



ХУУЛЬ ЗҮЙН ЯАМ



“ХУУЛЬ ЗҮЙН САЛБАРЫН  
ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ” ТӨСӨЛ

# ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙ

*Гарын авлага*

**Зөвлөх:**

А.Дугармаа

**Боловсруулсан:**

Б.Алтангэрэл

Р.Оюунбадам

*Энэхүү гарын авлагыг Хууль зүйн яамнаас хэрэгжүүлж буй  
Дэлхийн банкны “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах”  
төслийн хүрээнд боловсруулав.*

Улаанбаатар хот  
2013 он

DDC  
347.077  
III-978

## ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙ ГАРЫН АВЛАГА

### **ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН:**

А.Дугармаа  
С.Тэгшжаргал

### **ГАРЫН АВЛАГА БОЛОВСРУУЛСАН:**

#### **Зөвлөх:**

А.Дугармаа

#### **Багийн гишүүд:**

Б.Алтангэрэл  
Р.Оюунбадам

Хэвлэлийн хуудас: 16.6  
Цаасны хэмжээ: В5  
Хэвлэсэн тоо: 1200  
Хэвлэсэн газар: “BCI” Хэвлэлийн компани

ISBN 978-99962-56-83-7

© Энэхүү гарын авлага зохиогчийн эрхээр хамгаалагдсан тул  
зөвшөөрөлгүйгээр хэвлэн олшруулахыг хориглоно.



## ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛИЙН ОЮУТАН, БАГШ НАРТ



Монгол Улсын Засгийн газрын Хууль зүйн салбараа шинэчлэх санаачлагыг анхлан дэмжсэн хандивлагчдын тоонд Дэлхийн банк зүй ёсоор ордог билээ. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2002-2008 онуудад Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлсэн “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төслийн хүрээнд эрх зүйн шинэтгэлийн чухал хэсэг болох Эрх зүйн бакалаврын боловсролын агуулга, чанарыг олон улсын түвшинд нийцүүлж, сайжруулах ажлын эхлэл тавигдсан юм. Тухайлбал, “Эрх зүйн дээд боловсролын Монгол Улсын стандарт”-ын анхны хувилбар, түүний дагуу 31 хичээлийн жишиг хөтөлбөр, эдгээрээс 14 хичээлийн оюутанд зориулсан гарын авлага зэргийг боловсруулж, сургалтын арга барилыг шинэчлэхэд чиглэсэн ажлууд хийгдсэн. Эдгээр хөтөлбөр, гарын авлагыг 2007-2008 онд эрх зүйч бэлтгэдэг бүх их, дээд сургуулиудын оюутнуудын хүртээл болгосон.

2009 оноос Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж эхэлсэн “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд дээрх ажлын үргэлжлэл болох оюутанд зориулсан нийт 20 гаруй хичээлийн гарын авлага боловсруулах ажил хийгдэж байна. Энэ ажлыг хууль зүйн салбарын нэр хүндтэй, туршлагатай эрдэмтэд, багш нар болон идэвх, санаачлагатай залуу багш нараас бүрдсэн нийт 60 орчим хүний бүрэлдэхүүнтэй баг гүйцэтгэж байна.

*Төслийн зохицуулагч*

**БОЛЬХОРЛООГИЙН САРАНТУЯА**

## ҮР ДҮНД ЧИГЛЭСЭН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР



Боловсрол судлаачид болон багш нар сургалт явуулах үзэл баримтлалыг боловсруулахдаа хоёр янзын хандлагыг баримталж байна. Нэгдэх нь илүү уламжлалт хэлбэрийнх бөгөөд агуулгад чиглэсэн баримтлалыг дагадаг байхад хоёр дахь нь үр дүнд анхаардаг. Агуулгад чиглэсэн хандлагаар бол сургалтын агуулгыг тухайн шинжлэх ухааны мэдлэг, ойлголт тодорхойлдог. Харин үр дүнд чиглэсэн хандлага нь мэдлэгт анхаарахаас гадна суралцагчдын ур чадвар, хандлага үнэт зүйлсийн хөгжилд анхаардаг. 1990-ээд оноос хийсэн эрх зүйн шинэчлэлт нь хууль зүйн их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүйг шинэчлэх, боловсронгуй болгохыг шаардсан юм. Хууль зүйн яам, Дэлхийн банкны “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах” төслийн “Хууль зүйн бакалаврын боловсролыг дэмжих” дэд төслийн боловсруулсан сургалтын хөтөлбөр, гарын авлагын шинэлэг тал нь:

- Агуулгад суурилсан хөтөлбөрөөс агуулга, үр дүнд суурилсан хөтөлбөр боловсруулсан.
- Зорилго, хүрэх үр дүнг тодорхой болгосон.
- Онолын мэдлэгийг эзэмшүүлэхийг зорихоос гадна мэргэжлийн чадвар эзэмшүүлэх, үнэт зүйлсийн төлөвшилд нь нөлөөлөх зорилго тавьсанд оршино.

*Төслийн зөвлөх*

**УХНААГИЙН ТУЯА (Ph.D)**

### ЗОХИОГЧИД



#### **Авирмэдийн Дугармаа**

*МУИС-ийн ХЗС-ийн сургуулийн иргэний эрх зүйн тэнхимийн ахлах багш, докторант*

1984 онд ОХУ-ын Иваново хотын УИС-ийн хуулийн ангийг эрх зүйч, 1996 онд ТЗУХИ-ийн төрийн удирдлагын өдрийн анги. Төрийн удирдлагын менежерээр тус тус төгссөн. Иргэний эрх зүй, Компанийн эрх зүй, Хөдөлмөрийн эрх зүй, Гэр бүлийн эрх зүй, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн эрх зүйгээр мэргэшсэн. Энэ чиглэлээр олон тооны сурах бичиг, гарын авлага, өгүүлэл, нийтлэлийг дангаар болон бусадтай хамтран туурвиж олны хүртээл болгосны зэрэгцээ нилээд олон магистр, бакалаврын ажлыг удирдаж хамгаалуулсан. Эрх зүйч, МӨХ-ны гишүүн өмгөөлөгч, МҮХАУТ -ын дэргэдэх Үндэсний арбитрын арбитрч, МУИС-ийн ХЗС-ийн ахлах багш, МУИС-ийн докторант.



#### **Роломсүрэнгийн Оюунбадам**

*Шихихутуг хууль зүйн дээд сургуулийн багш*

1971 онд МУИС-ийг инженер-эдийн засагч, 1991 онд ОХУ Резань хотын ДЯЯ-ны сургуулийн эрх зүйн курс, 1997 онд Отгонтэнгэр ИС-ийн ХЗС-ийг эрх зүйч, 1999 онд МУИС-ийн ХЗС-ийг эрх зүйн магистраар тус тус суралцаж төгссөн. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад тасралтгүй 36 жил ажилласан, 2007 оноос Шихихутуг ХЗДС-д багшаар ажиллаж байгаа. МУИС-ийн ХЗС-ийн докторант. Хорих ял эдлүүлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой олон тооны сурах бичиг, гарын авлага, өгүүлэл, илтгэл дангаар болон бусадтай хамтран бичиж байсан.



#### **Баясгалангийн Алтангэрэл**

*Хууль Сахиулахын Их Сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн процессын эрх зүйн тэнхимийн эрхлэгч*

1996-2000 онд Цагдаагийн Академийг эрх зүйн бакалавр, 2002-2004 онд эрх зүйн магистр, 2008 оноос Хууль сахиулахын их сургуулийн докторантурын сургалтыг тус тус төгссөн. 2000 оноос Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Цагдаагийн Академийн ШШГ Эрх зүйн тэнхимд ажиллаж, улмаар одоо Хууль сахиулах их сургуулийн ШШГПроцессийн эрх зүйн тэнхимийн эрхлэгчээр ажиллаж байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй, Иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйгээр мэргэшин, судалгааны ажил хийдэг. Судалгааныхаа ажлын чиглэлээр гарын авлага 2, судалгааны өгүүлэл, илтгэл 10 гаруйг хэвлүүлсэн.



## ГАРЧИГ

<b>НЭГ. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙН ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР.....</b>	<b>8</b>
1. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙН ХИЧЭЭЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ .....	8
<b>ХОЁР. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙН ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА .....</b>	<b>14</b>
<b>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙН НИЙТЛЭГ АСУУДАЛ .....</b>	<b>14</b>
СЭДЭВ.1.1. ШШГЭЗҮЙН ЗОХИЦУУЛАХ ЗҮЙЛ, ЗОХИЦУУЛАЛТЫН АРГА, ЗАРЧИМ, ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦООНД ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ .....	14
СЭДЭВ 1.2. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙН ЭХ СУРВАЛЖ .....	20
СЭДЭВ.1.3. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦАА .....	23
СЭДЭВ.1.4. ШШГБ-ЫН ТОГТОЛЦОО, САНХҮҮЖИЛТ, ЧИГ ҮҮРЭГ, ТОЙРГИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ .....	30
<b>ХОЁРДУГААР БҮЛЭГ: ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ АЛБАДАН ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА.....</b>	<b>37</b>
СЭДЭВ.2.1. ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ АЛБАДАН ГҮЙЦЭТГЭХ НИЙТЛЭГ ЖУРАМ .....	37
СЭДЭВ.2.2 ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ АЛБАДАН ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ТӨРӨЛ .....	53
СЭДЭВ.2.3. ТӨЛБӨР ТӨЛӨГЧ ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭС ТӨЛБӨР ГАРГУУЛАХ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТ, ОНЦЛОГ, ТӨЛБӨР ГАРГУУЛАХ ДАРААЛАЛ .....	65
СЭДЭВ.2.4. ТОДОРХОЙ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭХИЙГ ДААЛГАСАН БОЛОН ГЭР БҮЛИЙН ХОЛБОГДОЛТОЙ ХЭРЭГ МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ АЛБАДАН ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА.....	73
<b>ГУРАВДУГААР БҮЛЭГ: ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААР ГАРСАН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА.....</b>	<b>80</b>
СЭДЭВ.3.1. ЭРҮҮГИЙН ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГАА, ЯЛЫН БОДЛОГО .....	80
СЭДЭВ.3.2. ХОРИХООС ӨӨР ТӨРЛИЙН ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГАА.....	85
СЭДЭВ.3.3. ШҮҮХИЙН ШИЙТГЭХ ТОГТООЛ ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ТӨРӨЛ, ХЭЛБЭР, ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА.....	93
СЭДЭВ.3.4. ХОРИХ БАЙГУУЛЛАГАД ЯЛТНЫГ ХҮЛЭЭН АВАХ, ЯЛТНЫ ХӨДӨЛМӨР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ БА ТЭДГЭЭРИЙН ЭРХИЙН БАЙДАЛ .....	98

# ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙ

ГАРЫН АВЛАГА

СЭДЭВ.3.5. ХОРИХ БАЙГУУЛЛАГАД ЯЛТНЫГ АНГИЛАН ХУВААРИЛАХ, ШИЛЖҮҮЛЭХ БОЛОН ЯЛТНЫ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ТҮҮНД ТАВИХ ХЯНАЛТ, ХАРУУЛ ХАМГААЛАЛТ .....	105
СЭДЭВ.3.6. ХОРИХ АНГИЙН ОЙЛГОЛТ, ЯЛ ЭДЛҮҮЛЭХ НӨХЦӨЛ, ЖУРАМ.....	110
СЭДЭВ.3.7. СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИЙГ ЦАГДАН ХОРИХ ТУХАЙ ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА.....	116
СЭДЭВ.3.8. ШҮҮХИЙН ТОГТООЛ ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ БУСАД БАЙГУУЛЛАГЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА.....	125
СЭДЭВ.3.9. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГАА,ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ БА НҮБ БОЛОН ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГААС ЯЛ ЭДЛҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ГАРГАСАН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА.....	133
СЭДЭВ.3.10. МОНГОЛ УЛСЫН ШШГБ ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА, ЭХ СУРВАЛЖ .....	144
ГУРАВ. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙ ХИЧЭЭЛИЙН ЗААХ АРГА, АРГАЧЛАЛ.....	148
ДӨРӨВ. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙ ХИЧЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ .....	151
V ХЭСЭГ. ХАВСРАЛТ .....	154



## ӨМНӨХ ҮГ

Хууль зүйн яамнаас Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд хууль зүйн их, дээд сургуулиудад судлах мэргэжлийн хэд хэдэн хичээлийн хөтөлбөр боловсруулан гаргасан ба тэдгээрийн тоонд Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн эрх зүйн хичээл багтаж байгаа болно. Тус хичээлийн хөтөлбөрийн агуулга нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн үндсэн асуудал, иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, тухайн хичээлийн заах арга зүйн асуудлыг тодорхой болгоход чиглэгдсэн болно.

Иймд шийдвэр гүйцэтгэх эрх зүйн тогтолцоо, тухайн хичээлийн хөтөлбөрийн агуулгын дагуу гарын авлагыг бичиж та бүхэнд хүргэж байгаадаа баяртай байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн гарын авлага нь хичээлийн хөтөлбөрт багтсан бүлэг, сэдвийг бүхэлд нь хамарсан ба сэдэв бүр сэдвийн зорилго, агуулга, нэр томъёоны тайлбар, тойм лекц мөн түүнчлэн мэдлэг шалгах хяналтын асуулт, бодлого, сорилоос бүрдэнэ. Хичээлийн хөтөлбөрийн дагуу сэдвийн хүрээнд судлах эрх зүйн эх сурвалж, ном, сурах бичиг, гарын авлагыг бүлэг тус бүрт нэрлэн заасан ба харин тухайн сэдвийн хүрээнд нэмэлт эх сурвалж шаардлагатай тохиолдолд сэдэв тус бүрт оруулж өгсөн болно.

Энэхүү гарын авлагыг судалснаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн онолын суурь мэдлэгийг эзэмшиж, иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, ял эдлүүлэх ажиллагааны мөн чанарыг танин мэдэж, онолын үүднээс дүгнэлт өгөх, шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх, ял эдлүүлэх ажиллагаанд хууль тогтоомжийг зөв хэрэглэх, холбогдох баримт бичгийг боловсруулах, аливаа маргаантай асуудлын учир холбогдлыг зөв тогтоон, шийдвэрлэх арга замыг олох илүү мэдлэг, чадвартай болно гэдэгт итгэлтэй байна.

Оюутан гарын авлагыг сургалт-танин мэдэхүйн болон эрдэм шинжилгээ судалгааны хэрэгцээнд ашиглаж болох бөгөөд сэдвийн зорилго, агуулгатай сайтар танилцсаны эцэст сэдвийн нэр томъёоны тайлбар, тойм лекцийг уншиж судлах нь илүү үр дүнтэй юм. Дараа нь хяналтын асуултанд хариулт өгч, бодлого, сорилыг гүйцэтгэж, мэдлэгээ шалгах боломжтой. Энэхүү гарын авлагад иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх, ял эдлүүлэх ажиллагаатай холбоотой бүхий л асуудлыг бүхэлд нь бүрэн төгс авч үзэх боломжгүй байсан учраас өгөгдсөн эх сурвалж, ном, сурах бичгийг нэг бүрчлэн дэлгэрэнгүй судлах шаардлагатай гэдгийг дурьдах нь зүйтэй гэж үзлээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн хичээлийн гарын авлагыг уншиж судалснаар шийдвэр гүйцэтгэх албадах ажиллагааны тогтолцоо, төрөл, онцлог, журам, эрх зүйн үр дагаврыг сайтар ойлгож, энэ талаар өөр өөрсдийн үзэл баримтлалтай болж, холбогдох хууль тогтоомжийг хэрэглэх, боловсронгуй болгоход санал дүгнэлтээ гаргах бүрэн чадвартай болно гэдэгт итгэлтэй байна.

Гарын авлагыг бэлтгэхэд бүх талын туслалцаа үзүүлсэн төслийн хамт олон болон багш нартаа талархал дэвшүүлж байна.

*МУИС-ийн ХЗС-ийн Иргэний эрх зүйн тэнхмийн ахлах багш докторант  
А. Дугармаа*

## НЭГ. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙН ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

### 1. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙН ХИЧЭЭЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

#### Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн хичээлийн танилцуулга

**Хичээлийн нэр:** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй (ШШГЭЗ)  
 Нийт цаг: 40 (Лекц -24 цаг, семинар -16 цаг)  
 Кредит цаг: 2  
 Индекс: CRLA 315  
 Семестр: VI улирал

**Заавал судалсан байх хичээл:** Үндсэн хуулийн эрх зүй, Иргэний эрх зүй, Гэр бүлийн эрх зүй, Хөдөлмөрийн эрх зүй, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, Захиргааны процессын эрх зүй, Эрүүгийн эрх зүй, Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй

Заавал судалсан байх хичээл		Үндэслэл
1.	Үндсэн хуулийн эрх зүй	Үндсэн хуулийн эрх зүй нь аливаа салбар эрх зүйн үндэс, эх сурвалж болдог учраас шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болж, заавал биелэгдэх зарчим хэрэгжих шийдвэр гүйцэтгэх эрх зүйн харилцаанд оролцогчид Үндсэн хуулиар баталгаажуулсан зарчмыг удирдлага болгоно.
2.	Иргэний эрх зүй	Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд иргэний эрх зүйн харилцаанаас үүдэлтэй маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхэд Иргэний эрх зүйн зохицуулалт шаардлагатай болно. Иймд Иргэний эрх зүйн хичээлийг судалсан байвал зохино.
3.	Гэр бүлийн эрх зүй	Гэрлэх нөхцөл журам, гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус амины харилцаа, хүүхэд үрчлэх, тэжээн тэтгэх, асран хамгаалах, харгалзан дэмжихтэй холбогдсон үйл ажиллагаа, хүнд нөхцөлд байгаа хүүхдийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг гэр бүлийн эрх зүйн хичээлээр судалдаг. Иймд эдгээр харилцаанаас үүдэлтэй маргааныг шийдвэрлээд гаргасан шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаанд гэр бүлийн эрх зүйн хэм хэмжээг хэрэглэнэ.



4.	Хөдөлмөрийн эрх зүй	Хөдөлмөрийн эрх зүй хичээлийг судалснаар тодорхой үүрэг гүйцэтгүүлэхийг даалгасан шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ач холбогдол, мөн чанарыг танин мэдэхэд суурь нь болж өгнө. Материаллаг эрх зүй, процессын эрх зүйн хоорондын харилцан хамаарал, үндсэн зарчмын уялдааг гүнзгий ойлгож, хэрэглэх чадвартай болохын тулд заавал урьдчилан судалсан байх ёстой.
5.	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй	Иргэний хэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны харилцан хамаарлын асуудлыг судлахын тулд энэ хичээлийг судалсан байвал зохино.

### **Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн хичээлийг судлах хэрэгцээ, шаардлага:**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй нь нийгэм, төрийн байгууламж, ялангуяа, иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг шүүхийн шийдвэрт заасны дагуу бодит байдлаар сэргээх, шүүх болон бусад эрх олгогдсон байгууллагаас гаргасан шийдвэрийг заавал гүйцэтгэх, хилсээр нэг ч хүнийг шийтгэхгүй байх зорилгын хүрээнд шүүх эрх мэдлийн гүйцэтгэлийг хэрэгжүүлэгч эрх зүйн тулгуур үндсийг тодорхойлсон бие даасан салбар эрх зүй мөн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, иргэний болон эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн үндэс, журмыг тогтоодог чухал арга хэрэгсэл учраас оюутун бүр бусдын зөрчигдсөн эрхийг сэргээх, хууль ёсны эрх ашиг, сонирхлыг хуулийн хүрээнд хамгаалахын тулд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг судлан зохих мэдлэгийг эзэмшсэн байх шаардлагатай.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн хичээл нь эрх зүйч мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэж буй хууль зүйн их, дээд сургуулиудын оюутнуудын хувьд заавал судлах мэргэжлийн хичээл бөгөөд үүнийг судлахгүйгээр прокурор, шүүгч, шийдвэр гүйцэтгэгч, өмгөөлөгч нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх боломжгүй юм. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь эрүүгийн болон иргэний журмаар хэргийг хянан шийдвэрлээд гарсан тогтоол, шийдвэрийг биелүүлэх болон ял эдлүүлэх нөхцөл, журмыг хэрэгжүүлдэг учраас бусдын эрх ашиг, сонирхлыг хамгаалах, эдгээр ажиллагааны талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх ажил хуульч болох бидний өмнө тулгарч байдаг. Нөгөөтэйгүүр энэхүү хичээлийг судалснаар оюутнууд цаашдын ажил мэргэжлийнхээ чиглэлийг зөв тогтоох, хуульчийн мэргэжлийн үүрэг, хариуцлагыг ухамсарлан, хууль зүйн аливаа асуудалд хүмүүнлэг, энэрэнгүй, шударга зарчмын үүднээс хууль, эрх зүйн ухамсрыг ямагт удирдлага болгодог хандлагыг төлөвшүүлнэ.

### **Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн хичээлийн зорилго**

Монгол улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн тухай ойлголт, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохицуулахад төрийн оролцох оролцоо, чиг үүрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйгээр зохицуулагдах харилцаа, түүний эрх зүйн зохицуулалт, шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн бусад салбар эрх зүйтэй холбоотой болон бусад салбар эрх зүйгээс ялгагдах онцлогийн тухай онол, практикийн мэдлэгийг эзэмшүүлэх, төрөөс шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар явуулж байгаа бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор хууль тогтоох байгууллагаас батлан гаргасан хууль тогтоомжийг онол практикийн үүднээс танин мэдэх, энэ асуудлыг эрхэлсэн байгууллагын үйл ажиллагаатай танилцах, нийгмийн амьдралд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бодитойгоор хэрэгжүүлэхэд оролцох чадвар эзэмшүүлэхийн зэрэгцээ аливаа шийдвэрийг биелүүлэх ажиллагаанд хуулиар зөвшөөрөгдсөн үзэл баримтлал, зарчмын үүднээс хандах дадлыг оюутанд төлөвшүүлэхэд оршино.

### **Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн хичээлийн зорилт:**

- Эрх зүйн тогтолцоонд шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн эзлэх байр суурь, гүйцэтгэх үүргийг тодорхойлох;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн ойлголт, мөн чанар, зохицуулах зүйл, зохицуулалтын арга, эрх зүйн бусад салбаруудаас ялгагдах болон төсөөтэй талыг тодорхойлох;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн түүхэн хөгжил, түүний үе шат, онцлогийг судалж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн үндсэн ойлголтуудыг уламжлал, шинэчлэлийн хүрээнд авч үзэх;
- Ял эдлүүлэх нөхцөл, журмын тухай ойлголт, үндсэн шинж, ангилалт, төрөл, хэмжээ болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйтэй холбоотой бусад асуудлуудын талаар онолын мэдлэг эзэмшүүлэх;
- Эрүүгийн болон иргэний журмаар гарсан шийтгэх тогтоол, шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл, журам тэдгээрийн онцлогийг судлах.

### **Энэ хичээлийн хүрээнд оюутан дараах мэдлэг олно. Үүнд:**

- Монгол улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн хичээлээр иргэний хэргийн талаар гарсан шийдвэрийг хүлээн авч, иргэн, хуулийн этгээдэд учирсан бодит хохирлыг хуулиар тогтоосон журмын дагуу барагдуулах;
- Шийдвэр гүйцэтгэгч болон тогтоол гүйцэтгэгч нар, бусад мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд хэрхэн хандах, харилцан холбоо;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцогчдын эрх зүйн байдал;
- Ял эдлүүлэх нөхцөл, журмыг хэрхэн хэрэгжүүлэх талаар суурь мэдлэгийг олгоно.



Оюутан дараах чадварыг эзэмшинэ. Үүнд:

- Онолын мэдлэгээ ашиглан практикт тохиолдсон аливаа асуудлыг тайлбарлан шийдвэр гаргах;
- Бодлого бодох, аливаа тогтоол, шийдвэрүүдийг гүйцэтгэх ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөхдөө онолын мэдлэгээ ашиглах;
- Бичиг баримт боловсруулах;
- Онолын мэдлэгээ практикт хэрэгжүүлэх арга замыг тодорхойлж, онол практикийн харилцан уялдаа, холбоо, практикт учирч буй бэрхшээлийг шийдвэрлэх арга замыг хуулийн хэм хэмжээг зөв хэрэглэж, тодорхойлох;
- Амаар болон бичгээр өөрийн үзэл бодлыг илэрхийлэх зэрэг чадвар эзэмшинэ.

**Оюутанд дараах хандлага тогтооход чиглэнэ. Үүнд:**

- Шүүхийн аливаа шийдвэр, тогтоолыг түргэн шуурхай гүйцэтгэх, эрх зүйн хариуцлага ногдуулах арга хэмжээг хуулийн хүрээнд гүйцэтгэх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцогчдын хууль ёсны эрх ашиг, сонирхлыг хамгаалах, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх үзлийг төлөвшүүлнэ.

### **Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө, цаг хуваарилалт**

№	Лекцийн хичээлийн сэдэв нэр	Цаг	№	Семинарын хичээлийн сэдвийн нэр	Цаг
	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн нийтлэг асуудал				
1	ШШГЭЗ-н зохицуулах зүйл зохицуулалтын арга, зарчим, эрх зүйн тогтолцоонд эзлэх байр суурь	4	1	ШШГЭЗ-н эх сурвалж	2
2	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн харилцаа	2	2	ШШГБ-ын тогтолцоо, санхүүжилт, чиг үүрэг, тойргийн тухай ойлголт, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдал	2
	Иргэний хэргийн шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаа				
3	Шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх нийтлэг журам	4	3	Албадах ажиллагааны төрөл (үзлэг нэгжлэг хийх, эд хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах, хураах, үнэлэх, худалдан борлуулах, эд хөрөнгийн мэдүүлэг авах, өртэй этгээдийн бүртгэл хөтлөх үндэслэл, журам)	2

# ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙ

ГАРЫН АВЛАГА

4	Төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааны тухай ойлголт, онцлог, төлбөр гаргуулах дараалал	2	4	Тодорхой үүрэг гүйцэтгүүлэхийг даалгасан шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаа	2
Эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа					
5	Эрүүгийн ял эдлүүлэх ажиллагаа, ялын бодлого	2	5	Шүүхийн тогтоол гүйцэтгэх ажиллагааны төрөл, хэлбэр, хорих ял эдлүүлэх байгууллага	2
6	Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа	2			
7	Хорих байгууллагад ялтныг хүлээн авах, ялтны хөдөлмөр зохион байгуулалт ба тэдгээрийн эрхийн байдал	2	6	Хорих ангид ялтныг ангилан хуваарилах, шилжүүлэх болон ялтны хөдөлмөр эрхлэлт, түүнд тавих хяналт харуул хамгаалалт	2
8	Хорих ангийн ойлголт, ял эдлүүлэх нөхцөл, журам	2			
9	Сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа	2	7	Шүүхийн тогтоол гүйцэтгэх ажиллагаанд оролцох бусад байгууллагын хамтын ажиллагаа	2
10	Гадаадын зарим улс орны ял эдлүүлэх ажиллагаа, түүний эрх зүйн зохицуулалт ба НҮБ болон ОУ-н байгууллагаас ял эдлүүлэх чиглэлээр гаргасан баримт бичгийн агуулга	2	8	МУ-ын ШШГБ болон ОУ-ын байгууллагуудын хамтын ажиллагаа, эх сурвалж	2
<b>Нийт</b>		<b>24</b>			<b>16</b>



## **Багшид тавих шаардлага:**

### ***Мэргэжлийн талаар:***

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн хичээлийг заах онол, арга зүйн өндөр мэдлэг чадвар, дадлага туршлагатай, сэтгэлгээний өргөн цар хүрээтэй, гадаад хэл дээр бичгэн орчуулга хийх чадвартай, компьютерийн програмууд дээр ажиллаж чаддаг, судалгааны ажлын зохих туршлагатай тухайн сургуулийн орон тооны багш байна.

### ***Заах арга зүйн хувьд:***

- ❖ Лекц унших, семинар болон оюутнуудын бие даалтын ажлыг удирдах арга зүйг эзэмшсэн байх;
- ❖ Хууль зүйн сургалт явуулах, заах арга зүйд гарч буй орчин үеийн хандлагын өөрчлөлтийг мэдэрч өөрийн заах арга зүйг боловсронгуй болгох, байнга шинэчлэх чин эрмэлзлэлтэй байх;
- ❖ Оюутны лекцээр олж авсан мэдээлэл болон бие даан эзэмшсэн мэдлэгт суурилан онолын мэдлэгийг бүтээх үйл явцыг удирдаж чаддаг байх;
- ❖ Багш, оюутнуудтай хамтран багаар ажиллах чадвартай байх;
- ❖ Мэдээлэл түгээх болон оролцооны идэвхтэй аргуудыг хэрэгжүүлэх зохих мэдлэг, дадалтай байх.

### ***Бусад шаардлага:***

- ❖ Сургалтын материалыг шинэлэг хэлбэрээр бэлтгэх, тэдгээрийг ашиглах аргыг оюутнуудад зааж сургах;
- ❖ Оюутнуудад зориулсан гарын авлагыг товч, тодорхой, энгийн хялбаршуулсан аргаар бэлтгэх;
- ❖ Орчин үеийн сургалтын техник, хэрэгслийг ашиглах чадвартай байх;
- ❖ Хичээлээр олсон мэдлэг, чадварыг үнэлэх зохистой шалгуурыг сонгон авч оюутанг бодитойгоор үнэлдэг байх;
- ❖ Харилцааны соёлтой, хуульчийн болон багшийн ёс зүйг чанд мөрддөг байх.

## ХОЁР. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙН ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙН НИЙТЛЭГ АСУУДАЛ

Бүлгийн зорилго: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй, түүний зохицуулалтын арга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зорилт, зарчим, тогтолцоо, үйлчлэх хэмжээ, хязгаарын талаар суурь мэдлэг олох, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хууль тогтоомжийн нийтлэг хэм хэмжээг хэрэглэх, эрүү, иргэний болон захиргааны хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх дадал, чадвар эзэмших, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хэм хэмжээг хэрэглэх бэлтгэлтэй болоход оршино.

#### СЭДЭВ.1.1. ШШГЭЗҮЙН ЗОХИЦУУЛАХ ЗҮЙЛ, ЗОХИЦУУЛАЛТЫН АРГА, ЗАРЧИМ, ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦООНД ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

##### *(Лекц 4 цаг)*

Сэдвийн зорилго: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн зохицуулах зүйл, зохицуулалтын арга, зарчмын талаар онолын мэдлэгтэй болсноор тухайн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдах нийгмийн харилцааны онцлог, мөн чанарыг бусад бие даасан салбар эрх зүйтэй харьцуулах, адил төстэй болон ялгагдах онцлог шинжийг тодорхой болгон, Монгол улсын эрх зүйн тогтолцоонд эзлэх байр суурийг тодорхойлоход оюутан бүр өөрийн үзэл баримтлалыг дэвшүүлэх чадвар эзэмшинэ.

##### **Сэдвийн агуулга:**

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн зохицуулах зүйл
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн зохицуулалтын арга
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн зарчмын тухай ойлголт, онцлог, ангилал
- Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд баримтлах зарчим
- Ял эдлүүлэх ажиллагаанд баримтлах зарчим
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн үүсэл, хөгжилт, нийгмийн хөгжлийн үе шатууд дахь түүний мөн чанар
- ШШГЭЗ-н ойлголт, түүний мөн чанар, шинж, чиг үүрэг
- ШШГЭЗ-н бусад салбар эрх зүйгээс ялгагдах онцлог
- Монгол улсын эрх зүйн тогтолцоонд ШШГЭЗ-н эзлэх байр суурь гүйцэтгэх үүрэг, ач холбогдол



- ШШГЭЗ нь бусад салбар эрх зүйтэй холбоотой болох нь
- ШШГЭЗ-н тогтолцооны ойлголт, ач холбогдол
- ШШГЭЗ-н ерөнхий, тусгай анги, тусгай хэсгийн ойлголт, тэдгээрийн уялдаа холбоо

### **Нэр томъёоны тайлбар:**

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн зохицуулах зүйл.** Шүүхээс гаргасан болон баталгаажуулсан шийдвэрийг гүйцэтгэх явцад үүссэн нийгмийн өвөрмөц харилцааг хэлэх ба эрүү, иргэн, захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх явцад үүсэн бий болно.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн зохицуулалтын арга.** Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх явцад үүссэн нийгмийн харилцааг зохицуулах зохицуулалтын арга хэрэгсэл бөгөөд сайн дураар (итгүүлэн үнэмшүүлэх) болон албадах аргыг хослуулан хэрэглэнэ.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй.** Шүүхээс гаргасан болон баталгаажуулсан бүхий л төрлийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааны нөхцөл, журмыг тогтоосон хэм хэмжээний нийлбэр гэж ойлгоно.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн зарчим.** ШШГЭЗ-н хэм хэмжээнд тусгалаа олсон, нийгэм улс төрийн бодлогод тулгуурлан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэхэд удирдлага болговол зохих үзэл баримтлал юм. ШШГЭЗ-н зарчим нь ерөнхий, салбар хоорондын, тусгай зарчим гэсэн төрөлтэй байна.

**Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа.** Хуулиар эрх олгогдсон байгууллага, албан тушаалтнаас иргэний хэргийн шүүхээс гаргасан болон баталгаажуулсан шийдвэрийг хуулиар тогтоосон нөхцөл, журмын хүрээнд гүйцэтгэж буй олон талт, хоорондоо холбоо бүхий ажиллагаануудыг хамарсан ойлголт юм.

**Ял эдлүүлэх ажиллагаа.** Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шүүхээс оногдуулсан эрүүгийн ялыг хуулиар тогтоосон нөхцөл журам, хяналтын хүрээнд албадан гүйцэтгэж буй төрийн албадлагын үйл ажиллагааг хэлнэ.

**ШШГЭЗ-н тогтолцоо.** ШШГЭЗ нь ерөнхий, тусгай анги, тусгай хэсгээс бүрдэх ба судлах зүйлээрээ хоорондоо ялгагдана.

### **Сэдвийн тойм**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй нь өөрийн гэсэн тусгай шинжүүдтэй байдаг. Эдгээр шинжид 1. Нийгмийн өвөрмөц харилцааг зохицуулах, 2. Ял эдлэгсэд, хоригдогч, төлбөр төлөгчдийн эрх, эрх чөлөөг зөвхөн хууль тогтоомжид зааснаар хязгаарлах, 3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа сайн дураар буюу хэвийн байдлаар хэрэгжээгүй тохиолдолд төрийн албадлага хэрэглэх байдлууд

хамаарагдана. Гэм буруутай нь тогтоогдсон этгээдэд оногдуулсан эрх зүйн хариуцлагын хэрэгжүүлэх явцад эрх зүйн өвөрмөц харилцаа үүсч, тэр нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдана.

Аливаа төрлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх явцад үүссэн нийгмийн өвөрмөц харилцааг бүрдүүлж байгаа гол хэсэг бол шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааны нөхцөл журам юм. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан төрөл бүрийн ялыг шүүх хэн нэгэн гэм буруутай этгээдэд оногдуулсан тохиолдолд чухам ямар нөхцөл журмыг баримтлан эдлүүлэхийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан эрхийн актуудад тусгасан байдаг.

Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй нь ял эдлүүлэх төрийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн болон ял эдлүүлэх ажиллагаанд мөрдөх нөхцөл, журам болон иргэний шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг тогтоосон хэм хэмжээнээс бүрдэнэ. Мөн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд оролцох төр, аж ахуй нэгж, байгууллага, олон нийтийн байгууллага, иргэдийн оролцооны зорилго, хэлбэрийг тогтооно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйд хамаарагдах олон асуудлууд төр, эрх зүйн онол дээр тулгуурлан хөгждөг. ШШГЭЗ-н ойлголт, шинжлэх ухаан, түүхэн хөгжилт, эх сурвалж, зарчим, харилцаа, хэм хэмжээний ойлголтууд нь төр, эрхийн онолд тулгуурлагддаг боловч шүүхийн шийдвэр гүйцэтгэх явцад үүссэн нийгмийн харилцааг зохицуулахтай холбогдсон өөрийн өвөрмөц онцлогтой.

ШШГЭЗ-н тогтолцоо буюу ерөнхий, тусгай ангийн олон асуудал эрүүгийн болон иргэний эрх зүйтэй харилцан холбоотойгоор хэрэгжин хөгжиж ирсэн уламжлалтай. ШШГЭЗ нь Иргэний эрх зүйтэй нилээд өргөн холбоотой байдаг. Иргэний хууль, ИХХШТХ-ийн заалт зөрчсөнтэй холбогдсон шийдвэрүүдийг шүүх гаргадаг ба түүний шийдвэрийг шийдвэр гүйцэтгэлийн албад, тэдгээрийн ажилтнууд биелүүлдэг байна. Энэ байдал нь 1. ШШГЭЗ, Иргэний эрх зүйн хоорондын заалт шууд утгаар, 2. Шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд олон хэлбэрээр холбогддог болохыг харуулж байна. Иргэний эрх зүйн гэрээ, хэлцэл, өмчлөлийн болон өв залгамжлах эрх, иргэн, хуулийн этгээдийн эрх зүйн эрхийн чадвар, чадамж зэргийг шийдвэр гүйцэтгэгч нар хэрхэн ойлгож хэрэгжүүлэх нь тэдний үйл ажиллагааны үр дүнд нөлөөлөх талтай. Ийм байдлаар дээр нэрлэсэн эрх зүй хоорондын холбоог дэлгэрүүлэн авч үзэж болно.

Монгол Улсын Хөдөлмөрийн эрх зүйгээр зохицуулагддаг иргэдийн хөдөлмөрлөх, цалин хөлс авах эрх, ажил, амралтын цаг зэрэг нь ялтанд нэгэн адил хамаарагдах боловч ял эдэлж байгаатай нь холбогдон онцлог байдлаар хэрэгжинэ. Харин Хөдөлмөрийн хуульд заасан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны арга техникийн тухай ойлголт нь ялтны хөдөлмөрт бүрэн хэмжээгээр нэгэн адил хэрэгжинэ. Хорихоос өөр төрлийн ял эдэлж байгаа ялтны хөдөлмөрийн нөхцөл нь Монгол Улсын Хөдөлмөрийн хууль тогтоомжоор тодорхойлогдох боловч зарим онцлог бий.



### **ЭБШЭЗ, ШШГЭЗ-н хоорондын харилцан хамаарлын гол илрэл нь:**

1. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны журмыг ЭБШЭЗ-гээр зохицуулдаг, 2.ШШГБ-ын тогтолцоонд хамаарах хорих ял эдлүүлэх байгууллага олон арван жилийн турш хэрэг бүртгэх ажиллагаа явуулж ирснээр тайлбарлагдана. Мөн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж хуулийн хүчин төгөлдөр болох ба тэдгээрийг биелүүлэх (ЭБШТХ-ийн 328, 329 дүгээр зүйлүүд), ялтныг хугацааны өмнө ялаас чөлөөлөх түүнчлэн ял эдлүүлэх дэглэмийг бууруулах, чангатгах зэрэг (ЭБШТХ-ийн 334 дүгээр зүйл) асуудлыг шүүх шийдвэрлэх боловч уг асуудалд холбогдох албан тодорхойлолтыг хорих байгууллага гаргаж хүргүүлдэг байна. Түүнчлэн ялтныг өвчний учир ялаас хугацааны өмнө чөлөөлөхөд ЭБШЭЗ-н холбогдох хэм хэмжээг дагаж мөрдөнө.

#### **ХЯНАЛТЫН АСУУЛТ:**

1. ШШГЭЗ-н зохицуулах зүйлийг тодорхойлно уу.
2. ШШГЭЗ-н зохицуулалтын арга ямар байх вэ?
3. ШШГЭЗ-н диспозитив аргын талаар хэлэлцэнэ үү.
4. ШШГЭЗ-н императив аргын талаар хэлэлцэнэ үү.
5. ШШГЭЗ-н урамшууллын аргын хэрэгжилтийг тодорхойлно уу.
6. ШШГЭЗ-н зарчмын ойлголт ямар байх вэ?
7. ШШГЭЗ-н зарчмыг хэрхэн ангилан авч үзэх вэ?
8. ШШГЭЗ-н ямар зарчим иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд хэрэгжих талаар ярилцана уу.
9. ШШГЭЗ-н ял эдлүүлэх ажиллагаанд хэрэгжих зарчим ямар байх талаар хэлэлцэнэ үү.
10. Монголын эрх зүйн тогтолцоонд ШШГЭЗ-н эзлэх байр суурийг тодорхойлно уу.
11. ШШГЭЗ-н чиг үүрэг, ач холбогдол гэсэн хоёр ойлголтын ялгагдах үндсэн шинжийг тодорхойлно уу.
12. ШШГЭЗ-н тогтолцоо (систем) ямар байх болон түүний ангиллыг нэрлэнэ үү.

### **Бодлого**

Сүхбаатар дүүргийн шүүх 2009 оны 03 дугаар сарын 05-ны өдөр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр торгох торгуулийн ялыг ногдуулжээ. Шийдвэр гүйцэтгэгч “Б” хуульд зааснаар шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулсан боловч 4 жилийн хугацаанд ялтан Д торгуулийн мөнгийг төлөөгүй байна. Тэрээр мөнгөгүй тул торгуулийн ялыг хэрэгсэхгүй болгож өгөөч гэсэн хүсэлтийг шийдвэр гүйцэтгэх албанд гаргажээ.

Энэ тохиолдолд:

1. Ялтан Д-ийн гаргасан хүсэлтийг хэрхэн шийдвэрлэх вэ?
2. Хэрэв шийдвэр гүйцэтгэгч Б уг хүсэлтээс татгалзсан үйлдэл тус бүрт хууль зүйн үүднээс дугнэлт гаргана уу.

## Сорил

1. Шүүхийн шийдвэр биелүүлэх үндэслэлийг тодорхойлно уу.
  - a. Шүүхийн хүчин төгөлдөр тогтоол, арбитрын шийдвэр
  - b. Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр тогтоол, хуульд заасан тохиолдолд бусад байгууллагын шүүхээр баталгаажуулсан шийдвэр
  - c. Шүүхийн хүчин төгөлдөр тогтоол, бусад байгууллагын шийдвэр
  - d. Шүүхийн хүчин төгөлдөр тогтоол
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны зарчмыг олно уу.
  - a. Хууль дээдлэх, хүний эрх чөлөө хууль ёсны эрх ашгийг хүндэтгэх, энэрэнгүй байх ардчиллын зарчимд үндэслэнэ
  - b. Хууль дээдлэх, хүний эрх чөлөө хууль ёсны эрх ашгийг хүндэтгэх, шуурхай энэрэнгүй байх зарчимд үндэслэнэ
  - c. Хүний эрх чөлөөг хамгаалах, хууль дээдлэх
  - d. Хууль дээдлэх, ардчилал, хүний эрхийг хамгаалах
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль тогтоомж:
  - a. Үндсэн хууль, ШШГТХ зэргээс бүрдэнэ
  - b. Үндсэн хууль, хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.
  - c. Үндсэн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ
  - d. Үндсэн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Эрүүгийн хууль зэргээс тус, тус бүрдэнэ.
4. Хорих ял эдлэгсэд урьд тогтоолгосон өндөр насны болон бусад тэтгэвэр, тэтгэмжээ үргэлжлүүлэн авч болох эсэх:
  - a. Болно
  - b. Болохгүй
  - c. Суллагдсаны дараа авах
  - d. Тэтгэвэр, тэтгэмж авах эрх түр түдгэлзэнэ
5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд ямар байгууллага хяналт тавих вэ?
  - a. УИХ, Засгийн газар
  - b. Хууль зүйн яам



- c. Хууль зүйн яам, Орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга  
d. Улсын Дээд Шүүх
6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь харьяаллын хувьд:
- Засгийн газарт
  - Шүүхэд
  - ШШГЕГ-т хамаарна.
  - Аль нь ч биш, бие даасан статустай
7. Хорих ял эдлүүлж буй нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд
- Хамаарахгүй
  - Хамаарна.
  - Хуульд заасан бол хамаарна
  - Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хамаарна.
8. Насанд хүрээгүй болон жирийн дэглэмтэй хорих ангийн ялтны ажил, амралтын цаг нь дараах хуульд нийцсэн байна
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
  - Хөдөлмөрийн хууль
  - Иргэний хууль
  - Хөдөлмөрийн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
9. Нотариатын мэдэгдэх хуудас шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах үндэслэл болох уу?
- Шүүхээс баталгаажуулсан, түүний үндсэн дээр гүйцэтгэх хуудас олгосон бол болно.
  - Шүүхээс баталгаажуулсан, харьяалагдах шүүхээс олгосон гүйцэтгэх хуудастай бол болно.
  - Огт болохгүй
  - Олон улсын гэрээнд заасан бол болно.
10. Хорих анги шинээр байгуулах, өөрчлөх, татан буулгах, байршлыг өөрчлөх асуудлыг:
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын саналыг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэнэ.
  - Ерөнхий сайд шийдвэрлэнэ.
  - Улсын Их Хурлын хуралдаанаар шийдвэрлэнэ.
  - Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.

## СЭДЭВ 1.2. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙН ЭХ СУРВАЛЖ

### (Семинар 2 цаг)

**Сэдвийн зорилго:** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн эх сурвалжийн талаар тодорхой мэдлэг эзэмшин, холбогдох эх сурвалжийг ашиглах чадвартай болно.

### Сэдвийн агуулга:

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн эх сурвалжийн ойлголт, онцлог
- ШШГЭЗүйн эх сурвалжийн төрөл, ангилалт,
- ШШГЭЗүйн эх сурвалж болох хууль, хууль тогтоомжууд
- Хуулийг хэрэглэх ба тайлбарлах нь
- Олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх

### Нэр томъёоны тайлбар:

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн эх сурвалж.** Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх явцад үүссэн нийгмийн харилцааг зохицуулах хууль тогтоомжийн агуулгаар илэрхийлэгддэг хэм хэмжээний илрэн гарах гадаад хэлбэр юм.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн хэм хэмжээ.** Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх явцад үүссэн нийгмийн өвөрмөц харилцааг зохицуулах зорилгоор, хууль тогтоох дээд байгууллага, бусад эрх бүхий байгууллагаас тогтоосон заавал дагаж мөрдөх зан үйлийн горим юм.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн хууль тогтоомж.** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. Монгол Улсын олон улсын гэрээнд өөр журам тогтоосон бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

**Олон улсын гэрээ.** Монгол Улс, Монгол Улсын Их Хурал болон Монгол Улсын Засгийн газраас гадаадын нэг буюу хэд хэдэн улс, тэдгээрийн Засгийн газар, олон улсын байгууллагатай тодорхой асуудлаар харилцан эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлон тогтоосон, олон улсын эрх зүйгээр зохицуулагдах хоёр буюу олон талын бичгээр үйлдсэн тохиролцоог хэлнэ.

### Сэдвийн тойм

Эрх зүйн эх сурвалж гэдэг нь тухайн улс оронд үйлчилж байгаа эрх зүйн хэм хэмжээг бэхжүүлэх (түүнчлэн өөрчлөх буюу халах) ба илэрхийлэх албан ёсны хэлбэр мөн. Эрүү, Иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг биелүүлэх, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэгжүүлэх явцад үүссэн нийгмийн



харилцааг зохицуулах хууль тогтоомжийн агуулгаар илэрхийлэгддэг хэм хэмжээний цогцолборыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн эх сурвалж гэнэ. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн эх сурвалжид хамаарагдах хууль тогтоомжийг үйлчлэх хүрээ, нийгмийн тодорхой харилцааг зохицуулах хэм хэмжээгээр нь нэгд хууль, хоёрт хууль тогтоомжийн бусад акт гэж ангилна.

ШШГЭЗ-н эх сурвалжид хамаарагдах хуулиудыг дотор нь түгээмэл эх сурвалж, үндсэн эх сурвалж, бусад эх сурвалжид хамаарагдах гэж ангилан хуваана.

ШШГЭЗ-н түгээмэл эх сурвалжид Монгол Улсын Үндсэн хууль хамаарагдана. Монгол Улсын Үндсэн хууль бол Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хууль тогтоомжийн удиртгал хэсэг болдог. Энэ нь Эрүүгийн ял эдлүүлэх байгууллага, ялангуяа Тогтоол гүйцэтгэх байгууллага нь эрх зүйн өвөрмөц зохицуулалт шаардсан олон талт үйл ажиллагаа явуулдагтай холбоотой. Өөрөөр хэлбэл Монгол Улсын Үндсэн хуульд заасан төр, олон нийтийн байгууллагын чиг үүрэг, иргэний нийтлэг эрх, үүрэг, түүнчлэн хүний эрх, эрх чөлөөнд холбогдох багц асуудлууд бүгд ял эдлэх, эдлүүлэх, ажиллагаанд ямар нэг хэмжээгээр хамаарагддаг.

ШШГЭЗ-н үндсэн эх сурвалжид хамаарагдах хуульд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль орно. Энэ хуулиар Монгол Улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, ажилтны эрх зүйн баталгаа, төр олон нийтийн бусад байгууллага, хүмүүстэй хамтран ажиллах хэлбэр, түүнчлэн бүх төрлийн ял эдлүүлэх болон цагдан хорих ажиллагааны нөхцөл журам, ял эдлэхээс суллах, тэнсэн харгалзах байдал зэргийн эрх зүйн үндсийг бүхэлд нь хуульчлан баталгаажуулсан байна.

#### ХЯНАЛТЫН АСУУЛТ:

1. Үе үеийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой хуулиудын онцлог зохицуулалтууд нь тухайн үеийн нийгэм, улс төрийн нөхцөл байдалтай хэрхэн уялдаж байсныг түүхэн баримт, жишээтэйгээр тайлбарлана уу?
2. Дээрх хуулиудын адил болон онцлог талуудыг харьцуулна уу.

#### Бодлого

Шүүхийн шийтгэх тогтоолоор ялтан “Д”-д хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 350 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний торгох ял оногдуулжээ. Ялтан “Д” нь тодорхой оршин суух хаяггүй, өөрийн нэр дээр өмчлөлийн эд хөрөнгөгүй. Хэдийгээр “Д” ажил эрхэлдэг боловч шийдвэр гүйцэтгэгчид энэ талаар мэдэгдээгүй байна. Шийдвэр гүйцэтгэгч ялтны энэхүү байдлыг тодруулсаны эцэст гүйцэтгэх баримт бичгийг түдгэлзүүлжээ. Ингэхдээ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-д “төлбөр гаргуулж болох эд хөрөнгө, эсхүл орлого байхгүй

бөгөөд хуульд заасан аргаар түүний эд хөрөнгө, эсхүл орлогыг албадан гаргах боломжгүй бол эд хөрөнгөтэй болтол” түдгэлзүүлнэ гэж заасныг удирдлага болгожээ.

1. Ялтны эд хөрөнгөгүй байдал нь түдгэлзүүлэх үндэслэл болох уу?
2. Торгох ялыг өөр төрлийн ялаар сольж болох уу?

### Сорил

1. Сахилгын байранд хоригдсон, тусгаарлах тасалгаанд шилжсэн ялтны ээлжит болон урт хугацааны уулзалтыг хасах эсэх:
  - a. Бүхэлд нь хасна
  - b. Аль аль тохиолдолд нь хасахгүй
  - c. Зохих хугацааг багасгаж хасна
  - d. Зөвхөн ээлжит уулзалтыг хасна
2. Сахилгын нэг зөрчил гаргасан ялтанд хуульд заасан шийтгэлийн төрлийг давхар оногдуулж болох эсэх
  - a. Болно
  - b. Болохгүй
  - c. Хэд хэдэн шийтгэлийг давхардуулж болно
  - d. Зөвхөн нэг шийтгэлийг давхардуулж болно.
3. Сахилгын байранд хорьсон, тусгаарлах тасалгаанд шилжүүлсэн ялтны эрүүл мэндэд хэн хяналт тавих
  - a. Эмч
  - b. Харуулын хянагч
  - c. Жижүүрийн офицер
  - d. Нийгмийн ажилтан
4. Хоригдлын хөдөлмөрийн норм, хөлсний үнэлгээг аль байгууллагаас тогтоох
  - a. Хууль зүйн яам
  - b. ШШГЕГ
  - c. Тогтоол гүйцэтгэх газар
  - d. Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
5. Хорих байгууллагын албан хаагчаар ажилтан авч ажиллуулах шалгуур үзүүлэлт ямар байх вэ?
  - a. 18 насанд хүрсэн, ял шийтгэлгүй, мэргэжлийн зохих сургалтад хамрагдсан Монгол Улсын иргэн
  - b. 20 насанд хүрсэн Монгол Улсын иргэн
  - c. Дээд боловсрол эзэмшсэн Монгол Улсын иргэн
  - d. Хорин насанд хүрсэн, мэргэжлийн зохих сургалтад хамрагдсан иргэн



### СЭДЭВ.1.3. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦАА

#### **(Лекц 2 цаг)**

Сэдвийн зорилго: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн харилцааны ойлголт, түүний бүтцэд хамаарах субъект, объект, агуулгын талаар онол, практикын мэдлэгтэй болох улмаар энэ харилцааг бусад адил төрлийн харилцаанаас ялган зааглах, шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцогчдын эрх, үүргийг хуульд зааснаар хэрэгжүүлэх чадвартай болно.

#### **Сэдвийн агуулга:**

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн харилцааны ойлголт, онцлог шинж
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн харилцааны бүтэц
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн харилцаа үүсэж, өөрчлөгдөж, дуусгавар болох хууль зүйн факт
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн харилцааны субъектын чадвар, чадамж, ангилал
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, түүний чиг үүрэг
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны эрх зүйн байдал, ангилал
- Хорих ангийн албан хаагчийн эрх зүйн байдал
- Шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдал
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудын эрх зүйн байдал: (төлбөр авагч, төлбөр төлөгч)
- Ялтны эдлэх эрх, хүлээх үүрэг
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн эрх зүйн харилцаанд шүүх оролцох эрх зүйн зохицуулалт
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаан дахь Прокурорын хяналт
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд төлөөлөгч, өмгөөлөгч оролцох нь
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд гуравдагч этгээд оролцох нь
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд шинжээч оролцох нь
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд орчуулагч, хэлмэрч оролцох нь
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хөндлөнгийн гэрч оролцох нь

### Нэр томъёоны тайлбар

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн харилцаа.** Шүүхээс гаргасан болон баталгаажуулсан шийдвэрийг гүйцэтгэх явцад төрийн эрх бүхий байгууллага, шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх гэм буруутай этгээд болон бусад этгээдийн хооронд үүссэн, шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдах нийгмийн өвөрмөц харилцааг хэлнэ.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн харилцааны бүтэц.** ШШГЭЗ-н харилцааны бүтэц нь нэр томъёоны хувьд бусад эрх зүйн харилцааны нэгэн адил субъект, эрх зүйн харилцааны агуулга, объектоос бүрдэнэ.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн харилцааны субъект.** ШШГЭЗ-ийн харилцааны субъект буюу оролцогчид гэдэг ойлголтод хуулиар тогтоосон эрх эдэлж, үүрэг хүлээсэн хуулийн этгээд, эрхийн чадамжтай иргэн хамаарна.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн харилцааны объект.** ШШГЭЗ-н харилцаанд оролцогч субъектүүдээс бүх төрлийн ял эдлэх, эдлүүлэх, цагдан хорих явцад үйлчлэх хууль тогтоомжид заасан эрхээ эдэлж, үүргээ биелүүлэхтэй холбогдуулан бодитойгоор хийж буй үйлдэл (эс үйлдэл) нь уг харилцааны объект болдог.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн харилцааны агуулга.** ШШГЭЗ нь салбар эрх зүй болохын хувьд бусад эрх зүйн нэгэн адил өөрийн харилцааны агуулгатай байдаг. ШШГЭЗ-н харилцааны агуулга нь бүх төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд оролцогч субъектүүдийн бодит зан үйл, тэдэнд хуулиар олгогдсон эрх, үүргийн нэгдлийг илэрхийлнэ.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага.** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь иргэний болон эрүүгийн, захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх үүрэг бүхий төрийн байгууллага мөн.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан.** Шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан нь шийдвэр гүйцэтгэгч болон хорих байгууллагын албан хаагчаас бүрдэнэ.

**Хорих ангийн албан хаагч.** Хорих байгууллагын албан хаагч нь 18 насанд хүрсэн, ял шийтгэлгүй, зохих мэргэжлийн сургалтад хамрагдсан Монгол Улсын иргэн байх ба хорих байгууллагад албан хаагч, хорих ангийн дарга ажиллана.

**Шийдвэр гүйцэтгэгч.** Шийдвэр гүйцэтгэх байгууллагын нэрийн өмнөөс шийдвэр гүйцэтгэх ажиллагааг гардан хэрэгжүүлэгч юм. Шийдвэр гүйцэтгэгч ял шийтгэлгүй, шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтанд тэнцсэн Монгол Улсын иргэн байна.

**Ахлах шийдвэр гүйцэтгэгч.** Шийдвэр гүйцэтгэх албанд ахлах шийдвэр гүйцэтгэгч ажиллах бөгөөд улсын байцаагчийн эрхтэй байна.



**Ерөнхий гүйцэтгэгч.** Шийдвэр гүйцэтгэх газрын дарга нь Улсын ерөнхий шийдвэр гүйцэтгэгч байх бөгөөд улсын байцаагчийн эрхтэй байна.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд.** Төлбөр төлөгч, төлбөр авагчийг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд гэнэ.

**Төлбөр авагч.** Төлбөр авагч гэж хуульд заасан эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзэж түүнийг сэргээх, хамгаалахаар гүйцэтгэх баримт бичигт заасан иргэн, хуулийн этгээдийг хэлнэ.

**Төлбөр төлөгч.** Төлбөр төлөгч гэж төлбөр авагчийн эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг зөрчсөн буюу үүргээ биелүүлээгүй гэж гүйцэтгэх баримт бичигт заасан иргэн, хуулийн этгээдийг хэлнэ.

**Эрх залгамжлагч.** Талуудын аль нэг нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас гарсан (сураггүй алга болсон, нас барсан, хуулийн этгээд татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан, шаардлага ба үүргээ бусдад шилжүүлсэн) бол төлбөр авагч, төлбөр төлөгчийн хүсэлтээр эрх залгамжлагч оролцоно.

**Ялтан.** Гэмт хэрэг үйлдэн шүүхийн таслан шийтгэх тогтоолын дагуу ял эдэлж байгаа этгээдийг хэлнэ.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаан дахь прокурорын хяналт.** Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар прокурор нь ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавина.

**Төлөөлөгч.** Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд иргэн өөрийн биеэр, эсхүл хуульд зааснаар, сайн дураар буюу гэрээгээр гэсэн хэлбэртэй төлөөлөгчөөрөө дамжуулан оролцоно.

**Өмгөөлөгч.** Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад талуудын эрх ашгийг хуульд заасан журмын хүрээнд хамгаалж байгаа, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээд юм.

**Гуравдагч этгээд.** Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад эрх ашиг, сонирхол нь хөндөгдсөн бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцож болно.

**Шинжээч.** Тусгай мэдлэг эзэмшсэн мэргэжлийн байгууллага, эсхүл тухайн чиглэлээр мэргэжил эзэмшиж мэргэшсэн, уг хэргийн талаар хувийн болон албаны сонирхолгүй, эрх бүхий байгууллагаас томилогдсон этгээд байна.

**Орчуулагч.** Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцогч нь монгол хэл мэддэггүй, бол тухайн хэлний чиглэлээр орчуулагч авч болно.

**Хэлмэрч.** Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогч хэлгүй, дүлий бол хэлмэрч авч болно.

**Хөндлөнгийн гэрч.** Төлбөр төлөгчийн орон байр, эд хөрөнгө байгаа газарт нэвтрэх, эд хөрөнгөд үзлэг, нэгжлэг хийх, түүнийг хураан авах зэрэг шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд иргэний эрх зүйн бүрэн чадамжтай, тухайн шийдвэр

гүйцэтгэх ажиллагааны талаар хувийн сонирхолгүй, түүнчлэн өөр хоорондоо болон шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бусад оролцогчтой төрөл, садангийн, эсхүл захирах захирагдах ёсны холбоогүй хоёроос доошгүй хөндлөнгийн гэрчийн оролцоотой явуулна.

### Сэдвийн тойм

Эрх зүйн харилцаа бодитойгоор оршин тогтноход нэг талаас тухайн нийгмийн харилцаанд үндэслэгдсэн бодит харилцаа өөрөө бий болсон байх, нөгөө талаас бодит харилцааг зохицуулдаг бие даасан эрх зүйн хэм хэмжээ батлагдан гарсан байх хоёр нөхцөл шаардагддаг байна.

ШШГЭЗ-н харилцаа бол нийгмийн амьдралд оршин тогтнох олон харилцааны нэг өвөрмөц төрөл юм. Өвөрмөц гэдгийн учир бол энэ харилцаанд нэг талаас төр, түүнийг төлөөлсөн байгууллага, нөгөө талаас бүх төрлийн ял эдлэж байгаа ялтан, төлбөр төлөгч, төлбөр авагч, мөн түүнчлэн эрх ашиг, сонирхол нь хөндөгдсөн гуравдагч этгээд оролцдог байдлаар тайлбарлагдана.

ШШГЭЗ-н харилцаа нь эрх зүйн харилцааны нийтлэг шинжийг агуулсан байдаг. Энэ нь :

1. Нийгмийн гишүүдийн хүсэл зорилгыг илэрхийлдэг;
2. Улс төрийн харилцааны нэг өвөрмөц төрөл болдог;
3. Зөвхөн эрх зүйн хэм хэмжээ үйлчилснээр үүсч бий болдог;
4. Субъектүүдийн хоорондох эрх, үүргийн нэгдлийг хангадаг;
5. Эрх зүйн харилцаа нь хэрэгжих явцдаа ухамсарлуулан итгүүлэх, төрийн албадлага хэрэглэх аргыг хослуулдаг байна.

Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан төрөл бүрийн ялыг эдлэх, эдлүүлэх явцад төр, түүнийг төлөөлсөн байгууллага, ял эдлэгсэд, тэдний хүрээлэлд багтах субъектүүдийн хооронд үүссэн нийгмийн өвөрмөц харилцааг ШШГЭЗ-н харилцаа гэнэ.

ШШГЭЗ-н харилцааны бүтэц нь нэр томъёоны хувьд бусад эрх зүйн харилцааны нэгэн адил а) субъект, б) эрх зүйн харилцааны агуулга, в) мөн харилцааны объектоос бүрдэнэ. Хэдийгээр эдгээр нь хоорондоо уялдаа холбоотой байх боловч, агуулга нь бусад эрх зүйн харилцааны бүтцээс ялгаатай байдаг.

Аливаа эрх зүйн харилцааны субъект буюу оролцогчид гэдэг ойлголтод хуулиар тогтоосон эрх эдэлж, үүрэг хүлээсэн хуулийн этгээд, эрхийн чадамжтай иргэд хамаарна.

ШШГЭЗ нь салбар эрх зүй болохын хувьд бусад эрх зүйн нэгэн адил өөрийн харилцааны агуулгатай байдаг. ШШГЭЗ-н харилцааны агуулга нь бүх төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд оролцогч субъектүүдийн бодит зан үйл, тэдэнд хуулиар



олгогдсон эрх, үүргийн нэгдлийг илэрхийлнэ. Мөн түүнчлэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бусад талуудын эрх, үүргийн нэгдлээр энэ харилцааны агуулгыг илэрхийлж болно.

**Объект:** ШШГЭЗ-н харилцаанд оролцогч субъектүүдээс шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон бүх төрлийн ял эдлэх, эдлүүлэх, цагдан хоригдох явцад үйлчлэх хууль тогтоомжид заасан эрхээ эдэлж, үүргээ биелүүлэхтэй холбогдуулан бодитойгоор хийж буй үйлдэл (эс үйлдэл) нь уг харилцааны объект болдог.

### ХЯНАЛТЫН АСУУЛТ:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн харилцаа гэдгийг тодорхойлно уу.
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн харилцааны онцлог шинжийг нэрлэнэ үү.
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн харилцааны бүтцэд юуг хамааруулан судлах талаар хэлэлцэнэ үү.
4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн харилцааны субъект гэдгийг тайлбарлана уу.
5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн харилцаа үүсэж, өөрчлөгдөж дуусгавар болох онцлог хууль зүйн фактыг нэрлэнэ үү.
6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн эрх зүйн харилцааны субъектын чадвар ямар байх вэ.
7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн эрх зүйн харилцааны субъектын чадамж ямар байхыг тодорхой жишээ авч тайлбарлана уу.
8. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн эрх зүйн харилцааны субъектын ангилал ямар байх вэ?
9. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын бүтэц, зохион байгуулалт ямар байх талаар авч үзэж тайлбарлана уу.
10. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын чиг үүргийг нэрлэнэ үү.
11. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны эрх зүйн байдал ямар байх вэ?
12. Хорих ангийн албан хаагчийн бүрэн эрхээс нэрлэнэ үү.
13. Шийдвэр гүйцэтгэгчийн эрх, үүрэг ямар байх вэ?
14. Шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанаас татгалзан гарч болох уу?
15. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудыг нэрлэнэ үү.
16. Төлбөр төлөгч гэдгийг тодорхойлно уу.
17. Төлбөр авагч гэдгийг хэрхэн тодорхойлох вэ? Түүний эрх, үүргийг нэрлэнэ үү.
18. Төлбөр төлөгчийн эрх, үүрэг ямар байх талаар хэлэлцүүлэг явуулна уу.
19. Ялтны эдлэх эрх, хүлээх үүрэг ямар байх вэ?

20. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн эрх зүйн харилцаанд шүүх хэрхэн оролцох вэ?
21. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаан дахь Прокурорын хяналт ямар байх вэ?
22. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд төлөөлөгч, өмгөөлөгч оролцох үндэслэл, журам ямар байх вэ?
23. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд гуравдагч этгээд оролцох уу? Түүний эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлно уу.
24. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд шинжээч оролцох журам ямар байх вэ?
25. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд орчуулагч, хэлмэрч оролцохдоо ямар эрх, үүрэгтэй байх вэ?
26. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хөндлөнгийн гэрч оролцох боломжтой эсэхэд дүгнэлт хийнэ үү?

## **Бодлого**

Ялтан Б.Сүх хуулийн хугацаанд торгуулийн мөнгөө төлөөгүй тул шүүгч шийтгэх тогтоолыг харьяаллын дагуу ялтны оршин суугаа Чингэлтэй дүүргийн шийдвэр гүйцэтгэх албанд хүргүүлсэн байна.

Шийдвэр гүйцэтгэгч Ж.Оюун шүүхийн шийдвэрийг хүлээн аваад, ялтан Сүхэд 14 хоногийн дотор торгуулийн мөнгийг шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд тушаах, уг хугацаанд төлөөгүй бол ялыг албадан гүйцэтгэх тухай мэдэгдэх хуудас гардуулжээ.

Ялтан Б.Сүх торгуулийн мөнгийг мэдэгдэлд заасан хугацаанд төлөх бололцоогүй тухайгаа дурьдсан өргөдөл ирүүлж, төлөх хугацааг сунгаж өгөхийг хүсчээ.

Энэ тохиолдолд:

1. Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөх хугацааг ямар хугацаагаар хойшлуулах санал тавих эрхтэй вэ?
2. Шийдвэр гүйцэтгэгч саналаа хаана гаргах ёстой вэ?



## Сорил

1. Жирийн дэглэмтэй хорих ангийн ялтны телефон ашиглах зардлыг хаанаас гаргах вэ?
  - a. Ялтан өөрөө
  - b. Тогтоол гүйцэтгэх газар
  - c. Тухайн хорих анги
  - d. Халамжийн байгууллага
2. Хорих ял эдлэгсдийн шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих зардлыг хаанаас гаргах вэ?
  - a. Хорих анги
  - b. Ялтан өөрөө
  - c. Тогтоол гүйцэтгэх газар
  - d. Буяны болон халамжийн байгууллага
3. Гадаад улсын харьяат ялтан өөрийн орны дипломат төлөөлөгчдийн газрын ажилтантай уулзах эрхтэй юу?
  - a. Эрхгүй
  - b. Уулзах эрхтэй
  - c. Тогтоол гүйцэтгэх газрын зөвшөөрлөөр
  - d. Прокурорын байгууллагын зөвшөөрлөөр
4. МУ-ын Ерөнхийлөгчөөс ялтанд уучлал үзүүлсэн эсэх тухай хариуг аль байгууллагаар дамжуулан өгөх вэ?
  - a. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
  - b. Тогтоол гүйцэтгэх газар
  - c. Хууль зүй дотоод хэргийн яам
  - d. Улсын дээд шүүх
5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан төрийн төлөөлөгч мөн үү?
  - a. Тийм
  - b. Үгүй
  - c. Төрийн үйлчилгээний ажилтан
  - d. Төрийн захиргааны албан хаагч

## СЭДЭВ.1.4. ШШГБ-ЫН ТОГТОЛЦОО, САНХҮҮЖИЛТ, ЧИГ ҮҮРЭГ, ТОЙРГИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

### (Семинар 2 цаг)

Сэдвийн зорилго: Хууль ёсыг сахиулах, нийгэмд эрх зүйн дэг журам тогтооход ШШГБ-ын гүйцэтгэх үүрэг, тус байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийн талаархи онолын мэдлэгтэй болох улмаар цаашид шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллах дадлага, чадварыг эзэмшүүлэхэд оршино.

### Сэдвийн агуулга:

- ШШГБ-ын бүтэц, тогтолцоо
- ШШГБ-ын үйл ажиллагааны чиг үүрэг
- ШШГБ-ын үйл ажиллагааны санхүүжилт
- Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тойрог
- Шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдал

### Нэр томъёоны тайлбар

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага.** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь иргэний болон эрүүгийн хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх үүрэг бүхий төрийн байгууллага мөн.

**Тогтоол гүйцэтгэх газар.** Эрүүгийн хэргийн талаарх шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх газар буюу Тогтоол гүйцэтгэх газар.

**Шийдвэр гүйцэтгэх газар.** Иргэний хэргийн талаархи шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх газар буюу Шийдвэр гүйцэтгэх газар.

**Шийдвэр гүйцэтгэгч.** Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг гардан хэрэгжүүлэгч, Шийдвэр гүйцэтгэгч ялшигч элгүй, шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтаар тэнцсэн Монгол Улсын иргэн байна.

**Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны тойрог.** Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг хэрэгжүүлэх анхан шатны нэгж болох орон нутгийн харьяаллыг хэлнэ.

### Сэдвийн тойм

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хорих ангийг удирдах газарт нэгтгэн хорих болон баривчлах ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол, эрүү, иргэний хэргийн холбогдолтой эд хөрөнгө гаргуулах, торгох, албадан ажил хийлгэх, ял оногдуулсан шүүхийн тогтоол, шийдвэрийг гүйцэтгэх чиг үүрэгтэй Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг мөн. Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх байгууллага нь



иргэний болон эрүүгийн хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх үүрэг бүхий төрийн тусгай алба бөгөөд нутаг дэвсгэрийн болон ажил үүргийн зарчмаар зохион байгуулагдана. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, хорих байгууллага, аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанаас бүрдэнэ. ШШГЕГ-т Иргэний хэргийн талаар шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх Шийдвэр гүйцэтгэх газар, эрүүгийн хэргийн талаарх шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх Тогтоол гүйцэтгэх газар тус тус харьяалагдана.

Хууль зүй дотоод хэргийн сайдын 2002 оны 05-р сарын 23-ны өдрийн 118 тоот тушаалаар аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэлийн албыг тойргийн журмаар зохион байгуулахаар шийдвэрлэсэн байна. Энэ тушаалын хавсралтад зааснаар улсын хэмжээнд 167 тойрог, түүнээс 112 нь аймгуудад, 55 нь нийслэл хотод ажиллаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газар нь дараах чиг үүргийг гүйцэтгэнэ.

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын боловсон хүчний бодлого боловсруулах, албан хаагчийг сургаж бэлтгэх, тэдний мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтныг албан тушаалд томилох, чөлөөлөх, халах, тэдгээрт цэргийн цол олгох, Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 19 дүгээр зүүлийн 19.5 дэх хэсгийн 4.5 дах заалтад заасан үндэслэлээр цол бууруулах, хураан авах асуудлыг шийдвэрлэх;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд дагаж мөрдөх журмыг энэ хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн батлах, биелэлтийг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;
- Шийдвэр гүйцэтгэх байгууллагыг зэвсэг техник, тусгай хэрэгсэл, хувцас бусад материалаар хангах бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх;
- Шийдвэр гүйцэтгэх байгууллагыг төлөөлж дотоод, гадаадын байгууллагатай харилцах чиг үүргийг хүлээнэ.

### **Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь:**

- Аймаг нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албыг мэргэжлийн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд хяналт тавих;
- Албадан ажил хийлгэх ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх;
- Шүүхийн зарим төрлийн шийдвэрийг бусад байгууллагаас гүйцэтгэх үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, энэ талаар нэгдсэн тоо бүртгэл хөтөлж, хяналт тавих;
- Аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны талаар гарсан гомдлыг шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Эдгээрээс гадна аймаг, нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын чиг үүрэг, тогтоол гүйцэтгэх газар, баривчлах, хорих ял эдлүүлэх талаар хорих байгууллагын шийдвэр гүйцэтгэх чиг үүрэг зэрэг хамаарна. Эдгээр нь тус бүртээ хуульд заасны дагуу тодорхой чиг үүргийг гүйцэтгэнэ.

Шийдвэр гүйцэтгэх байгууллагын тусгай албан тушаалтныг хоёр төрөлд ангилна. Үүнд:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч: Энэ нь улсын ерөнхий гүйцэтгэгч, ахлах гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгчээс бүрдэнэ.
2. Хорих байгууллагын ажилтан, офицер, ахлагч, хянагч зэрэг шийдвэр гүйцэтгэгчийн болон хорих ангийн дарга, алба хаагчдын бүрэн эрх, чиг үүргийн ялгаагаар төрөл, ангилалд хуваагдах боловч, шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан нь төрийн тусгай албан тушаалтанд хамаарна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч эрх хэмжээний хувьд харилцан адилгүй бүрэн эрхийг эдэлнэ. Үүнд :

- Улсын ерөнхий шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэх газрын дарга байх бөгөөд улсын байцаагчийн эрхтэй. Улсын ерөнхий шийдвэр гүйцэтгэгч нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 133.2 (шийдвэр гүйцэтгэгчийн талаарх гомдол) 133.3-д (шүүх болон бусад байгууллагаас гаргасан шийдвэр гүйцэтгэлийн хугацаанд нь биелүүлэхэд хяналт тавих) зааснаас гадна шийдвэр гүйцэтгэх албаны үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, хяналт тавих, ахлах шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрийг өөрчлөх хүчингүй болгох, мөн түүний үйл ажиллагаанд холбогдон гарсан гомдлыг хянан шийдвэрлэх бүрэн эрхийг эдэлнэ.
- Ахлах шийдвэр гүйцэтгэгч нь мөн хуулийн 133.1 (шийдвэр гүйцэтгэгч нарын эдэлвэл зохих бүрэн эрх)-д зааснаас гадна шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох, тэднийг мэргэжлийн удирдлагаар хангах, шүүх болон бусад байгууллагаас гаргасан шийдвэрийн гүйцэтгэх, гүйцэтгэх баримт бичгийн болон өртэй этгээдийн нэгдсэн бүртгэл хөтлөх, мэдээ, тайлан тэнцлийг нэгтгэн хуульд заасан журмын дагуу гаргах зэрэг хуульд заасан бүрэн эрхийг эдэлнэ.
- Шийдвэр гүйцэтгэгч ажил үүргээ гүйцэтгэх явцдаа мөн хуулийн 133.1-10 хүртэл хэсэгт заагдсан бүрэн эрхийг эдэлнэ.



### ХЯНАЛТЫН АСУУЛТ:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын бүтэц тогтолцоог тодорхойлно уу.
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын чиг үүргийг дурьдана уу.
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаандаа баримтлах зарчмыг нэрлэж, хэрэгжилтийг тайлбарлана уу.
4. Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны тойргийн талаар ярилцана уу.

### Бодлого

Төлбөр төлөгч “Г” нь Баянзүрх дүүргийн тохижилт үйлчилгээний газарт сар бүрийн 482500 төгрөгийн цалинтай ажил эрхэлдэг бөгөөд шүүхийн шийдвэрийн дагуу 7-15 насны 3 хүүхэддээ тэтгэлэг төлдөг байна. Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн цалингаас түүний сард төлөх ёстой тэтгэлэгийн 210600 төгрөгийг суутгах тухай мэдэгджээ.

Энэ тохиолдолд:

1. Шийдвэр гүйцэтгэгчийн явуулсан ажиллагаанд дүгнэлт өгнө үү.

### Сорил

1. Ахлах шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох эрхийг:
  - a. Ахлах гүйцэтгэгчийн зөвлөл
  - b. Албаны зөвлөл
  - c. Шадар гүйцэтгэгч
  - d. Ерөнхий гүйцэтгэгч эдэлнэ
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо:
  - a. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газар, Шийдвэр гүйцэтгэх болон Тогтоол гүйцэтгэх газраас бүрдэнэ
  - b. Төв ба орон нутгийн шийдвэр гүйцэтгэх албанаас бүрдэнэ
  - c. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, хорих байгууллага, аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанаас бүрдэнэ
3. Шүүхийн шийдвэр биелүүлэх үндэслэл:
  - a. Шүүхийн хүчин төгөлдөр тогтоол, арбиторын шийдвэр
  - b. Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр тогтоол, хуульд заасан тохиолдолд бусад

байгууллагын шүүхээр баталгаажуулсан шийдвэр

c. Шүүхийн хүчин төгөлдөр тогтоол, бусад байгууллагын шийдвэр

d. Шүүхийн хүчин төгөлдөр тогтоол

4. Шийдвэр гүйцэтгэлийн тойргийн тоог тогтоох вэ ?

a. ШШГЕГ-ын дарга

b. Хууль зүйн сайд

c. Аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны дарга

d. Засгийн газар

5. Гүйцэтгэх баримт бичгийг шүүхэд буцаахдаа:

a. Шийдвэр гүйцэтгэх албаны дарга тогтоол үйлдэнэ.

b. Ахлах шийдвэр гүйцэтгэгч тогтоол үйлдэнэ.

c. Шийдвэр гүйцэтгэгч тогтоол үйлдэнэ.

d. Аль, аль нь биш

## БҮЛГИЙН НОМ ЗҮЙ

### *Эрх зүйн баримт бичгүүд*

1. Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992 он

2. Монгол Улсын Иргэний хууль. УБ., 2002 он

3. Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. УБ., 2002 он

4. Монгол Улсын Төрийн албаны тухай хууль. УБ., 2002 он

5. Монгол Улсын Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль. УБ., 1994 он

6. Монгол Улсын Сэжигтэн яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль. УБ., 1999 он

7. Монгол Улсын Арбитрын тухай хууль. 2003 он

8. Монгол Улсын Захиргааны хариуцлагын тухай хууль. УБ., 1992

9. Монгол Улсын Шүүхийн тухай хууль. УБ., 2002 он

10. Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хууль. 2002 он

11. Монгол Улсын Эрүүгийн хууль. УБ., 2002 он



12. Монгол Улсын Нотариатын тухай хууль. УБ., 2011 он
13. Монгол Улсын Согтууруулах, мансууруулах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хууль. УБ., 2000 он
14. Монгол Ард Улсын дотор аливаа хэрэгтэн ялтанг засан сайжруулах ажлын тухай хууль. (1931 он)
15. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль. (1966 он)
16. Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль. 1981 он
17. Хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай хууль. 1993 он
18. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны тухай хууль. 1994
19. Хорихоос бусад төрлийн ял эдлүүлэх болон эрүүгийн хариуцагын бусад арга хэмжээг хэрэгжүүлэх тухай хууль. 1995 он
20. Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль. 1996 он
21. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 2002 он
22. Монгол Улсын Захиргааны хариуцагын тухай хууль. 1992
23. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай. УДШ-ийн тогтоол. Д: 43. 2007 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр.
24. Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтгээр УДШ-ийн тогтоол. Д:09. 2008 оны 02 дугаар сарын 28-ны өдөр.

### **Сурах бичиг, гарын авлага**

1. С.Нарангэрэл, БНМАУ-н Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн эрх зүйн үндсэн асуудал. УБ., 1985 он
2. С.Нарангэрэл, Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ., 2004 он
3. А.Лхагваа, С.Жанцан–Монгол Улсын Эрүүгийн ял эдлүүлэх эрх зүй. (Ерөнхий, тусгай ангийн сурах бичиг) УБ., 1996 он
4. А.Лхагваа, Монгол Улсын Шүүхийн шийдвэр биелүүлэх эрх зүй. (Ерөнхий ангийн сурах бичиг) УБ., 2000 он
5. А.Лхагваа, Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй (Ерөнхий, тусгай ангийн сурах бичиг) УБ., 2004 он
6. А.Лхагваа, Х.Пүрэвсүрэн, Монгол Улсын Эрүү, Иргэний хэрэгт холбогдох Шүүхийн шийдвэрийг биелүүлэх хууль тогтоомжийн хөгжилт (1931-2002 он) УБ., 2005 он
7. Б.Дашээвэг, Монгол Улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй. УБ., 2003, 2004 он

8. О. Алтангэрэл, Ш.Эрдэнэбат, Шийдвэр гүйцэтгэгчийн ном. УБ., 2004 он
9. В.Шаллер, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа. УБ., 2004 он
10. В.Шаллер, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн сургалтын материал.УБ., 2007
11. Юпп Ёоахимсхи, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар. УБ., 2003 он
12. Д.Х Валеев, “Исполнительное производство”. Москва., 2010 г
13. Исполнительное право, Отв. Ред. И.В. Решетникова. Москва., Норма, 2011г
14. М.С. Шакарян, “Гражданское процессуальное право” Москва., Юристь, 2002
15. В.В Ярков, Гражданский процесс.Москва., 2012
16. Гражданский процесс. Под. Ред. М.К. Треушников. Москва., 2010
17. Жалинский А., Рёрихт А, Введение в немецкое право. Москва., Спарк 2001.
18. А.Г. Давтян А.Г, Гражданское процессуальное Германии. Москва., 2000.

## **Бусад**

1. Н.Тунгалаг. Шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх хуулийн төсөл. Шихихутуг сэтгүүл. 2001оны №1.
2. Ц.Оюунбаатар. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэл ба эрх зүйн шинэчлэл”. Төр эрх зүй сэтгүүл. Д:2. 2002 он.
3. А. Дугармаа. Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийн зарим асуудлыг судлах нь. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа: шинэтгэл, хэрэгцээ, шаардлага” онол, практикийн бага хурлын илтгэлийн эмхтгэл. УБ. 2007 он.
4. А. Дугармаа. Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудал: Төр эрх зүй сэтгүүл. Тусгай дугаар. 2010 он.



## ХОЁРДУТААР БҮЛЭГ: ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ АЛБАДАН ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА

**Бүлгийн зорилго:** Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн эрх зүйн нэг бүрэлдэхүүн хэсэг болох иргэний хэргийн шүүхийн шийдвэр болон шүүхээс баталгаажуулсан бусад шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагааны ойлголт, онцлог, зардал, үе шат бүрт баримтлах нийтлэг болон тусгай журам, шийдвэр гүйцэтгэгчээс албадах ажиллагааны төрөл бүрийг хэрэгжүүлэх аргын талаар мэдлэг эзэмшиж, түүнийг практикт хэрэглэж хэвших чадвартай болно.

### СЭДЭВ.2.1. ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ АЛБАДАН ГҮЙЦЭТГЭХ НИЙТЛЭГ ЖУРАМ

#### *(Лекц-4 цаг)*

**Сэдвийн зорилго:** Иргэний хэргийн шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх үндэслэл болсон гүйцэтгэх баримт бичиг түүнд тавигдах шаардлага, буцаах үндэслэл, журам, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны ойлголт, үе шат, харьяалал, хугацаа, зардал, урамшуулал, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг түдгэлзүүлэх, дуусгавар болгох, гомдол гаргах зэрэг нийтлэг журмын талаар тодорхой мэдлэгтэй болсноор шийдвэр гүйцэтгэх ажиллагааны аль ч үе шатанд холбогдох хэм хэмжээг зөв тодорхойлон хэрэглэх чадвартай болохын зэрэгцээ энэ ажиллагааны нийтлэг зохицуулалтыг удирдлага болгодог хандлага төлөвшинө.

#### **Сэдвийн агуулга:**

- Гүйцэтгэх баримт бичгийн тухай ойлголт, агуулга
- Гүйцэтгэх баримт бичигт тавигдах нийтлэг болон тусгай шаардлага
- Гүйцэтгэх баримт бичгийн төрөл
- Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухай ойлголт, онцлог, үе шат
- Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэх, түүний эрх зүйн үр дагавар
- Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны харьяаллын тухай ойлголт, төрөл
- Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хугацаа, түүнийг тоолох журам
- Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлын тухай ойлголт, онцлог, зардал тодорхойлох журам
- Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны урамшууллын тухай ойлголт, урамшууллыг хуваарилах, олгох журам
- Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх тухай ойлголт, онцлог, үндэслэл, журам

- Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох үндэслэл, журам
- Гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаах үндэслэл, журам
- Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд гомдол гаргах үндэслэл, журам

### Нэр томъёоны тайлбар

**Гүйцэтгэх баримт бичиг.** Шүүхээс гарсан болон шүүхээс баталгаажуулсан шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл болон түүний агуулгыг илэрхийлдэг, хуульд тавигдсан шаардлага хангасан, эрх зүйн үр дагаврыг агуулсан баримт бичгийг хэлнэ. Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг гүйцэтгэх баримт бичиггүйгээр явуулахыг хориглоно. Гүйцэтгэх баримт бичиг тодорхой бүрдэлтэй байна.

**Иргэний хэргийн шүүхийн шийдвэр.** Иргэний болон захиргааны хэргийн талаар гарсан анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолыг ойлгоно.

**Шүүгчийн захирамж.** Зохигчдын эвлэрлийг баталгаажуулж, хэргийг хэрэгсэхгүй болгосон шүүгчийн захирамжаас гадна хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрснийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74, 106 дугаар зүйл болон Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 42, 43 дугаар зүйлд заасан шүүгчийн захирамж, шийдвэрийг хамааруулан ойлгоно.

**Шүүхээс баталгаажуулсан шийдвэр.** Арбитрын шийдвэр, нотариатын мэдэгдэх хуудас, эрх бүхий албан тушаалтны шийтгэвэр, цэргийн анги байгууллагын захирагч (дарга)-ийн тушаал зэргийг албадан гүйцэтгүүлэх талаар ИХШХШТ хуульд заасан журмын дагуу шүүгчийн захирамж гаргасан байхыг хэлнэ.

**Гүйцэтгэх баримт бичгийн агуулга.** Шүүхийн шийдвэрийн үндсэн дээр олгогдсон, шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх баримт бичиг.

**Гүйцэтгэх хуудас.** Шүүхээс гарсан болон шүүхээр баталгаажуулсан шийдвэрийг албадан гүйцэтгүүлэхээр гаргасан шүүгчийн захирамжийг үндэслэн эрх бүхий байгууллагаас олгосон баримт бичиг. Гүйцэтгэх хуудас нь төрийн сүлд бүхий хэвлэмэл хуудас байна.

**Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа.** Шийдвэр гүйцэтгэх байгууллага (шийдвэр гүйцэтгэгч) тухайн ажиллагаанд оролцогч талууд болох төлбөр төлөгч, төлбөр авагч, гуравдагч этгээд болон бусад субъектын хооронд шүүхээс гаргасан болон шүүхээр баталгаажуулсан шийдвэр, бусад байгууллагаас гаргасан шийдвэрийг албадан гүйцэтгэх явцад бий болсон олон талт, хоорондоо холбоо бүхий ажиллагаануудыг хамарсан ойлголт юм.

**Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үе шат.** Тухайн ажиллагааны эхлэл, явц, төгсгөлийг агуулсан ойлголт юм. Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа тодорхой бие



даасан үе шатуудыг дамжин хэрэгжиж байдаг.

**Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны харьяалал.** Шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хуульд заасны дагуу гүйцэтгэвэл зохих (төлбөр төлөгчийн болон тухайн эд хөрөнгийн нутаг дэвсгэрийн харьяаллаас хамаарсан) нутаг дэвсгэрийн харьяалал юм.

**Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хугацаа.** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа тодорхой цаг, хугацаанд явагдахыг ойлгоно.

**Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал.** Шийдвэр гүйцэтгэх байгууллагаас шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдон зайлшгүй гарах зардлыг ойлгоно.

**Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны урамшуулал.** Шүүхийн шийдвэрийг бодитойгоор гүйцэтгэсэн шийдвэр гүйцэтгэгчийг төлбөрийн шаардлагыг хангахаар гаргуулсан мөнгөний болон эд хөрөнгийн үнийн дүнгийн 0,5-10 хүртэлх хувиар урамшуулна.

**Урамшууллын гэрээ.** Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хэсэгчилэн биелсэн болон дуусгавар болсны дараа төлбөр авагчаас төлбөрт гаргуулсан мөнгөн болон эд хөрөнгийн үнийн дүнгээс 0.5-10 хүртэл хувиар гаргуулж, шийдвэр гүйцэтгэгчийг урамшуулахаар тохиролцсон гэрээ.

**Зардлын гэрээ.** Шийдвэр гүйцэтгэх байгууллагаас шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдон зайлшгүй гарах зардлыг төлбөр авагчаас тухай бүр гаргуулж, шийдвэр гүйцэтгэх албаны дансанд төвлөрүүлэхээр тохиролцсон гэрээ.

**Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх.** Шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан үндэслэл, нөхцөл бий болсон тохиолдолд шүүгчийн захирамж, ахлах шийдвэр гүйцэтгэгчийн тогтоолоор шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түр хугацаагаар зогсоож байгаа үйл ажиллагааг ойлгоно.

**Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох.** Хуульд заасан үндэслэлээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааг цаашид үргэлжлүүлэх боломжгүй болсон тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч төлбөр авагч болон төлбөр төлөгчид шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болсон тухай шийдвэрийн хувийг хүргүүлснээр энэхүү ажиллагааг дуусгавар болсонд тооцно.

**Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд гомдол гаргах.** Төлбөр авагч, төлбөр төлөгч, гуравдагч этгээд шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаа, шийдвэр гүйцэтгэгчийн гаргасан шийдвэрийг эс зөвшөөрсөн бол зөрчигдсэн эрх ашгаа хамгаалуулахаар эрх бүхий албан тушаалтан, шүүхэд хандаж байгаа үйл ажиллагаа юм.

**Гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаах.** Шийдвэр гүйцэтгэх

ажиллагаа явагдаагүй, эсхүл хэсэгчлэн явагдсан бол ахлах шийдвэр гүйцэтгэгчийн тогтоолоор гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцааж байгаа үйл ажиллагааг ойлгоно. Буцаасан гүйцэтгэх баримт бичгийг дахин гүйцэтгүүлэхээр ирүүлж болно.

### Сэдвийн тойм

Иргэний хэргийн шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх нийтлэг журам нь иргэн, хуулийн этгээдээс төлбөр гаргуулах, тодорхой үйл ажиллагаа гүйцэтгүүлэх, тодорхой үйл ажиллагаа гүйцэтгүүлэхгүй байхыг даалгасан шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх явцад шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бүх үе шатанд хэрэгжиж байдгаараа онцлог юм.

Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь өөрийн гэсэн онцлогтой.

Үүнд:

- Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэх үндэс нь хуулиар тодорхойлогдсон гүйцэтгэх баримт бичиг байна. (Гүйцэтгэх баримт бичгийн бүрдлийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тодорхой зааж өгсөн)
- Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд төлбөр авагч, төлбөр төлөгч гэсэн талууд оролцдог онцлогтой.
- Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шийдвэр гүйцэтгэгч бүрэн эрхийнхээ хүрээнд хэрэгжүүлнэ.
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь тодорхой үе шатуудыг дамжин хэрэгжинэ. (үүсгэх, бэлтгэх, гүйцэтгэх, гомдол гаргах, хянах, гүйцэтгэлийн ажиллагааг дуусгавар болгох)
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд энэрэнгүй байх, эдийн засгийн хувьд харилцан ашигтай байх, харилцан зөвшилцөж шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэр заавал биелэгдэх зэрэг зарчим хэрэгжиж байдгаараа онцлог юм.
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зөвхөн харьяалагдах тойргийн шийдвэр гүйцэтгэгч хэрэгжүүлнэ. Өөрөөр хэлбэл, шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаанд хуулиар тусгайлан тогтоосон харьяалал байна.
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эцсийн зорилго нь онцлог байдаг. (шүүхээс гарсан болон шүүхээс баталгаажуулсан шийдвэрийг албадан гүйцэтгэж, зөрчигдсөн эрх ашгийг бодит байдлаар сэргээнэ)
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хэрэглэгддэг албадах ажиллагааны тусгайлсан төрөлтэй.



Энэхүү ажиллагааг хэрхэн тодорхойлох нь иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн Монголын эрх зүйн системд эзлэх байр сууриас шууд шалтгаална. Иймд энэхүү гарын авлагын нэгдүгээр сэдвээс энэ талаар уншиж судална уу?

Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа тодорхой үе шатуудыг дамжин хэрэгждэг. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд ямар, ямар үе шат байх талаар хуульд нэг бүрчлэн зааж тодорхойлоогүй боловч онолын судлаачид энэ асуудлыг судлан өөр өөрсдийн үзэл баримтлалыг дэвшүүлсэн байдаг. Тухайлбал, ОХУ-ын Шийдвэр гүйцэтгэх эрх зүйн холбогдох ном, сурах бичигт шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэх, албадах ажиллагааг хэрэгжүүлэхэд бэлтгэх бэлтгэлийн, төлбөр төлөгчид албадлагын арга хэмжээг хэрэглэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд гомдол гаргах, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг дуусгавар болгох гэсэн үндсэн 5 үе шатыг дамжин хэрэгжиж байдаг гэсэн үзэл баримтлалд дийлэнх судлаачид санал нэгдэж байгаа талаар дурьджээ.

Эдгээр үе шат бүрт шийдвэр гүйцэтгэгч, төлбөр төлөгч, төлбөр авагч, гуравдагч этгээд болон бусад оролцогчдын хэрэгжүүлэх бүрэн эрх, эрх, үүрэг, гаргах эрх зүйн баримт бичиг онцлогтой. Энэ асуудлыг дэлгэрүүлэн судалснаар оюутан бүр өөр өөрсдийн үзэл баримтлалыг дэвшүүлж хэлэлцүүлвэл зохино.

Энэ сэдвийн хүрээнд гүйцэтгэх баримт бичиг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндэслэл гэсэн ойлголтуудыг ялган зааглаж ойлговол зохино. Тухайлбал, ажилтныг ажилд нь эгүүлэн тогтоосон шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноор шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэл болно. Харин тухайн шийдвэрийг албадан гүйцэтгэхэд шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэхээр шүүгчээс гаргасан захирамж, түүний үндсэн дээр шүүхээс олгосон гүйцэтгэх хуудас зайлшгүй шаардлагатай. Энэ тохиолдолд шүүхийн шийдвэр, шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх захирамж, гүйцэтгэх хуудас зэргийг хамтад нь гүйцэтгэх баримт бичиг хэмээн ойлгоно.

Гэтэл УДШ-ийн 2007 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай 43 дугаар тогтоолд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 10 зүйлийн 10.3, 11 дүгээр зүйлд заасан “гүйцэтгэх баримт бичиг” гэдгийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 187, 188 дугаар зүйлд заасан “гүйцэтгэх хуудас” гэж ойлгоно хэмээн тайлбарласан нь гүйцэтгэх баримт бичгийн ойлголт, агуулгыг бүрхэгдүүлж, хэт явцуу байдлаар авч үзжээ гэж дүгнэхэд хүргэж байгааг анхаарах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, гүйцэтгэх баримт бичгийн төрөлд хамаарах гүйцэтгэх хуудсыг, гүйцэтгэх баримт бичигтэй адил байдлаар тайлбарласан нь үндэслэлтэй эсэхийг судлах шаардлагатай юм.

Гүйцэтгэх баримт бичиг хуулийн шаардлага хангасан тохиолдолд ахлах гүйцэтгэгч түүнийг хүлээн авсан өдрөөс хойш 3 хоногийн дотор шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэрэг нээж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэх тухай тогтоол гарган зохих тойргийн шийдвэр гүйцэтгэгчид хуваарилна.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэх тухай тогтоолд гүйцэтгэх баримт бичиг, хөрөнгө битүүмжилсэн буюу хураасан акт, нэхэмжлэлийн үнийн дүнтэй тэнцэх хэмжээгээр иргэн, хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, харилцах дансны зарлагын гүйлгээг хаасан баримт бичиг, тодорхойлолт зэргийг хавсаргасан байвал зохих талаар Шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3-т заажээ.

Хөрөнгө битүүмжилсэн буюу хураасан акт, нэхэмжлэлийн үнийн дүнтэй тэнцэх хэмжээгээр иргэн, хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, харилцах дансны зарлагын гүйлгээг хаасан баримт бичиг, тодорхойлолт гэдэгт шүүхээс гарах шийдвэрийг бодитойгоор гүйцэтгэх боломжийг хангахын тулд шүүхийн шийдвэр гарахаас өмнө нэхэмжлэлийн үнийн дүнгийн хэмжээгээр эд хөрөнгийг бүгдийг буюу зарим хэсгийг битүүмжлэх, банкин дахь мөнгөн хадгаламжийн дансны зарлагын гүйлгээг зогсоох, тодорхой ажиллагаа гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэхгүй байхыг хариуцагчид даалгах, эд хөрөнгөө захиран зарцуулах эрхийг хязгаарлах тухайлбал, эд хөрөнгийг худалдах, бусад шилжүүлэх, эд хөрөнгийн бусад үүрэг биелүүлэхийг хориглох талаар гаргасан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын тогтоол, тэдгээрийн дагуу гүйцэтгэлийн ажиллагаа явуулсан акт, тэмдэглэл болон бусад холбогдох бичгийн баримтууд хамаарах юм.

Ахлах шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэх тухай тогтоол гаргаснаар хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэр заавал биелэгдэх зарчмын хүрээнд шийдвэр гүйцэтгэгч, төлбөр авагч, төлбөр төлөгчийн эрх, үүрэг хэрэгжих эрх зүйн үр дагавар бий болно.

### **Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны харьяалал**

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны харьяалал гэдэг нь шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хуульд заасны дагуу гүйцэтгэвэл зохих (төлбөр төлөгчийн болон тухайн эд хөрөнгийн нутаг дэвсгэрийн харьяаллаас хамаарсан) нутаг дэвсгэрийн харьяалал юм.



## Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны харьяаллыг тодорхойлбол:

- Төлбөр төлөгч иргэн бол шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түүний оршин суугаа газрын тойргийн шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэнэ.
- Төлбөр төлөгч хуулийн этгээд бол түүний ажил, хэргээ байнга явуулдаг, эсхүл удирдах байгууллага байгаа нутаг дэвсгэрийн тойргийн шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэнэ.
- Төлбөр төлөгчийн оршин суугаа (оршин байгаа) газар нь мэдэгдэхгүй бол түүний эд хөрөнгө байгаа нутаг дэвсгэрийн тойргийн шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэнэ.
- Тодорхой үйл ажиллагаа гүйцэтгүүлэхээр хариуцагчид даалгасан шийдвэрийг уг үйл ажиллагааг гүйцэтгэх этгээдийн оршин суугаа (оршин байгаа) нутаг дэвсгэрийн тойргийн шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэнэ.
- Бусдын амь бие, эрүүл мэндэд гэм хор учруулсны хохирлыг нөхөн төлүүлэх шийдвэрийг төлбөр төлөгч, төлбөр авагчийн алины нь ч оршин суугаа нутаг дэвсгэрийн тойргийн шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэнэ.
- Өөр өөр газар оршин суугаа (оршин байгаа) хэд хэдэн төлбөр төлөгчид холбогдох шийдвэрийг төлбөр авагчийн саналаар төлбөр төлөгчдийн аль нэгний оршин суугаа (оршин байгаа) нутаг дэвсгэрийн тойргийн шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэнэ.
- Гадаад улсын нутаг дэвсгэр дээр байгаа Монгол Улсын иргэн, хуулийн этгээдтэй холбоотой шийдвэрийг төлбөр авагчийн оршин суугаа (оршин байгаа) газрын, эсхүл төлбөр төлөгчийн эд хөрөнгө байгаа нутаг дэвсгэрийн тойргийн шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэнэ.

Харин шийдвэр гүйцэтгэх явцад төлбөр төлөгчийн оршин суугаа (оршин байгаа) газрын хаяг өөрчлөгдсөн, эд хөрөнгө байхгүй бол шийдвэр гүйцэтгэгч нь энэ талаар тэмдэглэл үйлдэж ахлах шийдвэр гүйцэтгэгч болон төлбөр авагчид тус тус мэдэгдэнэ.

## Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулах хугацаа



Шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичгийг хүлээж авснаас хойш ямар хугацаанд шийдвэрийг гүйцэтгэх талаарх хуулийн зохицуулалт хязгаарлагдмал тул албадах ажиллагааг хэрэгжүүлэх хугацааг шийдвэр гүйцэтгэгч өөрөө тогтоодог онцлогтой.

### Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад тодорхой зардал гарна. Үүнд дараах зардал багтана:

- Төлбөр төлөгчийн эд хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах, хураах, хадгалах, тээвэрлэх, шилжүүлэх, худалдан борлуулах зардал
- Төлбөр төлөгч болон түүний нуусан эд хөрөнгийг эрэн сурвалжлах, илрүүлэх зардал
- Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг хэрэгжүүлэхэд тогтоосон журмын дагуу оролцсон, шинжээчийн ажлын хөлс
- Илгээмж, шуудан, холбооны зардал
- Шийдвэр гүйцэтгэх бусад ажиллагааны зардал

### Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх зардлыг хуваарилах ерөнхий бүдүүвч:



### Шүүхийн шийдвэр гүйцэтгэх зардлыг хуваарилах нөхцөл:

- Шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг тухай бүр төлбөр авагчаас гаргуулж шийдвэр гүйцэтгэх албаны дансанд төвлөрүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болсон тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг төлбөр төлөгчөөс нөхөн гаргуулж, төлбөр авагчид олгоно.
- Төлбөрийн шаардлагын зарим хэсгийг хангасан бол шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг тэр хэмжээгээр төлбөр авагч, төлбөр төлөгч хуваан төлнө.
- Гүйцэтгэх баримт бичигт зааснаар хэд хэдэн төлбөр авагч, төлбөр төлөгч байгаа бол шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг тэднээс хуваан гаргуулна.



## **Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны урамшууллын тухай ойлголт, урамшууллыг хуваарилах, олгох журам**

Шүүхийн шийдвэрийг бодитойгоор гүйцэтгэсэн шийдвэр гүйцэтгэгчийг төлбөрийн шаардлагыг хангахаар гаргуулсан мөнгөний болон эд хөрөнгийн үнийн дүнгийн 0,5-10 хүртэлх хувиар урамшуулна.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардалд төлбөр төлөгчийн эд хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах, хураах, хадгалах, тээвэрлэх, шилжүүлэх, худалдан борлуулах, төлбөр төлөгчийн нуусан эд хөрөнгийг эрэн сурвалжлах, илрүүлэх, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг хэрэгжүүлэхэд тогтоосон журмын дагуу оролцсон шинжээчийн ажлын хөлс, илгээмж, шуудан, холбооны болон бусад шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлууд хамаарна.


Шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг тухай бүр төлбөр авагчаас гаргуулж, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болсон тохиолдолд зардлыг төлбөр төлөгчөөс нөхөн гаргуулж, төлбөр авагчид олгоно.

Хүүхдийн тэтгэлэг авагч, амь бие, эрүүл мэндэд учирсан хохирлын төлбөр авагч, хөгжлийн бэрхшээлтэй төлбөр авагч, өндөр настай төлбөр авагчийг дээр дурьдсан зардлаас чөлөөлнө. Шийдвэр гүйцэтгэгч нь төлбөр авагчтай гэрээ байгуулж зардлыг тухай бүр гаргуулна.

Шүүхийн шийдвэрийг бодитойгоор бүрэн биелүүлсний дараа шийдвэр гүйцэтгэгчид урамшуулал олгоно.

## **Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх тухай ойлголт, онцлог**

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх гэдэг нь хуульд заасан үндэслэл, нөхцөл бий болсон тохиолдолд шүүгчийн захирамж, ахлах шийдвэр гүйцэтгэгчийн тогтоолоор шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түр хугацаагаар зогсоож байгаа үйл ажиллагааг ойлгоно. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг Шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан үндэслэл, хугацаагаар шүүгчийн захирамж болон шийдвэр гүйцэтгэх албаны ахлах шийдвэр гүйцэтгэгчийн тогтоолоор тус тус түдгэлзүүлнэ.



Дараах тохиолдолд дор дурьдсан хугацаагаар шүүгчийн захирамжаар түдгэлзүүлнэ. Үүнд:

- Дампуурлын хэрэг үүсгэсэн, эсхүл битүүмжилсэн эд хөрөнгийг чөлөөлөх тухай нэхэмжлэлийг шүүхэд тус тус гаргасан бол асуудлыг хэлэлцэж дуусах хүртэл
- Төлбөрт хураагдсан эд хөрөнгийн талаар бие даасан шаардлага гаргах эрхтэй гуравдагч этгээд шүүхэд гомдол гаргасан бол шүүхийн шийдвэр гаргал
- Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах тухай хүсэлт гарсан бол түүнийг дахин шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр гарах хүртэл
- Гүйцэтгэх баримт бичгийн дагуу төлбөрт хураан авах эд хөрөнгийн жагсаалтаас тухайн эд хөрөнгийг хасуулах тухай, эд хөрөнгийн үнэлгээний талаар, үл хөдлөх эд хөрөнгийн үнэтэй холбогдсон, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 34.4, 87.3-д заасан үндэслэлээр шүүхэд гомдол гаргасан бол шүүхийн шийдвэр гарах хүртэл.

Дараах тохиолдолд дор дурьдсан хугацаагаар шийдвэр гүйцэтгэх албаны ахлах шийдвэр гүйцэтгэгчийн тогтоолоор түдгэлзүүлнэ. Үүнд:

- Төлбөр төлөгчийн хаягийг тодруулах буюу эрэн сурвалжилж байгаа бол хаягийг олж тогтоох хүртэл
- Төлбөр төлөгчөөс хураасан эд хөрөнгийг төлбөр авагч авахаас татгалзсан үед төлбөрийн шаардлага хангахуйц эд хөрөнгийг төлбөр төлөгчөөс гаргуулах хүртэл
- Эрүүгийн журмаар хэргийг шалгаж байгаа бол асуудлыг хэлэлцэж дуусах хүртэл
- Төлбөр гаргуулж болох эд хөрөнгө, эсхүл орлого байхгүй бөгөөд хуульд заасан аргаар түүний эд хөрөнгө, эсхүл орлогыг албадан гаргах боломжгүй бол эд хөрөнгөтэй болтол
- Барилга, орон байрнаас нүүлгэн гаргах тухай шийдвэрийг нүүн гарч байгаа этгээдийн амьдралын нөхцлийг харгалзан өвлийн улиралд тодорхой хугацаагаар
- Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа болон гүйцэтгэх баримт бичгийн талаар гомдол гаргасан нь үндэслэлтэй бол гомдлыг шийдвэрлэх хүртэл
- Төлбөр төлөгч, эсхүл төлбөр авагч иргэн нас барсан гэж зарлагдсан, сураггүй алга болсонд тооцогдсон, иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон, хуулийн этгээд татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан бол тэдгээрийн эрх, үүрэг эрх залгамжлагчид шилжих, эсхүл сураггүй алга болсонд тооцогдсон иргэний эд хөрөнгийг эрхлэн хамгаалагч болон иргэний эрх зүйн чадамжгүй төлбөр төлөгчид асран хамгаалагчийг тус тус тогтоох хүртэл



Шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлсэн тухай төлбөр төлөгч, төлбөр авагч, шүүх болон гүйцэтгэх баримт бичиг үйлдсэн бусад байгууллагад мэдэгдэнэ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2-т заасан үндэслэл арилмагц төлбөр авагчийн буюу шийдвэр гүйцэтгэгчийн хүсэлтээр шүүгч захирамж, ахлах шийдвэр гүйцэтгэгч тогтоол гарган шийдвэр гүйцэтгэх ажиллагааг сэргээнэ.

### **Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох үндэслэл, журам**

Хуульд заасан үндэслэлээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааг цаашид үргэлжлүүлэх боломжгүй болсон тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч төлбөр авагч болон төлбөр төлөгчид энэ тухай мэдэгдэж, шийдвэрийн хувийг хүргүүлснээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болсонд тооцно.

Дор дурьдсан үндэслэлээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болсонд тооцно.

- төлбөр авагч нь төлбөр авахаас татгалзвал түүний хүсэлтээр
- төлбөр төлөгч төлбөрөө бүрэн төлсөн
- төлбөр төлөгч, төлбөр авагч хоорондоо эвлэрвэл тэдгээрийн гаргасан тодорхойлолтоор
- төлбөр төлөгч-иргэн, эсхүл төлбөр авагч-иргэн нас барсан гэж зарлагдсан буюу төлбөр төлөгч-хуулийн этгээд татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан үед тэдгээрийн эрх, үүрэг эрх залгамжлагчид шилжээгүй
- төлбөр төлөгч-хуулийн этгээдэд дампуурлын хэрэг үүсгэж явуулсан татан буулгах ажиллагаа дуусгавар болоход эд хөрөнгө төлбөр төлөхөд хүрэлцэхгүй байгаа нь шүүхээр тогтоогдсон
- гүйцэтгэх баримт бичиг хүчингүй болсонд тооцогдсон.

### **Гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаах**

Энэ нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаагүй, эсхүл хэсэгчлэн явагдсан бол ахлах шийдвэр гүйцэтгэгчийн тогтоолоор гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцааж байгаа үйл ажиллагаа юм.

Гүйцэтгэх баримт бичгийг дараах үндэслэлээр төлбөр авагчид буцаана. Үүнд:

- Төлбөр авагч хүсэлт гаргасан
- Төлбөр авагч шүүхийн шийдвэрт заасан, эсхүл төлбөрт гаргуулсан боловч худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөрт тооцон авахаас татгалзсан;
- Төлбөр авагч өөрийн үйлдэл, (эс үйлдэхүй)-гээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулахад саад учруулж байгаа.

### Гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаах журам

Дээр дурьдсан үндэслэлээр төлбөрийг гаргуулах боломжгүй нь тогтоогдсон бол шийдвэр гүйцэтгэгч энэ тухай тэмдэглэл үйлдэж, гүйцэтгэх баримт бичиг болон бусад материалыг ахлах шийдвэр гүйцэтгэгчид ирүүлнэ.

Гүйцэтгэх баримт бичгийг буцаах үндэслэлтэй гэж үзвэл ахлах шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн эд хөрөнгийг зохих ёсоор битүүмжилсэн, хураасан, худалдан борлуулсан эсэх, нуусан эд хөрөнгийг олж илрүүлэх талаар бүхий л арга хэмжээ авсан эсэхийг хянан үзэж тогтоол гаргана. Гүйцэтгэх баримт бичгийг дээр дурьдсан үндэслэлээр төлбөр авагчид буцаасан бол түүнийг дахин гүйцэтгүүлэхээр шийдвэр гүйцэтгэх албанд ирүүлж болно.

### Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд гомдол гаргах үндэслэл, журам

Төлбөр авагч, төлбөр төлөгч, гуравдагч этгээд шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаа, шийдвэр гүйцэтгэгчийн гаргасан шийдвэрийг эс зөвшөөрсөн бол гомдол гаргах эрхтэй. Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд гаргах гомдлыг дор дурьдсан байдлаар ангилж болно. Үүнд:

- Эд хөрөнгө үнэлэхтэй холбоотой
- Эд хөрөнгийн битүүмжлэхтэй холбоотой
- Эд хөрөнгө хураахтай холбоотой
- Эд хөрөнгө худалдан борлуулахтай холбоотой
- Үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдааны явцад эд хөрөнгийн үнэлэхтэй холбоотой
- Эд хөрөнгийг битүүмжлэх, жагсаалтаас хасах, чөлөөлүүлэхтэй холбоотой гомдол

Шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар гарсан гомдлыг ахлах шийдвэр гүйцэтгэгч шийдвэрлэж тогтоол гаргах, түүнийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргах боломжтой.



Хуулийн энэ зохицуулалт гомдол гаргагч шүүхэд эрхээ хамгаалуулахаас өмнө ахлах шийдвэр гүйцэтгэгч, Ерөнхий гүйцэтгэгчид гомдлоо гаргаж шийдвэрлүүлсэн байхыг шаардаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3-дахь хэсэгт төлбөр төлөгч, төлбөр авагч эд хөрөнгийн үнэлгээний талаарх гомдлоо үнэлгээ тогтоосон өдрөөс хойш 7 хоногийн дотор шүүхэд гаргаж болно гэж заасан нь энэ талаарх гомдлыг шүүх тусгай харьяаллын хүрээнд шууд хүлээн авч шийдвэрлэх боломжтойг харуулж байна.

Иймд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад гомдол гаргах эрх зүйн зохицуулалтын хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хуулийн 15, 34, 37, 87 дугаар зүйлүүдийг харьцуулан судалвал зохино.

### ХЯНАЛТЫН АСУУЛТ:

1. Гүйцэтгэх баримт бичиг, түүний агуулга ямар байх вэ?
2. Гүйцэтгэх баримт бичигт хамаарах шийдвэрийг нэрлэж, тус бүрийг тайлбарлана уу.
3. Шүүхээс баталгаажуулсан шийдвэр гэдгийн онцлогийг нэрлэнэ үү.
4. Гүйцэтгэх хуудас, түүнд тавигдах шаардлага ямар байх вэ?
5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, түүний онцлогийг нэрлэнэ үү.
6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үе шат ямар байх вэ?
7. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэх, албадах ажиллагааны бэлтгэлийн болон албадах ажиллагааг хэрэгжүүлэх үе шатанд шийдвэр гүйцэтгэгчийн эрх, үүрэг, хариуцлага ямар байх талаар хэлэлцэнэ үү.
8. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны харьяалал, төрлийг нэрлэнэ үү.
9. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хугацаа, түүнийг тоолох журам ямар байх вэ?
10. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал гэдгийг тайлбарлаж, зардлын хэмжээг тодорхойлно уу.
11. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны урамшуулал, түүний хэмжээг хэлэлцэнэ үү.
12. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх үндэслэл, журам, үр дагавар ямар байх вэ?
13. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох гэдгийг тайлбарлаж, түүний үр дагаврын талаар ярилцана уу.
14. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох үндэслэл, журам нь гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаах үндэслэл, журмаас ялгагдах уу?
15. Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд гомдол гаргах эрхтэй этгээдийг нэрлэж, хаана, хэнд хандаж гомдол гаргахыг тодорхойлно уу.

### **Бодлого**

Иргэн Балжир БЗД-ийн шүүхэд нэхэмжлэл гаргажээ. Тэрээр нэхэмжлэлдээ өөрийн гэрээс 3 жилийн өмнө алдагдсан “Дөрвөн улирал” нэртэй уран зураг иргэн Даржаагийн байгааг олж мэдсэн тул бусдын хууль бус эзэмшлээс уран зургаа шаардан гаргуулж өгнө үү? гэснийг үндэслэн анхан шатны шүүх буюу БЗД-ийн шүүх нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэжээ. Анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш Балжир тухайн шийдвэрийг албадан биелүүлэх хүсэлт гаргаснаар шийдвэрийг албадан гүйцэтгэх шүүгчийн захирамж гарч, гүйцэтгэх хуудас бичигдсэн байна. Гүйцэтгэх баримт бичгийн дагуу гүйцэтгэлийн ажиллагаа явагдаж, уран зургийг Даржаагаас хураан авч төлбөр авагч Балжирт хүлээлгэн өгсөн байна. Үүнээс хойш тодорхой цаг хугацаа өнгөрсний дараа Балжир уран зургаа өөр нэгэн этгээдэд өндөр үнэ хүргэн худалдсан.

Гэтэл Даржаагаас гаргасан хяналтын гомдлын дагуу хяналтын журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, дахин шийдвэрлүүлэхээр тогтоол гаргажээ. БЗД-ийн шүүх хэргийг дахин шийдвэрлэхдээ Балжирын нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгожээ.

Энэ тохиодолд:

1. БЗД-ийн шүүх Балжирын нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн нь өмнө нь гүйцэтгэсэн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд нөлөөлөх эсэхэд дүгнэлт хийнэ үү?

### **Сорил**

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэлд аль нь хамаарах вэ?
  - a. Хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр
  - b. Хүчин төгөлдөр хяналтын шатны шүүхийн тогтоол
  - c. Улсын дээд шүүхийн шүүгчийн захирамж
  - d. Гүйцэтгэх хуудас
2. Аль нь гүйцэтгэх хуудас бичих шаардлагагүй эрх зүйн актад хамаарах вэ?
  - a. Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах тухай шүүгчийн захирамж
  - b. Захиргааны шийтгэвэр
  - c. Арбитрын шийдвэр
  - d. Бүгд буруу
3. Нотлох баримтыг хамгаалах тухай шүүгчийн захирамжийг шүүхээс баталгаажуулах шаардлагатай юу?
  - a. Шаардлагатай
  - b. Шаардлагагүй



- c. Зарим тохиолдолд баталгаажуулна.  
d. Дээрх бүгд буруу
4. Шүүхээр баталгаажуулах шаардлагатай эрх зүйн актыг хэдэн шүүгчийн бүрэлдэхүүнтэй баталгаажуулах вэ?  
a. 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй  
b. 1 шүүгчийн бүрэлдэхүүнтэй  
c. Шүүхээр баталгаажуулахаар хүсэлт гаргаж байгаа этгээдийн хүсэлтээр шийдвэрлэнэ.  
d. Дээрх бүгд буруу
5. Төлбөр авагч Наран шүүхийн шийдвэрт заасан эд хөрөнгийг төлбөртөө тооцон авахаас татгалзсан гэж гүйцэтгэх баримт бичгийг түүнд буцаахдаа ахлах шийдвэр гүйцэтгэгч тогтоол үйлдсэн байна. Энэ тохиолдолд ахлах шийдвэр гүйцэтгэгчийн үйлдэлд дүгнэлт хийнэ үү?  
a. Гүйцэтгэх баримт бичгийг буцаах тохиолдол бүрт ахлах шийдвэр гүйцэтгэгч тогтоол үйлддэг тул зөв байна  
b. Зөвхөн Наранд тохиолдсон үндэслэлээр гүйцэтгэх баримт бичгийг буцаахад тогтоол үйлддэг тул зөв байна  
c. Энэ талаар хууль, тогтоомжид ямар нэгэн зохицуулалт байхгүй  
d. Дээрх хариултын аль нь ч биш
6. Гүйцэтгэх баримт бичиг хүчингүй болсонд тооцогдсон бол:  
a. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгоно  
b. Гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаана  
c. Шийдвэр гүйцэтгэгчийн саналаар ахлах шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлнэ
7. Шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэхээр:  
a. Шүүх бүрэлдэхүүн тогтоол гаргана.  
b. Шүүгч захирамж гаргана.  
c. Ерөнхий шүүгч албан бичиг хүргүүлнэ.
8. Төлбөр төлөгч Э сураггүй алга болсонд тооцогдсон. Энэ тохиолдолд Э-д холбогдох шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг дуусгавар болгосон байна. Дүгнэлт хийнэ үү?  
a. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгосон нь үндэслэлтэй зөв.  
b. Үндэслэлгүй. Өв хөрөнгийг эрхлэн хамгаалагчаар томилогдсон этгээд оролцоно  
c. Үндэслэлгүй. Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч оролцоно

- d. Үндэслэлгүй. Өв залгамжлагч өвлөсөн хөрөнгийн хэмжээнд бусдад төлөх төлбөрийг хариуцана
9. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг гүйцэтгэх баримт бичиггүйгээр явуулахыг хориглоно. Гүйцэтгэх баримт бичгийг гүйцэтгэх хуудастай адилтган авч үзэж болох уу?
- a. Болно. Учир нь: \_\_\_\_\_
- b. Болохгүй. Учир нь: \_\_\_\_\_

## СЭДВИЙН НОМ ЗҮЙ

### Эрх зүйн баримт бичгүүд

1. Монгол Улсын Үндсэн хууль УБ., 1992 он
2. Монгол Улсын Иргэний хууль. 2002 он
3. Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. 2002 он
4. Монгол Улсын Арбитрын тухай хууль. 2003 он
5. Монгол Улсын Захиргааны хариуцлагын тухай хууль. 1992
6. Монгол Улсын Шүүхийн тухай хууль. 2002 он
7. Монгол Улсын Эрүүгийн хууль (холбогдох заалтууд)УБ., 2002 он
8. Монгол Улсын Нотариатын тухай хууль. 2011 он
9. Гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авч, хянан шийдвэр үйл ажиллагааны журам. ШШГЕГ-ын даргын тушаал. Д: А/08
10. Шийдвэр гүйцэтгэгчийн урамшууллыг суутгах, түүнийг хуваарилах журам. ХЗДХС-ын тушаал. Д: 104. 2010 он.
11. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг тодорхойлох журам. ХЗДХС-ын тушаал. Д: 104. 2010 он.

### Сурах бичиг, гарын авлага

1. А.Лхагваа “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй” 2004 он
2. С.Дашзэвэг”Монгол улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй” 2003 он
3. Б.Эрдэнэбат ”Шийдвэр гүйцэтгэгчийн ном” 2003 он
4. З.Сүхбаатар ”МУ-ын иргэний хуулиуд” 2003 он
5. 4. Под.ред.В.В.Ярков. Гражданский процесс. М., 2001.
6. 5. Под.ред. М.К.Треушников. Гражданский процесс. М., 2000



## СЭДЭВ.2.2 ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ АЛБАДАН ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ТӨРӨЛ

### (Семинар 2 цаг)

**Сэдвийн зорилго:** Иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн бодит биелэлтийг хангахын тулд шийдвэр гүйцэтгэгчээс сонгон хэрэгжүүлэх албадах ажиллагааны онцлог, төрөл тус бүрт баримтлах журмын талаар тодорхой мэдлэгтэй болсноор шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд төлбөр авагч, төлбөр төлөгчийн эрх ашгийг хамгаалах чадвартай болж, холбогдох хуулийн хэм хэмжээг хэрэгжүүлэх боломжтой болно.

### Сэдвийн агуулга:

- Шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг албадан хэрэгжүүлэхэд бэлтгэх бэлтгэл ажиллагаа, түүний эрх зүйн үр дагавар
- Албадах ажиллагааны төрөл
- Үзлэг хийх
- Нэгжлэг хийх
- Төлбөр төлөгчийн эд хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах
- Эд хөрөнгийг хураах
- Төлбөр төлөгчийн эд хөрөнгийг үнэлэх
- Эд хөрөнгийг худалдан борлуулах
- Төлбөр төлөгчөөс эд хөрөнгийн тухай мэдүүлэг авах тухай ойлголт, үндэслэл, журам
- Өртэй этгээдийн бүртгэл

### Нэр томьёны тайлбар:

**Үзлэг.** Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн эд хөрөнгийн хэмжээг тогтоох зорилгоор түүний өөрт нь буюу бусдын эзэмшилд байгаа эд хөрөнгөд нэг бүрчлэн үзлэг хийхийг ойлгоно.

**Нэгжлэг.** Шийдвэр гүйцэтгэгчээс төлбөр төлөгчийн нуусан эд хөрөнгийг илрүүлэх зорилгоор биед нь болон тухайн эд хөрөнгийг нуусан газарт явуулж байгаа албадах ажиллагааны төрөл юм. Нэгжлэгийг төлбөр төлөгчийн эд хөрөнгөд үзлэг хийх, битүүмжлэх, барьцаалах хураах явцад гүйцэтгэнэ.

**Эд хөрөнгийг битүүмжлэх.** Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн эд хөрөнгийг хамгаалах, төлбөр авагчид шилжүүлэх, худалдан борлуулах, хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах тухай шийдвэрийг гүйцэтгэх зорилгоор төлбөр төлөгчийн өөрт нь байгаа болон бусдын өмчлөлд байгаа эд хөрөнгийг тодорхой хугацаагаар

эзэмших, ашиглах захиран зарцуулах эрхийг хязгаарлаж байгаа үйл ажиллагааг ойлгоно.

**Эд хөрөнгийг барьцаалах.** Шүүхийн шийдвэрийн гүйцэтгэлийн биелэлтийг хангах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор төлбөр төлөгчийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрхийг барьцаалан авахыг ойлгоно.

**Эд хөрөнгө хадгалах.** Шийдвэр гүйцэтгэгч барьцаалсан, битүүмжилсэн, хураан авсан эд хөрөнгийг хамгаалалтандаа авч байгаа ажиллагаа юм.

**Эд хөрөнгө үнэлэх.** Төлбөр төлөгчийн битүүмжлэх, барьцаалах, хураах, худалдан борлуулах эд хөрөнгийн чанар, хэрэгцээ, элэгдлийн байдал, эд хөрөнгийн талаарх төлбөр төлөгчийн саналыг харгалзан төлбөр төлөгчийн эд хөрөнгөнд шийдвэр гүйцэтгэгч, шинжээчээс тогтоож байгаа үнэлэмжийг ойлгоно.

**Эд хөрөнгийг хураах.** Шийдвэр гүйцэтгэгч тогтоосон хугацаанд төлбөрөө төлөөгүй төлбөр төлөгчийн барьцаалсан, битүүмжилсэн эд хөрөнгийг өөрийн мэдэлд авч байгаа үйл ажиллагааг ойлгоно.

**Үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдаа.** Иргэний болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан журмын дагуу шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэн, төлбөр төлөгчийн үл хөдлөх эд хөрөнгөөс шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэхээр явуулж байгаа үйл ажиллагааг ойлгоно.

**Хөдлөх эд хөрөнгийн үнэ хаялцуулсан дуудлага худалдаа.** Төлбөр төлөгчийн хураагдсан хөдлөх эд хөрөнгийг Иргэний хуульд заасан журмын дагуу үнэ хаялцуулан худалдаж, шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх үйл ажиллагааг ойлгоно.

**Эд хөрөнгийн мэдүүлэг.** Төлбөр төлөгч төлбөрийн чадваргүй, хөрөнгөгүй нь тогтоогдсон, эсхүл байгаа хөрөнгө нь төлбөрийг төлөхөд хүрэлцэхгүй байгаа, ирээдүйд бий болох хөрөнгийг тогтоох зорилгоор шийдвэр гүйцэтгэгч өөрийн санаачилгаараа буюу төлбөр авагчийн хүсэлтээр төлбөр төлөгчийн төлбөрийг гаргуулах зорилгоор хэрэгжүүлж байгаа албадах ажиллагааны төрөл юм.

**Өртэй этгээдийн бүртгэл.** Энэ нь албадах ажиллагааны нэг төрөлд хамаарах бөгөөд төлбөр төлөгчийн эд хөрөнгийн мэдүүлэг өгсөн байдал, эсхүл тогтоосон хугацаанд шалтгаангүйгээр мэдүүлэг өгөхөөс татгалзсан зэргийг харгалзан шийдвэр гүйцэтгэгч түүнийг өртэй этгээдийн бүртгэлд бүртгэнэ.



## Сэдвийн тойм

### **Шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг албадан хэрэгжүүлэхэд бэлтгэх бэлтгэл ажиллагаа, түүний эрх зүйн үр дагавар**

Шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг албадан хэрэгжүүлэхийн тулд шийдвэр гүйцэтгэгч дараахь албадах ажиллагааны төрлүүдээс сонгон ажиллагаа явуулж болно. Үүнд:

- төлбөр төлөгчид эд хөрөнгө байгаа эсэх талаар хуульд заасан журмаар мэдээлэл олж авах, төлбөр төлөгчийн мөнгөн хадгаламж болон харилцах данснаас хасалт хийх, эд хөрөнгө болон биед үзлэг, нэгжлэг хийх, эд хөрөнгийг битүүмжлэх, албадан барьцаалах (цаашид “барьцаалах” гэх), хураах, худалдан борлуулах
- төлбөр төлөгчөөс эд хөрөнгийн тухай мэдүүлэг авах, өртэй этгээдийн бүртгэлд бүртгэх
- төлбөр төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах бусад орлогоос суутгал хийлгүүлэх
- төлбөр төлөгчийн бусдад байгаа өмч хөрөнгөөс хуульд заасан журмын дагуу төлбөр гаргуулах
- шийдвэрт нэр заасан тодорхой эд хөрөнгийг төлбөр төлөгчөөс гаргуулж төлбөр авагчид шилжүүлэх, эсхүл тодорхой үйл ажиллагаа гүйцэтгүүлэх
- хуульд заасан бусад үйл ажиллагаа

## Үзлэг хийх

Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн эд хөрөнгийн хэмжээг тогтоох зорилгоор өөрт нь болон бусдын эзэмшилд байгаа түүний өмчлөлийн эд хөрөнгөд нэг бүрчлэн үзлэг хийнэ.

Төлбөр төлөгчийн эд хөрөнгөд үзлэг хийх ажиллагааг явуулахад Шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу хөндлөнгийн гэрчийг оролцуулна.

Энэхүү ажиллагааг явуулахад төлбөр төлөгч, эсхүл түүний гэр бүлийн насанд хүрсэн гишүүн, өмгөөлөгч, хэрэв боломжгүй бол нутгийн захиргааны, эсхүл цагдаагийн байгууллагын ажилтныг байлцуулна. Харин төлбөр төлөгч нь хуулийн этгээд бол уг хуулийн этгээдийн төлөөлөгчийг байлцуулна.

Шийдвэр гүйцэтгэгч хөрөнгөд үзлэг хийхдээ тэмдэглэл хөтөлнө.

### **Нэгжлэг хийх**

Төлбөр төлөгчийн эд хөрөнгөд үзлэг хийх, битүүмжлэх, барьцаалах, хураах явцад түүний биедээ буюу ямар нэг газар, эсхүл бусад этгээдэд нуусан эд хөрөнгийг илрүүлэх зорилгоор биед болон тухайн эд хөрөнгийг нуусан газарт нэгжлэг хийж болно. Төлбөр төлөгчийн биед болон эд хөрөнгөд нэгжлэг хийх үед бэлэн мөнгө олдсон бол төлбөрийн хэмжээнээс илүүгүй хэмжээгээр хураан авна.

Төлбөр төлөгчийн эд хөрөнгөд үзлэг хийх ажиллагааг явуулахад Шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу хөндлөнгийн гэрчийг оролцуулна.

Энэхүү ажиллагааг явуулахад төлбөр төлөгч, эсхүл түүний гэр бүлийн насанд хүрсэн гишүүн, өмгөөлөгч, хэрэв боломжгүй бол нутгийн захиргааны, эсхүл цагдаагийн байгууллагын ажилтныг байлцуулна.

Төлбөр төлөгч нь хуулийн этгээд бол уг хуулийн этгээдийн төлөөлөгчийг байлцуулна.

Шийдвэр гүйцэтгэгч хөрөнгөд нэгжлэг хийх үйл ажиллагааг явуулахдаа тэмдэглэл хөтөлнө.

### **Төлбөр төлөгчийн эд хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах, хураах**

Дараах үндэслэлээр төлбөр төлөгчийн эд хөрөнгийг битүүмжлэх буюу барьцаална. Үүнд:

- Эд хөрөнгийг төлбөр авагчид шилжүүлэх, эсхүл худалдан борлуулах, эд хөрөнгийг хамгаалах;
- Төлбөр төлөгчийн өөрт нь байгаа болон түүний өмчлөлийн бусдад байгаа эд хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах тухай шийдвэрийг гүйцэтгэх
- Төлбөр төлөгчийн болон түүний өмчлөлийн бусдад байгаа эд хөрөнгийг хураах тухай шийдвэрийг гүйцэтгэх

Төлбөр төлөгчийн эд хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах шийдвэрийг эд хөрөнгийн жагсаалт гарган данслах, шийдвэр гүйцэтгэгч хувийн дугаартай тэмдэг дарж уг эд хөрөнгийг хамгаалалтандаа авах, эсхүл авахгүйгээр тухайн эд хөрөнгийг захиран зарцуулахыг хориглох, шаардлагатай бол эд хөрөнгийг ашиглах эрхийг хязгаарлах зэргээр гүйцэтгэнэ. Шийдвэр гүйцэтгэгч эд хөрөнгө ашиглах эрхийг хязгаарлах хугацааг тогтоосон шийдвэр гаргана. Дээр дурьдсан эд хөрөнгийг захиран зарцуулахыг хориглосон, эсхүл түүнийг ашиглах эрхийг хязгаарлах тухай шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрийг төлбөр төлөгч зөрчсөн бол хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

Битүүмжилсэн, барьцаалсан эд хөрөнгийг худалдан борлуулах зорилгоор хураан авах хугацааг шийдвэр гүйцэтгэгч тогтооно. Тогтоосон хугацаанд төлбөрийг төлөөгүй бол битүүмжилсэн, барьцаалсан эд хөрөнгийг хураан авна.



Тогтоосон хугацаанд төлбөрийг төлсөн бол шийдвэр гүйцэтгэгч эд хөрөнгийг битүүмжилсэн, барьцаалсан шийдвэрээ хүчингүй болгоно. Шаардлагатай бол шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад эд хөрөнгийг битүүмжлэх, барьцаалахын хамт тухайн эд хөрөнгө болон түүний зарим бүрдэл хэсгийг хураан авч болно.

Гадаад валют, Монгол Улсын мөнгөн тэмдэгт, үнэт металл, эрдэнийн чулуу, тэдгээрээр хийсэн гоёл чимэглэл, түүх, соёлын хосгүй болон бусад үнэт дурсгалт зүйлийг заавал хураан авна. Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн эд хөрөнгийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасан дарааллаар битүүмжлэх буюу барьцаална.

### **Эд хөрөнгө хадгалах**

Шийдвэр гүйцэтгэгч битүүмжилсэн, барьцаалсан эд хөрөнгийг төлбөр төлөгч болон бусад этгээдэд хадгалуулж болох ба хадгалагч эд хөрөнгийг хадгалж, түүний бүрэн бүтэн байдлыг хангах үүрэгтэй. Энд “бусад этгээд” гэдэгт хэнийг хамааруулах вэ?, төлбөр авагчид хадгалуулж болох уу гэдэг асуудал маргаантай байдгийг анхааран судална уу? Төлбөр төлөгчөөс хураасан үнэт зүйл, үнэт металл, эрдэнийн чулуу, гадаад валютыг банкинд хадгалуулдаг.

### **Төлбөр төлөгчийн эд хөрөнгийг үнэлэх**

Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн эд хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах, хураахдаа түүний чанар, хэрэгцээ, элэгдлийн байдал болон төлбөр төлөгчийн саналыг харгалзан орон нутгийн зах зээлийн тухайн үеийн ханшаар үнэлж, энэ тухай оролцогч талуудад мэдэгдэж, тэмдэглэл хөтөлнө.

Дараах тохиолдолд эд хөрөнгийг шинжээчээр үнэлүүлнэ. Үүнд:

- Эдийн бус хөрөнгө
- Төлбөр төлөгч, төлбөр авагч, өмчлөгч Иргэний хуулийн 177.1-д заасны дагуу тохиролцоогүй бол үл хөдлөх эд хөрөнгө
- Үнэт зүйл
- Тухайн эд хөрөнгийг үнэлэхэд хүндрэл учирсан бол
- Шийдвэр гүйцэтгэгчээс тогтоосон үнэлгээг төлбөр төлөгч зөвшөөрөхгүй байгаа.

Төлбөр төлөгч, төлбөр авагч эд хөрөнгийн үнэлгээний талаарх гомдлоо үнэлгээ тогтоосон өдрөөс хойш 7 хоногийн дотор шүүхэд гаргаж болно. Холбогдсон маргааныг зөвхөн шүүх харьяалан хянаж шийдвэрлэх юм.

### Эд хөрөнгийг худалдан борлуулах

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 39.5-д зааснаас бусад эд хөрөнгийг худалдан борлуулах ажиллагааг түүнийг хураан авснаас хойш 2 сарын дотор гүйцэтгэнэ. Хүнсний болон хурдан гэмтэж муудах зүйлийг нэн даруй худалдана. Хураагдсан хөдлөх эд хөрөнгийг үнэ хаялцуулах албадан дуудлага худалдаагаар, үл хөдлөх эд хөрөнгийг энэ хуульд заасны дагуу үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдаагаар тус тус худалдан борлуулах бөгөөд үнэ хаялцуулах албадан дуудлага худалдааг Иргэний хуулийн 197 дугаар зүйлд заасан журмаар явуулна.

Галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх зүйлс, химийн хорт бодис зэрэг тусгай зөвшөөрлөөр олж авах зүйлийг шүүхийн шийдвэрийн дагуу холбогдох байгууллагад худалдах буюу шилжүүлнэ. Бие даасан шаардлага гаргах эрхтэй гуравдагч этгээд эд хөрөнгийг худалдан борлуулах ажиллагааг зөвшөөрөхгүй бол шүүхэд гомдлоо гаргана.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 1-д заасан хугацаанд буюу 2 сарын дотор худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөр төлөгчид мэдэгдэн үнэ хямдруулан худалдаж болно. Худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөр авагчид шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулахад гарсан зардлыг хасаж төлбөртөө тооцон авахыг санал болгоно. Хэрэв төлбөр авагч авахаас татгалзсан бол худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөр төлөгчид, гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид тус тус буцаана. Худалдан борлуулсан эд хөрөнгийн гэмтэл, согогтой холбогдон гарсан гомдлыг хүлээн авахгүй.

Харин үнэт цаас худалдах журмыг хуулиар тогтооно. Индоссанментээр шилжүүлэгдэж болох вексель буюу бусад төлбөрийн хэрэгслийг худалдах ажиллагаа нь шийдвэр гүйцэтгэгч уг төлбөрийн хэрэгслийг эзэмшилдээ авснаар гүйцэтгэгддэг.

### Төлбөр төлөгчөөс эд хөрөнгийн тухай мэдүүлэг авах тухай ойлголт, үндэслэл, журам

Шийдвэр гүйцэтгэгч санаачилгаараа буюу төлбөр авагчийн хүсэлтийг үндэслэн дараах тохиолдолд төлбөр төлөгчөөс эд хөрөнгийн тухай мэдүүлгийг авна. Үүнд:

- Төлбөр төлөгч хөрөнгөгүй нь тогтоогдсон, эсхүл байгаа эд хөрөнгө нь төлбөр төлж хүрэлцэхгүй бол
- Төлбөр төлөгчийн өмчлөлийн хөрөнгө бусдын эзэмшилд байгаа, эсхүл ирээдүйд буй болох бусад эд хөрөнгийн тухай
- Төлбөр төлөгч төлбөрийн чадваргүй.

Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчөөс эд хөрөнгийн тухай мэдүүлэг авах хугацааг товлож, энэ тухай төлбөр төлөгч, төлбөр авагчид мэдэгдэнэ. Төлбөр авагч ирээгүй нь уг мэдүүлгийг авахад саад болохгүй.



Төлбөр авагчийн шаардлагыг 6 сарын дотор хангаж чадахаа төлбөр төлөгч нотолсон бөгөөд төлбөр авагч төлбөрийг хэсэгчлэн төлүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч уг мэдүүлэг авах ажиллагааг дээр дурдсан хугацаагаар хойшлуулж, эд хөрөнгийн тухай мэдүүлэг авах өдрийг товлон тогтоодог.

Эд хөрөнгийн тухай мэдүүлэг авахаар товлосон өдөр төлбөр төлөгч төлбөрийн дөрөвний гурвыг төлсөн байвал төлбөр төлөгчийн хүсэлтээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 3-т заасан хугацааг шийдвэр гүйцэтгэгч дахин 2 сараар сунгаж болно.

Шийдвэр гүйцэтгэгч мэдүүлгийг үндэслэн төлбөр төлөгчийг өртэй этгээдийн бүртгэлд бүртгүүлж, төлбөр авагчид хуулбарыг хүргүүлнэ.

Өртэй этгээдийн бүртгэлд бүртгүүлснээс хойш төлбөр төлөгч эд хөрөнгөтэй болсон, эсхүл хөдөлмөрийн харилцаа нь өөрчлөгдсөн бол төлбөр авагчийн хүсэлтээр эд хөрөнгийн тухай дахин мэдүүлэг өгдөг.

### **Өртэй этгээдийн бүртгэл**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар нь улсын, шийдвэр гүйцэтгэх алба нь тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй этгээдийн талаарх мэдээллийг цахим тоолуурт оруулж, өртэй этгээдийн бүртгэл хөтлөх бөгөөд өртэй этгээдийн бүртгэл хөтлөх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтоосон байдаг.

Өртэй этгээдийн бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс хойш 7 хоногийн дараа тухайн этгээдийн талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

Өртэй этгээдийн бүртгэлд бүртгэгдсэн этгээдийн талаарх мэдээллийг дараах тохиолдолд бусдад өгч болно. Үүнд:

- Шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх
- Санхүү, эдийн засгийн хувьд найдвартай эсэхийг шалгуулах
- Зээл өгөх, авах гэж байгаа
- Эрүүгийн гэмт хэрэг илрүүлэх

Дараах үндэслэлээр өртэй этгээдийн бүртгэлээс хасна. Үүнд:

- Эд хөрөнгийн тухай мэдүүлгээ өгсөн
- Төлбөр авагчийн шаардлага хангагдаж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 82.1-д заасны дагуу шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг төлсөн бол

Шүүх, эрх бүхий бусад байгууллагын шийдвэрээр тогтоосон төлбөрийг төлөөгүй бол өртэй этгээдийн бүртгэлд бүртгэх, бүртгэлээс хасах, түүнээс мэдээлэл авахтай холбогдсон гомдлыг шүүх авч хэлэлцэхгүй.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 42.1-д заасан өртэй этгээдийн бүртгэлд бүртгэгдсэн төрийн захиргааны албан хаагч уг албанд болон сонгуульд нэр дэвшигчийн талаар Төрийн захиргааны албаны зөвлөл, Сонгуулийн ерөнхий хороонд тус тус мэдэгдэнэ.

### ХЯНАЛТЫН АСУУЛТ:

1. Шийдвэр гүйцэтгэлийн албадах ажиллагааны ойлголт, түүний төрөл тус бүрийг нэрлэнэ үү.
2. Төлбөр төлөгчийн эд хөрөнгөнд үзлэг хийх гэдгийг хэрхэн ойлгох вэ? Үзлэг хийх эрхтэй этгээдийг нэрлэнэ үү.
3. Үзлэг хийхэд баримтлах журам ямар байх вэ?
4. Төлбөр төлөгчийн биед болон эд хөрөнгөд нэгжлэг хийх гэдгийг хэрхэн ойлгох вэ? Нэгжлэг хийхэд баримтлах журмыг нэрлэнэ үү.
5. Төлбөр төлөгчийн эд хөрөнгийг битүүмжлэхэд ямар журам баримтлах вэ?
6. Төлбөр төлөгчийн эд хөрөнгийг барьцаалах гэдгийг хэрхэн ойлгох вэ?
7. Төлбөр төлөгчийн эд хөрөнгийг барьцаалахад баримтлах журам ямар байх вэ?
8. Төлбөр төлөгчийн эд хөрөнгийг хураах, түүнээс үүсэх эрх зүйн үр дагаврыг нэрлэнэ үү.
9. Төлбөр төлөгчийн эд хөрөнгийг үнэлэх явцад баримтлах журам ямар байх вэ?
10. Төлбөр авагч, төлбөр төлөгч эд хөрөнгийн үнэлгээний талаар гомдол гаргах эрх, түүнийг хянан шийдвэрлэх журмыг хэлэлцэнэ үү?
11. Эд хөрөнгө худалдан борлуулах гэдгийг хэрхэн ойлгох вэ? Ямар журам үйлчилдэг вэ?
12. Үнэ хаялцуулсан албадан дуудлага худалдааны журам ямар байх вэ?
13. Үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдааны журмыг тодорхойлж ярилцана уу.
14. Эд хөрөнгийн мэдүүлэг авах үндэслэлийг тодорхой жишээн дээр тайлбарлана уу.
15. Эд хөрөнгийн мэдүүлэг өгсөн болон өртэй этгээдийн бүртгэлд бүртгэснээс үүсэх хууль зүйн үр дагаврыг тодорхойлно уу.
16. Өртэй этгээдийн бүртгэл гэдгийг албадах ажиллагааны нэг төрөл гэдгээр нь авч үзэж тайлбарлана уу.



## **Бодлого**

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 5-р хорооны иргэн Нармандах Сүхбаатар дүүргийн шүүхэд нэхэмжлэл гаргажээ. Нармандах нэхэмжлэлдээ: Миний төрсөн дүү Аюур 2002 оны 9 дүгээр сард архи ууж танхайран өөрийн хамтран амьдрагч Нарангийн амь насыг хохироосон хэргийн учир 2003 оны 4 дүгээр сард 25 жилийн ял шийтгүүлж, 1.000.000 төгрөгийг ар гэрт нь төлөх болсон юм. Аюур нь хэрэгт холбогдох үедээ миний талийгаач ээж, аавынд амьдарч байсан ба хувьд нь ногдох эд хөрөнгөгүй, олон жил ял эдэлж байсан хүн юм. Гэтэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтнууд 2003 оны 11 дүгээр сарын 27-ний өдөр миний нэр дэр байдаг Чингэлтэй дүүргийн 11 дүгээр хороо, Нуурын 11-р гудамжны 145 тоот хашаа байшинг битүүмжилсэн байсан. Үүнийхээ үндэслэлийг тухайн үед Аюур энд оршин суудаг байсан учраас энэ хөрөнгөөр төлбөрийг төлөх ёстой, хэрэв төлөхгүй бол хашаа байшинг албадан дуудлага худалдаанд оруулна гэсэн. Дээрх хашаа байшин нь миний аав Ойдовын нэр байсан ба үүнээс бусад бүх хөрөнгийг Аюур үрэн таран хийсэн юм. Энэ хашаа байшин миний өмч, гэтэл шийдвэр гүйцэтгэх байгууллага намайг төлбөр төлөхөөс зайлсхийж байна гээд энэ хөрөнгө нь хэнийх вэ гэдгийг шалгалгүйгээр миний өмчлөх эрхэнд халдаж, эрх ашгийг хохироож байна. Иймд миний өмч болох хашаа байшинг хууль бус битүүмжлэлээс чөлөөлж өгнө үү? гэв.

Хариуцагч Нийслэлийн Шийдвэр гүйцэтгэх албаны Чингэлтэй дүүргийн ахлах шийдвэр гүйцэтгэгч Эрдэнэ, 126-р тойргийн шийдвэр гүйцэтгэгч Тулга нар нэхэмжлэлийг эс зөвшөөрч, тайлбарлахдаа: Нийслэлийн шүүхийн 2003 оны 43 дугаар тогтоолоор нэхэмжлэгч Нармандахын төрсөн дүү Аюур хохирогч Нарангийн оршуулгын зардалд 1 000 000 (нэг сая) төгрөг төлөхөөр болсон боловч өөрөө ял эдэлж байгаа юм. Энэ тогтоолын дагуу Чингэлтэй дүүргийн 11 дүгээр хороо, Нуурын 11-р гудамжны 145 тоот хашаа байшинд хэн амьдарч байсныг хорооны Засаг даргаас тодруулахад, төлбөр төлөгч Аюур оршин сууж байсан гэж тодорхойлолт гаргасан. Мөн түүнчлэн Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газарт албан бичиг явуулсан боловч хариу ирээгүй тул актаар битүүмжилсэн. Хэрэв Нармандах дээрх 1.000.000 төгрөгийг төлчих юм бол заавал хашаа байшингаар төлүүлнэ гээд байхгүй. Энэ төлбөр нь оршуулгын зардал учраас төлөхийг шаардсан юм гэв.

Энэ тохиолдолд:

1. Төлбөр төлөгчийн шүүхэд гаргасан нэхэмжлэл үндэслэлтэй эсэхийг хууль зүйн талаас нь тайлбарлаж, шүүхээс гаргах шийдвэрийн тогтоох хэсгийн агуулгыг илэрхийлнэ үү.

## Сорил

1. Төлбөр төлөгчийн эд хөрөнгөд үзлэг, нэгжлэг хийхэд хөндлөнгийн гэрч оролцох уу.
  - a. Хөндлөнгийн 1 гэрчийг заавал байлцуулна
  - b. Хөндлөнгийн 2-оос доошгүй гэрчийг заавал байлцуулна
  - c. Хөндлөнгийн гэрчийг заавал байлцуулах эсэхийг шийдвэр гүйцэтгэгч өөрөө шийдвэрлэнэ.
  - d. Хөндлөнгийн 3 ба түүнээс дээш гэрч байлцуулна
  
2. Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн эд хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах, хураахдаа түүний чанар, хэрэгцээ, элэгдлийн байдал болон \_\_\_\_\_ орон нутгийн зах зээлийн тухайн үеийн ханшаар үнэлж, энэ тухай оролцогч талуудад мэдэгдэж, тэмдэглэл хөтөлнө.
  - a. Төлбөр төлөгчийн саналыг харгалзана
  - b. Төлбөр төлөгчийн саналыг харгалзах шаардлагагүй
  - c. Төлбөр төлөгч болон төлбөр авагчийн аль алины саналыг авна
  - d. Төлбөр авагчийн саналыг авна.
  
3. Төлбөр төлөгчийн эд хөрөнгийг битүүмжлэх буюу барьцаалах үндэслэлд аль нь хамаарахгүй вэ?
  - a. Эд хөрөнгийг төлбөр авагчид шилжүүлэх, эсхүл худалдан борлуулах, эд хөрөнгийг хамгаалах;
  - b. Төлбөр төлөгчийн өөрт нь байгаа болон түүний өмчлөлийн бусдад байгаа эд хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах тухай шийдвэрийг гүйцэтгэх
  - c. Төлбөр төлөгчийн болон түүний өмчлөлийн бусдад байгаа эд хөрөнгийг хураах тухай шийдвэрийг гүйцэтгэх
  - d. Тухайн эд хөрөнгийг үнэлэхэд хүндрэл учирсан бол
  
4. Эд хөрөнгийн тухай мэдүүлэг авахуулахаар санал гаргах эрхтэй этгээдийг нэрлэнэ үү.
  - a. Төлбөр төлөгчийн хүсэлтээр
  - b. Зөвхөн төлбөр авагчийн хүсэлтээр
  - c. Шийдвэр гүйцэтгэгч санаачлагаараа буюу төлбөр авагчийн хүсэлтээр
  - d. Зөвхөн шийдвэр гүйцэтгэгчийн санаачилгаар



5. Өртэй этгээдийн бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс хойш хэд хоногийн дараа тухайн этгээдийн талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэх вэ?
  - a. 7    b.14
  - c.10    d. 5
  
6. Өртэй этгээдийн бүртгэлд бүртгэгдсэн этгээдийн талаарх мэдээллийг бусдад өгч болох үндэслэл. (Үл хамаарахыг ол)
  - a. Шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх
  - b. Захиргааны зөрчлийг илрүүлэх зорилгоор
  - c. Зээл өгөх, авах гэж байгаа
  - d. Санхүү, эдийн засгийн хувьд найдвартай эсэхийг шалгуулах
  
7. Төлбөр төлөгчөөс хураасан үнэт зүйл, үнэт металл, эрдэнийн чулуу, гадаад валютыг ..... хадгалуулна.
  - a. Төлбөр авагчид
  - b.Төлбөр төлөгчид өөрт нь
  - c. Банкинд
  - d. Шийдвэр гүйцэтгэгчийн санаачилгаар гэрээний үндсэн дээр бусад этгээдэд
  
8. Индосаммент гэж юу вэ?
  - a. үнэт цаас    b.чек, вексель    c.тэмдэглэгээ
  
9. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хураасан эд хөрөнгийг үнэлүүлэхээр шийдвэр гүйцэтгэгч өөрийн санаачилгаар шинжээч томилжээ. Дүгнэлт хийнэ үү?
  - a. Үндэслэлтэй зөв
  - b. Тухайн үнэлгээний талаар маргаан гарсан тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч өөрөө үнэлэх тул үндэслэлгүй
  - c. Зөвхөн төлбөр авагч, төлбөр төлөгчийн хүсэлтээр шинжээчийг томилох эсэхийг шийдвэрлэх тул үндэслэлгүй.
  
10. Төлбөрт хураагдсан эд хөрөнгийн талаар гуравдагч этгээд шийдвэр гүйцэтгэх байгууллагад гомдол гаргасан бол:
  - a. Ахлах шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлнэ.
  - b. Шүүгчийн захирамжаар шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлнэ
  - c. Ерөнхий шийдвэр гүйцэтгэгч гомдлыг хянах тул шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлнэ
  - d. Харьяаллын дагуу шүүх шийдвэрлэнэ

**СЭДВИЙН НОМ ЗҮЙ****Эрх зүйн баримт бичгүүд**

1. Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992 он
2. Монгол Улсын Иргэний хууль. УБ., 2002 он
3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. УБ., 2002 он
4. Монгол Улсын Эрүүгийн хууль холбогдох заалтууд УБ., 2002 он
5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарим зүйл, хэсэг тайлбарлах тухай. МУДШ-ийн 2007 оны 43 дугаар тогтоол.
6. Өртэй этгээдийн бүртгэл хөтлөх журам. ХЗДХСайдын 2002 оны 251 дүгээр тушаалын хавсралт.
7. Худалдан борлогдоогүй хөдлөх эд хөрөнгийг үнэ хямдруулан худалдан борлуулах журам. ХЗДХС-ын 2002 оны 296 дугаар тушаалын хавсралт.
8. Үнэ хямдруулан худалдан борлуулах журам. ХЗДХС-ын тушаал. Д: 150 2010 он
9. Үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалгааг зохион байгуулж явуулах журам. ШШГЕГ-ын даргын 2002 оны А/172 дугаар тушаалын хавсралт.
10. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуулийг хэрэгжүүлэхүйл ажиллагаанд хэрэглэх хэвлэмэл маягтуудын жагсаалт. ШШГЕГ-ын даргын 2002 оны А/123 дугаар тушаалын хавсралт.

**Сурах бичиг, гарын авлага**

1. Б.Дашзэвэг. Монгол Улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй. УБ. 2003, 2004 он
2. О. Алтангэрэл, Ш.Эрдэнэбат. Шийдвэр гүйцэтгэгчийн ном. УБ., 2004 он
3. В.Шаллер. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа. УБ., 2004 он
4. В.Шаллер. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн сургалтын материал. УБ., 2007 он
5. Д.Х. Валеев. Исполнительное производство. Москва., 2010 г
6. Исполнительное право. Отв. Ред. И.В. Решетникова. Москва., Норма, 2011г
7. М.С.Шакарян. Гражданское процессуальное право Москва., Юристь, 2002
8. В.В Ярков. Гражданский процесс. Москва., 2001
9. Под. Ред. М.К.Треушников. Гражданский процесс. Москва., 2000



## СЭДЭВ.2.3. ТӨЛБӨР ТӨЛӨГЧ ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭС ТӨЛБӨР ГАРГУУЛАХ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТ, ОНЦЛОГ, ТӨЛБӨР ГАРГУУЛАХ ДАРААЛАЛ

### (Лекц 4 цаг)

Сэдвийн зорилго: Төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааны онцлог, тэдгээрийн өмчлөлийн болон бусдад байгаа эд хөрөнгөнөөс төлбөр гаргуулах дараалал, төлбөрт хурааж болохгүй эд хөрөнгө, орлогын талаар мэдлэг эзэмшсэнээр энэ талаарх хуулийг практикт зөв хэрэглэх, иргэн хуулийн этгээдийн эрхийг хамгаалах чадвартай болно.

### Сэдвийн агуулга:

- Төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдийн өмчлөлийн эд хөрөнгөөс төлбөр гаргуулах журам
- Төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдийн банкны болон банкны бус санхүүгийн байгууллага дахь хадгаламжийн болон харилцах данснаас суутгал хийх
- Төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдийн үүргийн гүйцэтгэлд барьцаалсан эд хөрөнгөөс төлбөр гаргуулах
- Төлбөр төлөгч иргэний төлбөрт хурааж болохгүй эд хөрөнгө, орлого
- Төлбөр төлөгч хуулийн этгээдийн эд хөрөнгийг битүүмжлэх дараалал
- Төсөвт байгууллагын эд хөрөнгөнөөс төлбөр гаргуулах
- Хуулийн этгээд татан буугдах болон дампуурах үед түүний эд хөрөнгөөс төлбөр гаргуулах ажиллагаа

### Нэр томъёоны тайлбар:

**Төлбөр төлөгч иргэн.** Төлбөр авагчийн эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг зөрчсөн буюу үүргээ биелүүлээгүй гэж гүйцэтгэх баримт бичигт заасан иргэнийг хэлнэ.

**Төлбөр төлөгч хуулийн этгээд.** Төлбөр авагчийн эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг, сонирхлыг зөрчсөн буюу үүргээ биелүүлээгүй гэж гүйцэтгэх баримт бичигт заасан хуулийн этгээдийг хэлнэ.

**Төлбөр гаргуулж болохгүй эд хөрөнгө, орлого.** Төлбөр төлөгч иргэний зайлшгүй хэрэгцээт эд хөрөнгө, орлогыг хэлнэ.

**Төлбөр төлөгч хуулийн этгээдийн эд хөрөнгийг битүүмжлэх дараалал.** Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгч хуулийн этгээдийн өмчлөлийн эд хөрөнгийг битүүмжилж төлбөр гаргуулахад баримтлах журам.

**Үүргийн гүйцэтгэлд барьцаалсан эд хөрөнгө.** Үүрэг гүйцэтгүүлэгчийн үүргийн гүйцэтгэл, шаардлагыг хангуулахын тулд үүрэг гүйцэтгүүлэгчээс барьцаанд тавьсан түүний өмчлөлийн эд хөрөнгө.

**Дампуурал.** Төлбөрийн чадваргүй болсон нөхөрлөл, хоршоо, компани, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, хуулийн этгээдийн эрх бүхий төрийн бус байгууллагыг дахин хөрөнгөжүүлэх тухай хүсэлтийг тухайн хуулийн этгээд, нэхэмжлэгчид, хэрэг гүйцэтгэгч шүүхэд гаргаагүй, шүүх дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг батлаагүй, эсхүл төлөвлөгөөг ирүүлээгүй, мөн түүнчлэн төлөвлөгөөг биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд шүүхээс тухайн хуулийн этгээдийг дампуурсанд тооцож, шийдвэр гаргана.

### **Сэдвийн тойм**

Төлбөр төлөгч иргэний өмчлөлийн эд хөрөнгөөс төлбөр гаргуулах журам

Төлбөрийг төлбөр төлөгч-иргэн ямар эд хөрөнгөө төлбөрт өгөх тухай хүсэлтээ тавих эрхтэй. Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгч иргэний өмчлөлийн эд хөрөнгө болох түүний банк, банк бус санхүүгийн байгууллага дахь хадгаламжийн болон харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгө, үнэт цаас, түүнчлэн үл хөдлөх ба хөдлөх эд хөрөнгө, бусад хөрөнгөнөөс гаргуулна.

Гүйцэтгэх баримт бичгийг үндэслэн эхний ээлжинд бэлэн мөнгө, эсхүл банк, банк бус санхүүгийн байгууллага дахь хадгаламжийн болон харилцах дансанд байгаа төлбөр төлөгчийн мөнгөн хөрөнгө болон бусад үнэт зүйлээс төлбөрийг гаргуулахдаа төлбөр төлөгчийн банк, банкны бус санхүүгийн байгууллага дахь хадгаламжийн болон харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгөөс төлбөр гаргуулах мэдэгдлийг зохих банк, банкны бус санхүүгийн байгууллагад хүргүүлнэ.

Мэдэгдлийг үндэслэн тухайн банк, банкны бус санхүүгийн байгууллага нь төлбөр төлөгчийн данснаас төлбөрийг гаргаж 3 хоногийн дотор төлбөр авагчид олгох буюу мэдэгдэл өгсөн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд шилжүүлнэ. Нэхэмжлэлийн шаардлага хангах хэмжээний мөнгөн хөрөнгө төлбөр төлөгчийн хадгаламжийн болон харилцах дансанд байхгүйн улмаас мэдэгдэлд заасан шаардлагыг хэсэгчлэн биелүүлсэн, эсхүл бүрэн биелүүлэх боломжгүй талаар мэдэгдэнэ.

Төлбөр төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах бусад орлого нь банк, банкны бус санхүүгийн байгууллага дахь хадгаламжийн болон харилцах дансанд ордог бол төлбөр гаргуулж болохгүй орлогыг хасаж төлбөрийг шилжүүлнэ.

Төлбөр төлөгчийн мөнгөн хөрөнгө болон үнэт эд зүйл байхгүй, эсхүл төлбөр төлөхөд хүрэлцэхгүй бол түүний өмчлөлийн бусад эд хөрөнгөнөөс (өвийн хөрөнгө, хуулийн этгээдэд оруулсан хөрөнгө) төлбөрийг гаргуулна.



Эд хөрөнгө төлбөр төлөхөд хүрэлцэхгүй байвал төлбөр төлөгчийн дундаа хэсгээр буюу хамтран өмчлөх эд хөрөнгийн төлбөр төлөгчид ногдох хэсгээс төлбөрийг гаргуулна. Энэ тохиолдолд Монгол Улсын Иргэний хуулийн зохицуулалтыг удирдлага болгоно.

Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн өмчлөлийн хөрөнгө, мөнгө бусдад байгаа эсэхийг тодруулж, хэрэв байвал түүнээс төлбөрт шаардагдах хэмжээгээр гаргуулна.

Төлбөр төлөгчийн өмчлөлийн бусдад байгаа эд хөрөнгөөс төлбөр гаргуулахдаа хөндлөнгийн хоёроос доошгүй гэрчийг оролцуулна.

Төлбөр төлөгчийн банк, банкны бус санхүүгийн байгууллага дахь хадгаламжийн болон харилцах дансанд байгаа үнэт металл, эрдэнийн чулуу, үнэт цаас, бэлэн мөнгө, түүнчлэн төлбөр төлөгчөөс бусдад, бусдаас төлбөр төлөгчид бэлэн ба бэлэн бусаар шилжүүлсэн хоорондын төлбөр тооцооны мөнгөнөөс төлбөрийг гаргуулж болно.

## **Төлбөр төлөгч иргэний төлбөрт хурааж болохгүй эд хөрөнгө, орлого**

**Төлбөр төлөгч иргэний зайлшгүй хэрэгцээт дараах эд хөрөнгийг төлбөрт хураан авч болохгүй.**

Зайлшгүй хэрэгцээт хоол, хүнс, гал тогооны хэрэгсэл

Төлбөр төлөгч болон түүний гэр бүлийн гишүүний улирал бүрийн нэг ээлжийн хувцас

Хүйтний улиралд хэрэглэх түлээ, түлш

Мал аж ахуй болон газар тариалан эрхэлдэг бол амьжиргааны наад захын хэрэгцээг хангах тооны мал, тариалах үр

Төлбөр төлөгч иргэн мэргэжлийнхээ ажил, үйлдвэрлэл явуулахад зайлшгүй шаардагдах эд юмс. Эдгээр эд юмсын үнэ нь гүйцэтгэх баримт бичигт дурдсан төлбөрийн хэмжээнээс өндөр байвал уг эд юмсыг орлуулах үнэ хямд зүйлээр сольж болно.



## Төлбөр төлөгч хуулийн этгээдийн эд хөрөнгөөс төлбөр гаргуулах журам

Төлбөр төлөгч нь хуулийн этгээд бол шийдвэр гүйцэтгэгч:

1. Хуулийн этгээдийн банк, банкны бус санхүүгийн байгууллага дахь хадгаламжийн болон харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгөөс төлбөр гаргуулах мэдэгдлийг шийдвэр гүйцэтгэгч тухайн банк, банкны бус санхүүгийн байгууллагад хүргүүлнэ.
2. Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн эд хөрөнгөд үзлэг, нэгжлэг явуулна. Энэхүү ажиллагааны явцад бэлнээр хадгалагдаж байгаа мөнгөн хөрөнгө илэрвэл түүнийг хураан авна.
3. Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн бэлнээр хадгалагдаж байгаа буюу банк, банкны бус санхүүгийн байгууллага дахь дансанд байгаа мөнгөн хөрөнгийг хуульд заасан журмаар битүүмжлэх арга хэмжээ авч болно.
4. Төлбөр төлөгч нь банк бол тухайн арилжааны банкны Монголбанк дахь харилцах данснаас хасалт хийх буюу төлбөрийн шаардлагын хэмжээгээр дансны зарлагын гүйлгээг битүүмжлэн төлбөрийг гаргуулна.



5. Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн өмчлөлийн мөнгөн болон бусад эд хөрөнгө бусдад байгаа эсэхийг тодруулж, хэрэв байвал түүнээс төлбөрт шаардагдах хэмжээгээр гаргуулна.
6. Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн банкин дахь харилцах данс, хадгаламжид байгаа үнэт металл, эрдэнийн чулуу, үнэт цаас, мөнгө, түүнчлэн төлбөр төлөгчөөс бусдад, бусдаас төлбөр төлөгчид бэлэн ба бэлэн бусаар шилжүүлсэн хоорондын төлбөр тооцооны мөнгөнөөс төлбөр гаргуулж болно.
7. Төлбөр төлөгч хуулийн этгээд нийлэх, нэгдэх, тусгаарлах, хуваагдах, өөрчлөх замаар өөрчлөн зохион байгуулагдсан тохиолдолд Иргэний хуульд заасны дагуу төлбөр төлөгч хуулийн этгээдийн эрх, үүргийг залгамжлан авсан хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгө болон бусад эд хөрөнгөөс төлбөр гаргуулна.
8. Төлбөр төлөгч-хуулийн этгээд татан буугдах, дампуурах зэргээр үйл ажиллагааг нь зогсоох үед гүйцэтгэх баримт бичгийг татан буулгах комисс буюу дампуурлын хэрэг гүйцэтгэгчид шилжүүлнэ.
9. Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн эд хөрөнгийг битүүмжлэх дарааллыг тогтоосон хуулийн заалтыг заавал удирдлага болгохыг анхаарах шаардлагатай. Хэрэв аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлж болохоор хуульд тусгайлан заасан бол тусгай зөвшөөрлийг битүүмжилж болно. Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгч хуулийн этгээдийн үл хөдлөх эд хөрөнгийг хуульд заасны дагуу битүүмжилснээс хойш 3 хоногийн дотор уг байгууллагын үл хөдлөх эд хөрөнгийг битүүмжилсэн тухай мэдэгдлийг Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газарт хүргүүлнэ.

Мэдэгдэлд уг үл хөдлөх эд хөрөнгийн үнэ, тоо хэмжээ, байршил, төлбөр авагчийн шаардсан мөнгөн дүнгийн тухай мэдээг хавсаргана. Мэдэгдлийн хуулбарыг татварын байгууллагад явуулна.

Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийг хийх эрх бүхий байгууллага нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсан бол тухайн битүүмжлэгдсэн үл хөдлөх эд хөрөнгө эрхийн улсын бүртгэлд бүртгэгдсэн эсэхийг тодорхойлсон лавлагааг 3 хоногийн дотор шийдвэр гүйцэтгэх байгууллагад өгнө.

### **Үүргийн гүйцэтгэлд барьцаалсан эд хөрөнгө**

Үүргийн гүйцэтгэлд барьцаалсан эд хөрөнгийг төлбөр төлөгч бусдад шилжүүлсэн бол уг эд хөрөнгө хэний эзэмшилд шилжсэнийг үл харгалзан түүнээс төлбөр гаргуулна.

Төлбөр төлөгчийн эд хөрөнгө төлбөр төлөхөд хүрэлцэхгүй бол түүний өмчлөлийн бусдад барьцаалсан эд хөрөнгөөс төлбөр гаргуулж болно. Энэ тохиолдолд

барьцаалагч тэргүүн ээлжинд хохирлоо арилгуулах эрх эдэлнэ. Барьцаалагч бусад үүрэг гүйцэтгүүлэгчдийн төлбөрийг барагдуулах үүрэг хүлээнэ.

### ХЯНАЛТЫН АСУУЛТ:

1. Төлбөр төлөгч иргэн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны явцад эдлэх эрх, хүлээх үүргийг дурьдана уу.
2. Төлбөр төлөгч иргэний банк болон банкны бус санхүүгийн байгууллага дахь харилцах болон хадгаламжийн данснаас суутгал хийлгүүлэх үндэслэл, журмын талаарх ойлголтоо ашиглаж тодорхой тохиолдол зохионо уу.
3. Төлбөр төлөгч иргэний өөрийн өмчлөлийн болон бусадтай хамтран өмчилдөг эд хөрөнгө болон түүний өмчлөлийн бусдад байгаа эд хөрөнгөнөөс төлбөр гаргуулах журмыг иргэний эрх зүйтэй холбон тайлбарлана уу.
4. Төлбөрт хурааж болохгүй эд хөрөнгө, орлогыг хуульд тусгайлан заасны ач холбогдлыг хэрхэн ойлгож байна вэ?
5. Төлбөр төлөгч хуулийн этгээдийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны явцад эдлэх эрх, хүлээх үүргийг нэрлэнэ үү.
6. Төлбөр төлөгч хуулийн этгээдийн банк болон банкны бус санхүүгийн байгууллага дахь харилцах данснаас суутгал хийх үндэслэл, журмын талаар тайлбарлана уу.
7. Төлбөр төлөгч хуулийн этгээдийн эд хөрөнгийг битүүжлэх дараалал, түүнийг тогтоосны ач холбогдлыг тодорхойлно уу.
8. Хуулийн этгээд татан буугдах болон дампуурах үеийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны онцлог ямар байх вэ?
9. Эзэн хаяг нь тогтоогдохгүй байгаа төлбөрт гаргуулсан мөнгөн хөрөнгийг хэрхэн шийдвэрлэх вэ?
10. Хэд хэдэн төлбөр авагчийн шаардлагыг хэрхэн хангах вэ?

### Бодлого

Нийслэлийн Баянгол дүүргийн иргэн Н Сүхбаатар дүүргийн шүүхэд нэхэмжлэл гаргахыг хүсчээ. Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны шийдвэр гүйцэтгэгч А иргэн Н-д холбогдох шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг явуулахдаа түүний гэрт нь байсан зөөврийн компьютер, ангийн буу, өнгөт телевизор зэргийг хураажээ. Н нэгэн өдөр тутмын сонинд сэтгүүлчээр ажилладаг ба эхнэр, 2 охины хамт амьдардаг.



Энэ тохиолдолд:

Шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд дүгнэлт хийж, Н-ээс шүүхэд гаргах нэхэмжлэлийн үндэслэлийг тодорхойлж өгнө үү.

### Сорил

1. Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгч иргэн “Б”-ээс төлбөр гаргуулахдаа түүний эзэмшилд байсан газрыг үл хөдлөх хөрөнгийн албадан дуудлага худалдаагаар худалджээ. Албадан дуудлага худалдааны орлогоос үлдэгдэл 300 мянган төгрөгийг Б-д шилжүүлэн өгчээ.

Энэ тохиолдолд:

- a. Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа хуулийн дагуу явагдсан.  
Учир нь: \_\_\_\_\_
  - b. Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа хууль зөрчсөн. Учир нь:
2. Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгч иргэн “Д”-ийн банк, банкны бус санхүүгийн байгууллага дахь хадгаламжийн болон харилцах дансанд бэлэн мөнгө байхгүй байсан учир “Д”-ийн өвлийн улиралд өмсдөг булган дээлийг төлбөрт гаргуулахаар хураан авсан ба түүнийг худалдан борлуулсны эцэст өвлийн зориулалтай хувцас авахад шаардлагатай мөнгийг “Д”-д буцаан олгожээ.
    - a. Шийдвэр гүйцэтгэгчийн ажиллагаа хууль бус учир нь төлбөр төлөгч иргэний төлбөрт хураан авч болохгүй эд хөрөнгийг хураан авсан байна.
    - b. Шийдвэр гүйцэтгэгчийн ажиллагаа хуулийн дагуу явагджээ. Учир нь өвлийн булган дээлийн зах зээл дэх үнэ нь өндөр тул орлуулах үнэ хямд зүйлээр сольж болно.
    - c. Дээрх 2 хариулт буруу
  3. Төлбөр төлөгч “Сайхан саруул” ХХК нь нэг хувьцаа эзэмшигчтэй. Тус компанийн эд хөрөнгө нь төлбөр төлөхөд хүрэлцэхгүй байсан тул компанийн захирал Н-ийн эд хөрөнгөнөөс төлбөр гаргуулахаар түүний банкин дахь хадгаламжийн данснаас төлбөр гаргуулах мэдэгдлийг хүргүүлжээ. Н үүнийг эс зөвшөөрч гомдол гаргасан.
    - a. “Саруул сайхан” ХХК нь нэг хувьцаа эзэмшигчтэй тул захирлын эд хөрөнгөнөөс төлбөрийг гаргуулж болно.
    - b. “Саруул сайхан” ХХК-ийн захирлын эд хөрөнгөнөөс төлбөрийг гаргуулж болохгүй.

- с. Хуульд заасан тохиолдолд зөвхөн “Саруул сайхан” ХХК-ийн захирлын эд хөрөнгөнөөс төлбөрийг гаргуулж болно.
4. Шийдвэр гүйцэтгэгч “Хонхон” ХХК-ийн эд хөрөнгө төлбөр төлөхөд хүрэлцэхгүй байна гэсэн үндэслэлээр тус компанийн өмчлөлийн банкинд барьцаалсан үл хөдлөх эд хөрөнгөөс төлбөр гаргуулахаар болжээ. Уг үл хөдлөх эд хөрөнгийг албадан дуудлага худалдаагаар худалдан борлуулж төлбөрийг гаргуулсны эцэст үлдэгдэл мөнгөнөөс банк барьцааны үүргээ шаардах эрхтэй гэжээ. Банк шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрийг эс зөвшөөрөв. Дүгнэлт хийнэ үү.
- а. Шүүхийн шийдвэр гарч шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа хийгдэж байгаа тул эхлээд шүүхийн шийдвэрт заагдсан төлбөрийг гаргуулах нь зөв
- б. Банк тухайн үл хөдлөх эд хөрөнгийг барьцаалсан байсан тул эхний ээлжинд төлбөрөө гаргуулах нь хуульд нийцнэ.
- с. Хэд хэдэн төлбөр авагч байгаа тул төлбөр авагч нэг бүрийн авах төлбөрийн хэмжээгээр хувь тэнцүүлэн мөнгийг хуваарилна.
- д. Албадан дуудлага худалдаа явуулсан зардлыг эхний ээлжинд гаргуулах тул а,б,с дэх хариултууд буруу.
5. Төлбөр төлөгч иргэн С нь цалингаасаа нийгмийн даатгалын шимтгэл, татвараа төлсний эцэст бэлнээр 500 000 төгрөгний цалин авдаг. Шийдвэр гүйцэтгэгч шийдвэрийг богино хугацаанд түргэн гүйцэтгээгүйгээс хугацаа хэтэрлээ гэсэн шаардлага тавьж, С-ийн цалингаас сар бүр 400 000 төгрөгийг гаргуулан 5 сарын хугацаанд төлбөрийг барагдуулахаар болжээ. Шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд дүгнэлт хийнэ үү.
- а. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хугацаа зөрчигдсөн тул шийдвэр гүйцэтгэгчийн авсан арга хэмжээ нь хуульд нийцнэ.
- б. Шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэр нь хууль бус байна. Учир нь иргэнд сард хэрэглэх амьжиргааных нь мөнгийг үлдээх хэрэгтэй.
- с. Шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэр нь хууль бус. С-ийн цалингаас сар бүр 250 000 төгрөгийг л гаргуулах үндэслэлтэй.
6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр төлөгч хуулийн этгээд дампуурч, үйл ажиллагаа нь зогссон тул ахлах шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох тухай төлбөр авагчид мэдэгдсэн байна. Дүгнэлт хийнэ үү.
- а. Зөв
- б. Буруу



## СЭДЭВ.2.4. ТОДОРХОЙ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭХИЙГ ДААЛГАСАН БОЛОН ГЭР БҮЛИЙН ХОЛБОГДОЛТОЙ ХЭРЭГ МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ АЛБАДАН ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА

### *(Семинар 2 цаг)*

Сэдвийн зорилго: Иргэний хэргийн шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагааны хүрээнд олж авсан онолын мэдлэгтээ тулгуурлан барилга орон байрнаас албадан нүүлгэн гаргах, ажилтныг ажилд нь эгүүлэн тогтоох, гэр бүлийн холбогдолтой хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэхэд хэрэглэгдэх хууль тогтоомжийн онцлог зохицуулалтыг судалж, бусдад тайлбарлан таниулах, дэмжлэг тусалцаа үзүүлэх чадварыг эзэмшинэ.

### *Сэдвийн агуулга:*

- Барилга орон байрнаас албадан нүүлгэн гаргах шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаа
- Ажилтныг ажилд нь эгүүлэн тогтоосон шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа
- Гэр бүлийн гэр бүлийн холбогдолтой хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагааг

### *Нэр томьёоны тайлбар:*

**Барилга, орон байрнаас нүүлгэн гаргах.** Гүйцэтгэх баримт бичигт заасан барилга, орон байрыг нүүн гарах этгээд, түүнтэй хамтран амьдарч байгаа гэр бүлийн гишүүн, тэдгээрийн эд хөрөнгө, гэрийн тэжээвэр амьтдаас чөлөөлж, нүүн гарсан этгээдэд чөлөөлөгдсөн барилга, орон байрыг ашиглахыг хориглох ажиллагаа.

**Үндэслэлгүйгээр ажлаас халагдсан ажилтан.** Шүүхийн шийдвэрээр ажил олгогчийн санаачилгаар хууль зүйн үндэслэлгүйгээр ажлаас халагдсан гэж эрхэлж байсан ажилдаа эгүүлэн тогтоогдсон гүйцэтгэх баримт бичигт дурьдагдсан ажилтныг хэлнэ.

**Үндэслэлгүйгээр өөр ажилд шилжүүлсэн ажилтан.** Шүүхийн шийдвэрээр ажил олгогчийн санаачилгаар, хууль зүйн үндэслэлгүйгээр ажилтны хөдөлмөрийн гэрээний гол нөхцөлүүд бүхэлдээ буюу зарим хэсэг түр хугацаагаар өөрчлөгдөж, солигдсон гэдэг нь тогтоогдсон ажилтныг ойлгоно.

**Албадан гүйцэтгэх тухай мэдэгдэл.** Үндэслэлгүйгээр ажлаас халагдсан буюу өөр ажилд шилжүүлсэн ажилтныг урьдах ажил, албан тушаалд нь эгүүлэн тогтоох тухай шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй тохиолдолд шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэхээр ажил олгогчид хүргүүлсэн баримт бичгийг хэлнэ.

**Хүүхдийн тэтгэлэг.** Насанд хүрээгүй болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдэд тэжээн тэтгэх үүргээ биелүүлж, шүүхийн шийдвэрээр хүүхдийнхээ хэрэгцээнд зориулан олгож байгаа мөнгөн хөрөнгө, эд хөрөнгийг хэлнэ.

**Хүүхдийн эцэг, эх.** Хүүхэд төрснөөр, хүүхдийг үрчлэн авснаар, гэрлэгчдийн хэн нэг нь дагавар хүүхэдтэй бол эцэг эх, хүүхдийн харилцаа үүснэ.

**Хүүхдийн асран хамгаалагч.** Эд хөрөнгийн зохих бололцоотой төрөл, садан буюу төрөл, садан бус хүний бичгээр гаргаж, нотариатаар гэрчлүүлсэн зөвшөөрлийг үндэслэн сум дүүргийн Засаг дарга (бага насны, 14 нас хүрээгүй бүтэн өнчин хүүхэд, эцэг эх нь хоёулаа иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй буюу хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон болон эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан хүний бага насны хүүхэд, эцэг, эх нь хоёулаа удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүүлж байгаа, хорих газарт ял эдэлж байгаа зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар хүүхдэд биечлэн тэжээн тэтгэх, асран хамгаалах бололцоогүй хүний бага насны хүүхэд) асран хамгаалагчаар тогтоохыг хориглосон хүнээс бусад этгээдийг тогтоосныг ойлгоно.

**Хүүхдийн харгалзан дэмжигч.** Эд хөрөнгийн зохих бололцоотой төрөл, садан буюу төрөл, садан бус хүн байна.

**Хүүхдийн тэтгэлэг гаргуулах тухай шүүхийн шийдвэр.** Шүүх хүүхдийн нас, эцэг эхийн халамж, ахуйн нөхцөл бололцоо, ёс суртахууны байдал, хүчирхийлэл үйлдсэн эсэхийг нь харгалзан хүүхдийг эцэг, эхийн аль нэгний асрамжид үлдээж, тусдаа амьдрах эцэг, эхээс хүүхдийн тэтгэлэгийн хэмжээг тогтоож гаргуулахаар шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, магадлал, тогтоол.

**Хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид шилжүүлэх.** Шүүхийн шийдвэрт зааснаар хүүхдийг асрамжиндаа авах эрхтэй этгээдэд бусдын хууль бус асрамжаас хүүхдийг шилжүүлэх үйл ажиллагаа.

## Сэдвийн тойм

### **Барилга, орон байрнаас нүүлгэн гаргах**

Барилга, орон байрнаас нүүлгэн гаргах тухай шийдвэрийг хариуцагч болон гүйцэтгэх баримт бичигт заагдсан төлбөр төлөгч шүүхээс тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол шийдвэр гүйцэтгэгч албадан гүйцэтгэнэ.

Нүүлгэн гаргах гэдэгт гүйцэтгэх баримт бичигт заасан барилга, орон байрыг нүүн гарах этгээд, түүнтэй хамтран амьдарч байгаа гэр бүлийн гишүүн, тэдгээрийн эд хөрөнгө, гэрийн тэжээвэр амьтдаас чөлөөлж, нүүн гарсан этгээдэд чөлөөлөгдсөн барилга, орон байрыг ашиглахыг хориглох ажиллагаа хамаарна. Барилга, орон байрнаас нүүлгэн гаргах тухай хугацаатай мэдэгдлийг биелүүлээгүй бол шийдвэр гүйцэтгэгч албадан нүүлгэх өдөр, цагийг тогтоосон мэдэгдлийг нүүн гарвал зохих этгээдэд өгөх ба тухайн этгээд байхгүй байгаа нь шийдвэрийг биелүүлэхэд саад болохгүй.



Нүүлгэн гаргах ажиллагааг нүүн гарч байгаа этгээд, хөндлөнгийн хоёр гэрчийг байлцуулан, шаардлагатай бол орон сууц ашиглалтын байгууллагын төлөөлөгчийг оролцуулан гүйцэтгэнэ. Нүүн гарах этгээд албадан нүүлгэх мэдэгдэлд заасан хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр барилга, орон байранд байхгүй байвал түүний эзгүйд эд хөрөнгийг нь битүүмжлэн, зохих этгээдэд хадгалуулахаар хүлээлгэн өгч, барилга, орон байрыг чөлөөлнө.

Жилийн аль ч улиралд албадан нүүлгэх ажиллагааг гүйцэтгэж болох бөгөөд нүүн гарч байгаа этгээдийн амьдралын нөхцөлийг харгалзан өвлийн улиралд энэ ажиллагааг ахлах шийдвэр гүйцэтгэгчийн тогтоолоор тодорхой хугацаагаар түдгэлзүүлж болдог онцлогтой.

Шийдвэр гүйцэтгэгч нүүлгэн гаргах шийдвэрийг биелүүлсэн тохиолдолд тэмдэглэл үйлдэнэ.

### **Үндэслэлгүйгээр ажлаас халагдсан ажилтныг урьдах ажил албан тушаалд эгүүлэн тогтоох**

Хөдөлмөрийн хуулийн 40 дүгээр зүйлд заасан дараахь үндэслэл үүсээгүй байхад ажил олгогчийн санаачлагаар хөдөлмөрийн гэрээг цуцалсан бол үндэслэлгүйгээр халагдсан гэж үзнэ.

- аж ахуй нэгж байгууллага, түүний салбар нэгж татан буугдсан, орон тоо хасагдсан, ажилтны тоог цөөрүүлсэн
- ажилтан мэргэжил, ур чадвар, эрүүл мэндийн хувьд гүйцэтгэж байгаа ажил албан тушаалдаа тэнцэхгүй болсон нь тогтоогдсон
- ажилтан 60 нас хүрч өндөр насны тэтгэвэр авах эрх үүссэн
- ажилтан хөдөлмөрийн сахилгын зөрчил давтан гаргасан, эсхүл хөдөлмөрийн гэрээг шууд зогсоохоор хөдөлмөрийн гэрээнд тухайлан заасан ноцтой зөрчил гаргасан
- мөнгө болон эд хөрөнгө хариуцсан ажилтан ажил олгогчийн итгэлийг алдсан буруутай үйлдэл эс үйлдэхүй гаргасан нь тогтоогдсон
- сонгууль, томилолтоор өөр ажил, албан тушаалд ажиллах болсон
- контрактад заасан үндэслэл буй болсон

Үндэслэлгүйгээр ажлаас халагдсан буюу өөр ажилд шилжүүлсэн ажилтныг урьдах ажил, албан тушаалд нь эгүүлэн тогтоох тухай шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй бол шийдвэр гүйцэтгэгч албадан гүйцэтгэх тухай мэдэгдлийг хариуцагчид хүргүүлнэ.

Мэдэгдлийг хүлээн авсан ажил олгогч:

1. Урьд гаргасан шийдвэрээ хүчингүй болгосон
2. Тухайн ажилтныг урьдахь ажилд нь эгүүлэн тогтоосон шийдвэр гаргаж,

ажилтан ажил үүргээ гүйцэтгэх боломжтой болсон тохиолдолд шүүхийн шийдвэрийг гүйцэтгэсэнд тооцно.

Хэрэв ажлаас үндэслэлгүйгээр халагдсан ажилтны ажлын байранд өөр ажилтан ажиллаж байгаа бол түүнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгодог.

Хуулийн этгээд татан буугдсан, өөрчлөгдөн байгуулагдсаны улмаас үндэслэлгүйгээр ажлаас халагдсан буюу өөр ажилд шилжүүлсэн ажилтныг урьдах ажил, албан тушаалд нь эгүүлэн тогтоох тухай шийдвэрийг гүйцэтгэх боломжгүй тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч тухайн баримт бичгийг шүүх болон түүнийг олгосон бусад байгууллагад буцаах тухай шийдвэр гаргаж ахлах шийдвэр гүйцэтгэгчид шилжүүлнэ.

### **Үндэслэлгүйгээр өөр ажилд шилжүүлсэн ажилтан**

Хөдөлмөрийн тухай хуульд заасан дараах үндэслэлээр ажилтныг өөр ажилд шилжүүлж болно. Үүнд:

- ажлын зайлшгүй шаардлагаар өөр ажилд түр шилжүүлэх.,
- сул зогсолтын үед өөр ажилд түр шилжүүлэх.,
- ажилтныг эрүүл мэндэд нь харшлахгүй өөр ажилд түр шилжүүлж болно.

Энэ талаар гарсан шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэхэд ажилтныг өөр ажилд шилжүүлж байгаа үед түүний хөдөлмөрийн гэрээ дуусгавар болдоггүй, харин өөр ажилд шилжүүлэх нөхцөл арилсан үед ажилтан өмнөх ажил, үүргээ гүйцэтгэх боломжтой байдгаараа онцлог юм.

Үндэслэлгүйгээр ажлаас халагдсан буюу өөр ажилд шилжүүлсэн ажилтны урьд ажиллаж байсан ажлын байр, албан тушаал нь цомхотгогдсон бол ажил олгогч ажилтантай тохиролцсоны үндсэн дээр урьдахь ажил, албан тушаалтай дүйцэх өөр ажил, албан тушаалд ажиллуулах үүрэгтэй.

### **Хүүхдийн тэтгэлэг гаргуулах шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагааны онцлог**

Шүүхийн шийдвэрийн дагуу хүүхдийн тэтгэлэгийг гаргуулахад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Гэр бүлийн тухай хуулийг тус тус баримтална.

Гэр бүлийн тухай хуульд зааснаар хүүхдэд олгох тэтгэлэгийн талаар эцэг, эх нь харилцан тохиролцоогүй бол түүний насны байдлыг харгалзан сард нэг хүүхдэд дараах хэмжээгээр тогтооно. Үүнд:

- 11 хүртэлх насны хүүхдэд тухайн бүс нутагт тогтоогдсон амьжиргааны доод түвшингийн 50 хувиар
- 11-16 нас (суралцаж байгаа бол 18 нас)-тай болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдэд амьжиргааны доод түвшингийн хэмжээгээр



Зөвхөн цалин хөлснөөс өөр орлогогүй хариуцагчаас гаргуулах хүүхдийн тэтгэлэгийн хэмжээ нь түүний сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын 50 хувиас хэтэрч болохгүй гэсэн хуулийн зохицуулалт бий.

Шүүхийн шийдвэрээр суутгах, эсхүл тэжээн тэтгэх гэрээний дагуу төлөх хүүхдийн тэтгэлэгийн хэмжээ нь тэтгэлэг төлөгчийн цалин хөлсний 50 хувиас хэтэрсэн буюу шүүхээр өөр тэтгүүлэгчид тэтгэлэг гаргуулахаар шийдвэрлэсэн бол тэтгэлэг төлөгч тэтгэлэгийн хэмжээг өөрчлөн тогтоолгохоор шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

Хүүхдийн тэтгэлэг гаргуулах шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхэд дараах онцлог бий. Үүнд:

1. Хүүхдийн тэтгэлэг төлөгч нь цалин орлоготой бол тогтмол төлөгдөх төлбөрт тэтгэлэг гаргуулах ажиллагааг хамааруулж, түүний цалин орлогоос суутгал хийх замаар төлүүлнэ. Суутгал хийсэн этгээд нь суутгасан мөнгийг төлбөр авагчид бэлнээр буюу хадгаламжид шилжүүлнэ.
2. Хүүхдийн тэтгэлэг гаргуулах шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэхэд тэтгэлэг авагчийг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлаас чөлөөлнө.
3. Хэрэв тэтгэлэг төлөгч хэд хэдэн төлбөр авагчид төлбөр төлөх үүрэг хүлээсэн бол хүүхдийн тэтгэлэгийг дараалал харгалзахгүй тэргүүн ээлжинд олгоно.
4. Хүүхдийн эрх ашгийг хамгаалах үүднээс хүүхдийн тэтгэлэгийн мөнгөнөөс бусдад төлөх төлбөр гаргуулахыг хориглоно.

Хүүхдийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид шилжүүлэх шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаа.

Хүүхдийг хууль ёсны эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид шилжүүлэх талаар шүүх шийдвэр гаргахдаа хүүхдийн эрх ашгийг тэргүүн ээлжинд авч үзэн шийдвэрлэдэг. Гэрлэлт цуцлах, асран хамгаалах харгалзан дэмжигч тогтоосныг хүчингүйд тооцох, бусдын хууль бус асрамжаас хүүхдээ шаардан авах, хүүхдийн асрамж тогтоолгох зэрэг гэр бүлийн эрх зүйн харилцаанаас үүдэлтэй маргааныг шүүх шийдвэрлэсний эцэст шүүх хүүхдийг хэний асрамжинд үлдээх талаар шийдвэр гаргадаг. Энэхүү шийдвэрийг маргалдагч талууд сайн дураар биелүүлээгүй тохиолдолд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмаар албадан гүйцэтгэнэ. Энэ талаар гарсан шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэхдээ асран хамгаалах, харгалзан дэмжих байгууллагын төлөөлөгчийг байлцуулах ба тэмдэглэл үйлдэнэ. Харин асран хамгаалах харгалзан дэмжих байгууллага нь сум, дүүргийн Засаг дарга, нийгмийн халамжийн байгууллага байна.

Хүүхдийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид шилжүүлэхдээ асран хамгаалах, харгалзан дэмжих байгууллагын төлөөлөгчийг байлцуулна.

## ХЯНАЛТЫН АСУУЛТ:

1. Тодорхой үүрэг гүйцэтгүүлэхийг даалгасан шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагааны онцлог ямар байх вэ?
2. Барилга, орон байрнаас нүүлгэн гаргах тухай шийдвэрийг хэрхэн албадан гүйцэтгэх вэ? Энэ ажиллагааны онцлогийн талаар хэлэлцэнэ үү.
3. Шийдвэр гүйцэтгэгч үндэслэлгүйгээр ажлаас халагдсан ажилтныг урьдах ажил албан тушаалд эгүүлэн тогтоохдоо ямар ажиллагаанд анхаарал хандуулах вэ?
4. Шүүхийн шийдвэрээр тогтоогдсон хүүхдийн тэтгэлэг гаргуулах журам ямар байх вэ?
5. Тэтгэлэг төлөгч нь цалин орлогогүй байх нь хүүхдийн тэтгэлэг гаргуулахад нөлөөлөх үү.
6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд хүүхдийн эрх ашгийг хэрхэн хамгаалах вэ?
7. Тодорхой үүрэг гүйцэтгүүлэхийг даалгасан шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаанд Цагдаагийн байгууллага оролцох эсэх талаар хэлэлцэнэ үү.

## Бодлого

Гүйцэтгэх баримт бичигт заасан төлбөр төлөгч Сарангаас гаргуулвал зохих дараах төлбөрүүдийг хэрхэн барагдуулах вэ?

- Зам тээврийн ослын улмаас иргэн Отгонсүрэнгийн эд хөрөнгөд учруулсан хохирол 2 100 000 сая төгрөг
- Өмгөөлөгчийн өмгөөллийн хөлс 350 000 төгрөг
- Хандад төлөх зээлийн гэрээний төлбөр 2 600 000 төгрөг
- Охин Халиунд сар бүр төлөх тэтгэлэгийн нийт 570 000 төгрөг
- Дүүргийн татварт төлбөл зохих татвар 111000 төгрөг

## Сорил

1. Хүүхдийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид шилжүүлэхдээ ..... байлцуулна.
  - a. 2-оос доошгүй хөндлөнгийн гэрчийг заавал байлцуулна
  - b. Шийдвэр гүйцэтгэгчийг заавал байлцуулна.
  - c. Хүүхдийг өөрийг нь заавал байлцуулна.
  - d. Асран хамгаалах, харгалзан дэмжих байгууллагын төлөөлөгчийг заавал байлцуулна.



2. Шийдвэр гүйцэтгэгч Ц шүүхийн шийдвэрт заасны дагуу иргэн А-г Б-ын орон сууцнаас нүүн гарахыг өмнө нь хэд хэдэн удаа шаардаж байжээ. Шийдвэр гүйцэтгэгчийн шаардлагыг А үл биелүүлсэн тул албадан нүүлгэх өдөр, цагийг тогтоосон мэдэгдлийг А-д хүргүүлжээ. Мэдэгдэлд заасан хугацаанд А тухайн орон сууцандаа байхгүй байсан тул шийдвэр гүйцэтгэгч түүний эзгүйд орон сууцыг чөлөөлөн, эд хөрөнгийг нь битүүмжилжээ. Иргэн А шийдвэр гүйцэтгэгч хууль зөрчсөн ажиллагаа явуулсан гэж гомдол гаргажээ. Гомдлыг хангах үндэслэлтэй эсэхэд дүгнэлт хийнэ үү.
  - а. Үндэслэлтэй. Учир нь нүүн гарч байгаа этгээдийг буюу А-г заавал байлцуулах ёстой байсан.
  - б. Үндэслэлтэй. Хөндлөнгийн 2 гэрчийг байлцуулан ёстой.
  - с. Үндэслэлгүй. Шийдвэр гүйцэтгэгч хуулийн дагуу ажилласан.
3. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг “Зангуу” ХХК өөрийн байгууллагын дотоод журамд заасны дагуу нярав Б-г түр хугацаагаар өөр ажилд томилон шилжүүлжээ. Б нь үүнийг эс зөвшөөрч шүүхэд нэхэмжлэл гаргасан бол шүүх урьд ажиллаж байсан ажлын байранд эргүүлэн ажилуулахаар шийдвэрлэсэн байна. Гэтэл “Зангуу” ХХК нь Б-гийн эрхэлж байсан няравын ажлын байрыг цомхотгосон тул ажилд авах боломжгүй гэжээ. Шүүхийн шийдвэрийг хэрхэн биелүүлэх вэ?
  - а. Шийдвэр гүйцэтгэгч шүүхийн шийдвэрийг биелүүлэх боломжгүй тул гүйцэтгэх баримт бичгийг шүүх болон түүнийг олгосон бусад байгууллагад буцаах тухай шийдвэр гаргаж ахлах шийдвэр гүйцэтгэгчид шилжүүлнэ.
  - б. Ажил олгогч ажилтантай тохиролцсоны үндсэн дээр өмнө эрхэлж байсан ажил, албан тушаалтай дүйцэх өөр ажил, албан тушаалд ажиллуулах үүрэгтэй.
  - с. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх боломжгүй болсон гэж үзээд гүйцэтгэх баримт бичгийг Б-д буцаана.
4. Шүүхийн шийдвэрт заасан дагуу хүүхдийн тэтгэлэгийг гаргуулахад:
  - а. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг баримтална.
  - б. Гэр бүлийн тухай хуулийг баримтлана.
  - с. Дээр дурьдсан хуулиудыг адил хэмжээнд баримтална.
5. Барилга, орон байрнаас албадан нүүлгэх ажиллагааг өвлийн улиралд тодорхой хугацаагаар түдгэлзүүлэхийг
  - а. шүүхийн шийдвэрээр
  - б. шүүгчийн захирамжаар
  - с. ахлах шийдвэр гүйцэтгэгчийн тогтоолоор
  - д. шийдвэр гүйцэтгэгчийн тогтоолоор шийдвэрлэнэ.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ: ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААР ГАРСАН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА

Бүлгийн зорилго: Монгол Улсын эрүүгийн ялын бодлого, ял эдлүүлэх болон албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх шүүхийн тогтоолыг гүйцэтгэж эрүүгийн ялын зорилгыг хангах талаар мэдлэг эзэмших, ялтныг ангилан хуваарилж, хорих ангид ял эдлүүлэхэд хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг дээдлэн хангах зэрэг зарчим хэрэгжих эрх зүйн зохицуулалтын талаар тодорхой мэдлэг эзэмшиж, түүнийг практикт хэрэглэх чадвартай болно.

### СЭДЭВ.3.1. ЭРҮҮГИЙН ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГАА, ЯЛЫН БОДЛОГО

#### (Лекц 2 цаг)

Сэдвийн зорилго: Эрүүгийн ял эдлүүлэх үйл ажиллагаа, түүний процесс, эрх зүйн зохицуулалтын онцлог, хорих ял эдлэгсдийн эрхийн байдал, түүний хэрэгжилтийн талаар мэдлэг эзэмшиж, ял эдлүүлэх ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийг хэрэглэх чадвартай болоход оршино.

#### Сэдвийн агуулга:

- Шүүхийн тогтоолоор оногдуулсан эрүүгийн ял эдлүүлэх, эрүүгийн хариуцлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд оролцох байгууллага тус бүрийн хүлээх үүрэг, харилцан хамтын ажиллагаа
- Эрүүгийн ял эдлүүлэх ажиллагаанд оролцогч төрийн байгууллагын ажилтан, бусад иргэд, ялтны эрх, үүрэгийн нийтлэг болон онцлог талууд
- Ял эдлүүлэх ажиллагаанд тавих прокурорын болон ял эдлүүлэх байгууллагын дотоодын хяналтын чиглэл, хүрэх үр дүн

#### Нэр томъёоны тайлбар:

**Эрүүгийн ял эдлүүлэх ажиллагаа.** Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шүүхээс оногдуулсан эрүүгийн ялыг хуулиар тогтоосон нөхцөл, журам, хяналтын хүрээнд албадан гүйцэтгэж буй төрийн албадлагын арга хэмжээг хэлнэ.

**Ялын бодлого.** Төрөөс гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр баримталж буй бодлогыг хэлнэ.

**Ялын биелэлтийг хангах хэрэгсэл.** Ялын зорилгыг хангах хүрээнд авч хэрэгжүүлж буй арга хэрэгсэл.

**Ял эдлүүлэх зарчим.** Ял эдлүүлэх ажиллагаанд баримталж буй үзэл баримтлал, үндсэн эхлэл юм.



**Ялын зорилго.** Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлагын зорилгыг ойлгоно. Ял эдлүүлэх нөхцөл, журам. Ялтныг ял эдлүүлэхтэй холбогдсон хуулиар тогтоосон стандартын хэлнэ.

**Ялтан (хоригдол).** Гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор тогтоогдсон, ял эдэлж байгаа этгээдийг хэлнэ.

## **Сэдвийн тойм**

ШШГЭЗ-н ойлголт, судлагдахуунд хамаарах нэгэн чухал сэдэв бол ялын бодлого, түүний хэрэгжилтийн уялдаа холбооны тухай асуудал юм.

Монгол Улсын эрүүгийн ялын бодлого нь шүүх эрх мэдлийн байгууллагын хүрээнд шийдвэрлэгдэж, ял эдлүүлэх байгууллагуудын үйл ажиллагаагаар дамжин хэрэгжиж байдаг төдийгүй улс орны нийгэм, улс төр, эдийн засгийн тогтолцооны хөгжил ялын бодлогод зайлшгүй нөлөөлнө.

Монгол Улсын Эрүүгийн ялын бодлого хэдийгээр түүхэн цаг тухай үе бүрт хэлбэлзэлтэй явж ирсэн ч гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах эрүүгийн ялын тэнцвэр тохироог зөв байлгахыг аль болох эрмэлзэх, түүнчлэн ялын бодлогыг хэрэгжүүлэхэд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх, гэмт хэрэг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд анхаарч ирсэн юм.

Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн дэг журам, хүний аюулгүй байдлыг хангах, хүний эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ төрт ёсны болон үндэсний уламжлал, зан заншлыг сэргээн хөгжүүлж, хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгоход төрөөс баримталж байгаа бодлого чиглэгдэж байна.

Мөн түүнчлэн төрийн бодлогын нэг хэсэг нь эрүүгийн ял шийтгэлийг оновчтой оногдуулах үйл ажиллагааг боловсронгуй болгох, түүгээр дамжуулан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн ашиг сонирхлыг хамгаалахад чиглэгдэнэ.

Гэмт хэрэг үйлдэж, гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон ялтны эрх, эрх чөлөөнд эрүүгийн хуульд заасны дагуу эрхийн хязгаарлалт тогтоосон агуулга бүхий төрийн албадлагын онцгой арга хэмжээг ял гэнэ.

Ял нь:

Бусад төрийн албадлагатай харьцуулахад цээрлэлийн шинжийг агуулсан байна.

Ялыг гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай нь шүүхээр нотлогдсон этгээдэд төрийн нэрийн өмнөөс шүүх оногдуулдаг.

Ял нь ялтай байдлыг бий болгодог.

Ялын төрөл, хэмжээг эрүүгийн хуулиас өөр ямар ч хуулиар тогтоодоггүй зэрэг онцлог шинжтэй байдаг.

Иргэн, нийгмийн гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд ялын зорилго оршдог.

Ял нь:

- төрийн албадлагын онцгой арга хэмжээ
- ялтанд үзүүлэх цээрлэлийг агуулдаг
- ялтныг хүмүүжүүлэх хэрэгсэл болдог
- ялтан болон бусад хүмүүсийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэрэгсэл
- ял нь ялтны сонгох, сонгогдох эрхийг бүрэн, зарим эрхийг хагас хязгаарладаг
- ял нь хүнд, хөнгөн гэмт хэргийн хор аюултай харилцан хамааралтай гэсэн хэд хэдэн онцлог шинжүүдтэй.

## Ялын тогтолцоо

Эрүүгийн хуульд хөнгөн ялаас хүнд ял руу нь дараалуулан байрлуулсан шүүх зайлшгүй дагаж мөрдөх ёстой ялуудын төрлүүдийг ялын тогтолцоо гэнэ. Үндсэн ялд торгох, албадан ажил хийлгэх, баривчлах, хорих, цаазаар авах, үндсэн ба нэмэгдэл ялд тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял, нэмэгдэл ялд эд хөрөнгө хураах ял тус тус хамаарна.

### ХЯНАЛТЫН АСУУЛТ:

1. Хорих ял эдлэгсэдийн эрхийн байдлыг Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний эрхийн байдалтай харьцуулан авч үзнэ үү.
2. Хорих ял эдэлснээс үүсэх эрх зүйн болон бусад үүсч болох сөрөг үр дагаврыг тодорхой жишээ гарган тайлбарлана уу.
3. Хорих болон баривчлах ялаас бусад эрүүгийн ялын талаар ярилцана уу.
4. Эрүүгийн ялын зорилгыг хангахад шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн гүйцэтгэх үүргийг эрүүгийн эрх зүйтэй холбон тайлбарлана уу.



## **Бодлого**

Ялтан “Х” 450 цагийн албадан ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн. Тэрээр 235 цаг албадан ажил хийсний эцэст хөдөлмөрийн чадвараа түр алджээ. Ялтны энэ байдлыг харгалзан үзэж шийдвэр гүйцэтгэгч нь түүнийг эрүүл мэндийн улмаас албадан ажил хийх боломжгүй гэж дүгэнэн уг ялыг баривчлах ялаар солих тухай саналыг шүүхэд гаргасныг шүүх хүлээн авч шийдвэр гүйцэтгэгчийн саналаар шийдвэрлэсэн байна.

Энэ тохиолдолд:

1. Ялтан “Х” шүүхээс гаргасан шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд хэрхэн шийдвэрлэх вэ?
2. Ялтан үлдсэн ажил хийх цагийг хүчингүй болгох саналаа шийдвэр гүйцэтгэгчид гаргасан зэрэг үйлдэл тус бүрт хууль зүйн үүднээс үнэлэлт өгнө үү.

## **Сорил**

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэл:
  - a. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэл нь иргэний болон эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийтгэх тогтоол, хуульд заасан тохиолдолд бусад байгууллагын шүүхээр баталгаажуулсан шийдвэр байна.
  - b. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэл нь эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийтгэх тогтоол, хуульд заасан тохиолдолд бусад байгууллагын шүүхээр баталгаажуулсан шийдвэр байна.
  - c. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэл нь иргэний болон захиргааны хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр, эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийтгэх тогтоол, хуульд заасан тохиолдолд бусад байгууллагын шүүхээр баталгаажуулсан шийдвэр байна.
  - d. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэл нь иргэний хэргийн талаар гарсан хийн шийтгэх тогтоол, хуульд заасан тохиолдолд бусад байгууллагын шүүхээр баталгаажуулсан шийдвэр байна.
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо нь:
  - a. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, хорих байгууллага, аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанаас бүрдэнэ.
  - b. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанаас бүрдэнэ.
  - c. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага, хорих байгууллага, шийдвэр гүйцэтгэх тасаг, хэсгээс бүрдэнэ.
  - d. Иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх Шийдвэр

гүйцэтгэх газар, эрүүгийн хэргийн талаарх шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх Тогтоол гүйцэтгэх газраас бүрдэнэ.

3. Аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албыг мэргэжлийн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавих нь:
  - a. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын чиг үүрэг
  - b. Шийдвэр гүйцэтгэх газрын чиг үүрэг
  - c. Аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны чиг үүрэг
  - d. Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны чиг үүрэг
  
4. Нийгэмд аюултай халдварт өвчтэй, согтуурах, мансуурах донтой ялтныг албадан эмчлэх нь:
  - a. Тогтоол гүйцэтгэх газрын чиг үүрэг
  - b. Хорих байгууллагын чиг үүрэг
  - c. Аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны чиг үүрэг
  - d. Согтуурах, мансуурах донтой этгээдийг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрыг чиг үүрэг
  
5. Хорих ангийн дотоод журам зөрчин сахилгын шийтгэл эдэлж байгаа ялтанд таксофон ашиглахыг зөвшөөрөх үү?
  - a. Хориглоно
  - b. Зөвшөөрнө
  - c. Зохицуулсан заалт байхгүй
  - d. Хориглоогүй



## СЭДЭВ.3.2. ХОРИХООС ӨӨР ТӨРЛИЙН ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГАА

### (Лекц 2 цаг)

Сэдвийн зорилго: Эд хөрөнгийн холбогдолтой эрүүгийн хэргийн талаар гаргасан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх гэдэгт шүүхийн шийдвэрийг хэдийнээс биелүүлэх, эрүүгийн хэргийн талаар гаргасан болон эд хөрөнгийн холбогдол гэж юуг хэлэх, иргэний хэргийн талаар гаргасан шүүхийн шийдвэрээс ялгагдах шинж байдал гүйцэтгэх нөхцөл, журам гэх мэт асуудлыг боловсронгуй болгоход оршино.

### Сэдвийн агуулга:

- Торгох ял оногдуулсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа
- Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрх хасах ял оногдуулсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх онцлог
- Эд хөрөнгө хураах ял гүйцэтгэх ажиллагааны үндсэн шинж
- Эрүүгийн хэргийн зарим төрлийн шүүхийн шийдвэрийг цагдаагийн байгууллагаас гүйцэтгэх

### Нэр томъёоны тайлбар:

**Эрүүгийн ял эдлүүлэх ажиллагаа.** Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шүүхээс оногдуулсан эрүүгийн ялыг хуулиар тогтоосон нөхцөл, журам, хяналтын хүрээнд албадан гүйцэтгэж буй төрийн албадлагын арга хэмжээг хэлнэ.

**Албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх.** Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэнэ.

**Торгох ялыг хорих ялаар солих.** Ялтан эд хөрөнгө, хөдөлмөрийн хөлс, цалин орлогоо нуух, бусдад хууль бусаар шилжүүлэх, үрэгдүүлэх, шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэлгүйгээр байнга оршин суугаа газраа өөрчлөх зэргээр ял эдлэхээс санаатайгаар зайлсхийвэл шийдвэр гүйцэтгэгч зохих шалгалт явуулж, торгох ялыг баривчлах, хорих ялаар солих тухай саналыг прокурорт гаргах тухай ойлголт юм.

**Прокурорын зөвшөөрөл.** Шүүхээс зөвшөөрөл авахаас бусад тохиолдолд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөө, хувийн болон гэр бүл, захидал харилцааны нууц, орон байр, өмчийн халдашгүй байдлыг хөндсөн ажиллагаа явуулахад прокурор бичгээр зөвшөөрөл өгнө.

**Эд хөрөнгө хураах.** Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувьд ногдох эд хөрөнгийг бүгдийг буюу заримыг үнэ төлбөргүйгээр албадан гаргуулж, төрийн өмчлөлд шилжүүлэхийг эд хөрөнгө хураах ял гэнэ.

**Албадан ажил хийлгэх.** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлсон газарт нийгэмд ашигтай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг албадан ажил хийлгэх ял гэнэ.

**Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрх хасах.** Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн төрийн албан тушаал эрхлэх, тодорхой мэргэжлийн болон бусад үйл ажиллагаа явуулах эрхийг энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд нэгээс таван жил хүртэл хугацаагаар хязгаарлахыг тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял гэнэ.

### Сэдвийн тойм

Монгол улсад 1995 оны 12 дугаар сард “Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэгжүүлэх тухай” Монгол Улсын хууль батлагдан хэрэгжсэнээр хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх харилцааг зохицуулсан анхны төрөлжсөн хуультай болсон юм. Энэ хууль 1996 оны 11 дүгээр сард батлагдсан “Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай” Монгол Улсын хууль мөрдөгдөж эхлэх хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байсан болно.

УИХ-аас 2002 онд одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай” хуулийг баталсан ба хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх, ял эдлүүлэх ажиллагааг зохицуулж байна.

2002 онд батлагдсан Эрүүгийн хуульд ял нь 7 төрөлтэй байхаар заажээ. Үүнд:

1. Торгох - Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд шүүхээс мөнгөн төлөөс оногдуулахыг торгох ял гэнэ.
2. Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах – Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн төрийн албан тушаал эрхлэх, тодорхой мэргэжлийн болон бусад үйл ажиллагаа явуулах эрхийг энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд нэгээс таван жил хүртэл хугацаагаар хязгаарлахыг тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял гэнэ.
3. Эд хөрөнгө хураах - Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувьд ногдох эд хөрөнгийг бүгдийг буюу заримыг үнэ төлбөргүйгээр албадан гаргуулж, төрийн өмчлөлд шилжүүлэхийг эд хөрөнгө хураах ял гэнэ.
4. Албадан ажил хийлгэх - Эрүүгийн хуульд заасан хугацаагаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлсон газарт нийгэмд ашигтай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг албадан ажил хийлгэх ял гэнэ.
5. Баривчлах - Эрүүгийн хуульд заасан тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлан тодорхой дэглэм бүхий байранд ганцаарчлан байлгахыг баривчлах ял гэнэ.



6. Хорих - Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг энэ хуульд заасан хугацаагаар эрх чөлөөг нь хязгаарлаж, нийгмээс тусгаарлан хорих анги, гянданд байлгахыг хорих ял гэнэ.
7. Цаазаар авах - Онц хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд цаазаар авах ял оногдуулж болно.

Энэ сэдвийн хүрээнд хорих ялыг оролцуулахгүйгээр бусад 6 төрлийн ял эдлүүлэх ажиллагааны талаар судлах юм. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа нь хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, шуурхай, энэрэнгүй байх гэсэн зарчимд тулгуурлах бөгөөд бусад төрлийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаатай нэгэн ижил гүйцэтгэгдэнэ.


Торгох ял эдлүүлэх ажиллагаа:



<b>Торгох ялыг өөр төрлийн ялаар солих</b>	
<b>Боломж 1.</b> Баривчлах ялаар (хуульд тодорхой заагаагүй)	<b>Боломж 2.</b> Хорих ялаар (3 жил хүртэл хугацаагаар)
Ялыг солих тухай саналыг прокурорт гарган, прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.	

Эрүүгийн хуульд торгох ялыг зөвхөн хорих ялаар сольж болох талаар заасан боловч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд баривчлах болон хорих ялаар сольж болохоор хуульчилжээ.


**Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрх хасах ял эдлүүлэх ажиллагаа:**



<b>Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих</b>	
<b>Хяналт 1.</b> Прокурорын байгууллага	<b>Хяналт 2.</b> Цагдаагийн байгууллага
Ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлээгүй этгээдэд Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.	

Эрх хасах ял эдлэж байгаа этгээд ял эдлэх хугацаандаа өөр ажил, албан тушаалд шинээр орох, тодорхой үйл ажиллагаа эрхлэх нь нээлттэй бөгөөд зөвхөн ял оногдуулсан албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулахыг хориглодог. Ингэхдээ шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэж зөвшөөрөл авна.

**Эд хөрөнгө хураах ял эдлүүлэх ажиллагаа:**






<b>Хураах эд хөрөнгийн төрөл /гүйцэтгэх хуудсанд тодорхой дурдсан байх/</b>	
<b>Төрөл 1.</b>	<b>Төрөл 2.</b>
Ялтны зөвхөн өөрийн өмчлөлийн эд хөрөнгө	Дундаа хэсгээр, хамтран өмчлөлийн эд хөрөнгө
Шүүхийн шийтгэх тогтоолд заасан эд хөрөнгийг бүрэн хурааж, улсын орлогод оруулснаар ялыг бодитой биелүүлсэнд тооцно.	

Эд хөрөнгө хураах ялыг бодитой биелүүлсэн тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичгийг хааж, шийтгэх тогтоол гаргасан шүүхэд мэдэгдэх үүрэгтэй.


### **Албадан ажил хийлгэх ял эдлүүлэх ажиллагаа:**



<b>Албадан ажил хийлгэх ялыг өөр төрлийн ялаар солих</b>	
<b>Алхам 1.</b>	<b>Алхам 2.</b>
Ялтан ял эдлэхээс зайлсхийвэл албадан ажил хийлгэж байгаа байгууллага шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэнэ	Шийдвэр гүйцэтгэх газар албадан ажил хийлгэх ялыг баривчлах ялаар солих тухай саналаа шүүхэд гарган шийдвэрлүүлнэ
Албадан ажил хийлгэх ял эдлэх 8 цагийг 1 хоногийн баривчлах ялтай тэнцүүлэн ялыг солино.	

Албадан ажил хийлгэх ял эдлэх хугацаа дууссан бол, хуульд заасан бусад үндэслэлээр ялаас чөлөөлөгдсөн бол энэ өдрөөс эхлэн ялтны эрхийн хязгаарлалтыг зогсооно.


## Баривчлах ял эдлүүлэх ажиллагаа:



<b>Ялтныг хүлээн авах, шилжүүлэх</b>	
<b>Тохиолдол 1.</b> Тогтоол хүчин төгөдөр болсон өдрөөс 10 хоногийн дотор ял эдлэх байранд шууд хүргэнэ	<b>Тохиолдол 2.</b> Гэмт хэрэгт шалгагдаж байгаа бол цагдаагийн байгууллагад шилжүүлнэ
Шилжүүлэхдээ хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагын санал, прокурорын зөвшөөрлийг үндэслэн шийдвэрлэнэ.	

Баривчлах байр нь жирийн дэглэмтэй хорих ангитай адил дэглэмтэй байх бөгөөд төвлөрсөн бүтэцтэй байна.

## Цаазаар авах ял гүйцэтгэх ажиллагаа:





<b>Уучлал үзүүлсэн эсэх хариу</b>	
<b>Тохиолдол 1.</b>	<b>Тохиолдол 2.</b>
Уучлалын асуудлыг шийдвэрлэх хүртэл шийтгэх тогтоолыг гүйцэтгэхийг түдгэлзүүлнэ	Уучлал үзүүлсэн эсэх тухай хариуг прокуророор дамжуулан өгнө
Монгол Улсын Ерөнхийлөгч уучлал үзүүлээгүй бол ялыг зохих журмын дагуу гүйцэтгэнэ.	

**ХЯНАЛТЫН АСУУЛТ:**

1. Эд хөрөнгө хураах ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгээгүй этгээдэд ямар хариуцагаа хүлээлгэх вэ?
2. Хорих болон баривчлах ялаас бусад эрүүгийн ялын төрлүүдийг эдлүүлэх үйл ажиллагааг эдгээр ялын төрөл тус бүрээр тайлбарлана уу.
3. Албадан ажил хийлгэх ялыг өмнө нь хэрэглэж байсан “Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх” ялтай харьцуулна уу.
4. Эрүүгийн хуульд заасан журмаар албадан эмчлэх нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйтэй хамааралтай болохыг практик жишээгээр нотолно уу.

**Бодлого**

Шүүхийн шийтгэх тогтоолоор ялтан “Б”-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн 134 дүгээр зүйлийн 134.1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцон 251 цаг албадан ажил хийлгэх ял оногдуулжээ. Ялтан өөрийн биеэр ялын 131 цагийг эдлээд ял эдэлж байсан ажлын байраа дур мэдэн орхин явжээ.

Энэ тохиолдолд:

- Б-д оногдуулсан ял Эрүүгийн хуулийн холбогдох зүйл, заалттай тохирч байгаа эсэхийг шалгана уу.
- Ажлын байраа орхиж байгаа ялтны үйлдэлд дүгнэлт өгнө үү.
- Б-гийн үлдсэн ялыг хэрхэн эдлүүлэх вэ?

## Сорил

1. Прокурор нь ямар төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж ажиллах вэ?  
a. Албадан ажил хийлгэх                      b. Торгох  
c. Эд хөрөнгө хураах                            d. Бүгд зөв
2. Аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанд хамаардаг хорихоос өөр төрлийн ялыг нэрлэнэ үү.  
a. 3                      b. 4                      c. 5                      d. 6
3. Үндсэн болон нэмэгдэл ялын чанартай оногдуулж болдог ялын төрөл?  
a. Албадан ажил хийлгэх                      b. Торгох  
c. Эрх хасах                                        d. Эд хөрөнгө хураах
4. Монгол Улсын Ерөнхийлөгч ялтанд уучлал үзүүлсэн эсэх хариуг хэнээр дамжуулан өгөх вэ?  
a. Прокурор                                        b. Шүүх  
c. Хорих анги                                      d. Шууд гардуулна
5. Баривчлах ял эдлэж буй ялтан жилд хэдэн удаа түр хугацааны уулзалт хийх эрхтэй вэ?  
a. Жилд 12 удаа                                b. Жилд 24 удаа  
c. Жилд 36 удаа                                d. Тоог хязгаарлахгүй



### СЭДЭВ.3.3. ШҮҮХИЙН ШИЙТГЭХ ТОГТООЛ ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ТӨРӨЛ, ХЭЛБЭР, ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА

#### (Семинар 2 цаг)

**Сэдвийн зорилго:** Онолын мэдлэгтээ тулгуурлан шүүхээс ял оногдуулсан Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан ял оногдуулсан шийтгэх тогтоолыг бие даан гүйцэтгэх, хуулийн хэрэгжүүлэх дадал, чадварыг эзэмшинэ.

#### Сэдвийн агуулга:

- Ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолын төрөл, хэлбэр
- Хорих ялын тухай ойлголт, ял эдлүүлэх журам
- Хорих ял эдлүүлэх байгууллага, хорих ангийн дэглэм
- Онцгой субъектийн ял эдлүүлэх ажиллагаа (насанд хүрээгүй, эмэгтэй, жирэмсэн гэх мэт)

#### Нэр томъёоны тайлбар:

**Хорих байгууллага.** Хорих байгууллага нь баривчлах байр, насанд хүрээгүйчүүдийн болон насанд хүрэгсдийн хорих анги, гяндан тэдгээртэй адил дэглэм бүхий байгууллагаас бүрдэнэ.

**Хорих ангитай адил дэглэм бүхий байгууллага.** Дамжин өнгөрүүлэх анги болон хорих байгууллагын нэгдсэн эмнэлэгийг ойлгоно.

**Хорих ял эдлүүлэх дэглэм.** Хорих ялын зорилгыг хангах хүрээнд тодорхой нөхцөл журам, хэм хэмжээг агуулсан цогц ойлголт юм. Хорих ял эдлүүлэх жирийн, чанга, онцгой дэглэм байна.

**Баривчлах байр.** Баривчлах ял эдлүүлэх болон баривчлах байрууд хамаарна.

**Цагдан хорих байр.** Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны цагдан хорих таслан шийтгэх арга хэмжээ авагдсан этгээдийг түр хорих байрыг хэлнэ.

#### Сэдвийн тойм:

Хорих анги нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоонд онцлох байр суурь эзэлдэг. Хорих ангийг шинээр байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газар шийдвэрлэнэ. Тухайлбал, 2007 оны 08 дугаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай 188 дугаар тогтоол гаргаж Дархан-Уул, Булган аймаг, Авдрант дахь хорих ангиудын байршлын өөрчилж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг батлан өгсөн юм.

Хорих анги нь Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан үндэслэлийн дагуу жирийн, чанга, онцгой дэглэмтэй зохион байгуулагдана. Хорих анги нь шүүхийн шийтгэх тогтоолоор оногдуулсан хорих ялыг албадан эдлүүлэх төрийн байгууллага бөгөөд, хуулийн этгээдийн эрх эдэлнэ.

Хорих ангитай адил дэглэм бүхий байгууллага гэдэгт хорих байгууллагын Нэгдсэн эмнэлэг, Дамжин өнгөрүүлэх анги хамаарагдана.

Хорих ангийн үндсэн чиг үүргийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тусгайлан зүйлчилж заагаагүй ч нэгд: түүхэн уламжлал, хоёрт: 1996 онд батлагдан мөрдөгдөж ирсэн Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуульд заасан зэргийг үндэслэн дараах байдлаар томъёолж болно.

Хорих ялыг албадан эдлүүлэх: Хэдийгээр Монгол Улсын Үндсэн хуульд хэнийг ч албадан ажиллуулж болохгүй тухай заасан боловч гэмт хэрэг үйлдэж, гэм буруутайд тооцогдсон этгээдийг олон нийтээс тусгаарлаж эрх, эрх чөлөөнд нь хуульд заасан хязгаарлалт тогтоох шаардлагатай болдог. Хорих ял оноосон шүүхийн шийтгэх тогтоолыг хэрэгжүүлэх нь төрийн албадлагын онцгой ажиллагаа юм. Хорих ял нь шийтгүүлсэн этгээдийг тэдний үйлдсэн гэмт хэрэг, эдлэх ялын хугацаа, дэглэмийг харгалзан тодорхой дэглэмийн харилцан адилгүй нөхцөлд ялыг нь эдлүүлнэ. Хорих ялыг албадан эдлүүлэх үйл ажиллагаа нь хорих ангийн ял эдүүлэхэд чиглэгдсэн албадлагын арга хэмжээ хэрэглэх эрх, үүргийн биелэлтийг хангах, мөн хорих ангийн дотоод журмыг чанд сахиж, хорих байгууллагын ажилтнаас тавьсан хууль ёсны шаардлагыг зайлшгүй биелүүлэх байдалтай салшгүй холбоотой байдаг.


Хорих ангиудад ялыг албадан эдлүүлэх ажиллагаа хэдийгээр зайлшгүй хийгдвэл зохих төрийн албадлага ч ялтныг хүнийх нь хувьд хүндэтгэн үзэх, хүний эрх, эрх чөлөөг сахин хамгаалах нийтлэг зарчмыг баримтлан ажиллах шаардлага нэгэн адил тавигддаг байна

#### ХЯНАЛТЫН АСУУЛТ:

1. Хорих байгууллагын бүтэц, тогтолцоо ямар байх вэ?
2. Монгол Улсад хорих ял эдлүүлэх ажиллагаа буюу хорих байгууллага хэрхэн үүсч хөгжсөн түүхийг хэлэлцэнэ үү.



## Дасгал



## Асуулт:

### Босоогоор:

1. Зөвхөн нэмэгдэл ялын чанартай оногдуулдаг ял?
3. Эрүүгийн ял нь хэдэн төрөлтэй вэ?
7. Жирийн дэглэмтэй хорих анги нь үндсэн хашааны эргэн тойронд хэдээс доошгүй хамгаалалтын бүстэй байх вэ?
8. Насанд хүрээгүй ялтан чанга дэглэмтэй хорих ангид ял эдлэж байгаа бол хэдэн сард нэг удаа илгээмж авах эрхтэй вэ?
10. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар хорих анги нь ямар бүтэцтэй байх вэ?
12. Эрүүгийн журмаар хэргийг шийдвэрлэсэн тохиолдолд шүүхээс гарах шийдвэр нь ямар хэлбэртэй байх вэ?
14. Зөвхөн үндсэн ялын чанартай оногдуулдаг ял?
16. Ял эдлэхээс ноцтой зайлсхийсэн тохиолдолд баривчлах ялаар сольж болох ялын төрөл?
20. Ял эдлүүлэх дэглэм бүхий газрыг юу гэж нэрлэдэг вэ?

### **Хөндлөнгөөр:**

2. Шүүхээс мөнгөн төлбөр оногдуулахыг ямар ял гэх вэ?
4. Баривчлах байр нь ямар хорих ангитай ижил дэглэмтэй байх вэ?
5. Шүүхийн шийтгэх тогтоол гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих субъект?
6. Оногдуулсан ялыг өөр төрлийн ялаар солих асуудлыг хаанаас шийдвэрлэх вэ?
9. Жирийн дэглэмтэй хорих ангийн ялтанд хэд хоног хүртэлх чөлөөг олгож болдог вэ?
11. Чанга дэглэмтэй хорих ангийн ялтан 3 сард 1 удаа ямар хугацааны уулзалт хийх вэ?
13. Хорих ангийн ажлын байрны асуудлыг хаанаас шийдвэрлэх вэ?
15. Гяндангийн ялтан ямар хугацаанд 1цагаас доошгүй хугацаатай гадаалах эрхтэй вэ?
17. Гяндангийн ялтанд гаднаас юу авахыг хориглодог вэ?
18. 1 – 6 сарын хугацаагаар оногдуулдаг ял?
19. Гяндангийн ялтан жилд 2 удаа түр ... хийх эрхтэй.

### **Хариулт:**

#### **Босоогоор:**

- 1.Эд хөрөнгө хураах
- 3.Долоо
- 7.Хоёр
- 8.Нэг
- 10.Төвлөрсөн
- 12.Тогтоол
- 14.Цаазаар авах
- 16.Албадан ажил хийлгэх
- 20.Хорих анги

#### **Хөндлөнгөөр:**

- 2.Торгох
- 4.Жирийн
- 5.Прокурор
- 6.Шүүх
- 9.Долоо
- 11.Удаан
- 13.Засгийн газар
- 15.Өдөрт
- 17.Илгээмж
- 18.Баривчлах
- 19.Уулзалт



## Сорил

1. Насанд хүрээгүй ялтан илгээмж авах, түр уулзалт хийх тоог хязгаарлахгүй бөгөөд
  - a. Жилд 8-аас дээшгүй удаан хугацааны уулзалт хийнэ.
  - b. Жилд 10 удаа удаан хугацааны уулзалт хийнэ.
  - c. Жилд 12 удаа удаан хугацааны уулзалт хийнэ.
  - d. Аль аль нь буруу
  
2. Эмэгтэй ялтан удаан хугацааны уулзалт
  - a. Жилд 10 удаа хийнэ
  - b. Жилд 12 удаа хийнэ
  - c. Жилд 8 удаа хийнэ
  - d. Жилд 7 удаа хийнэ
  
3. Эмэгтэй ялтан чанга дэглэмтэй хорих ангид ял эдэлж байгаа бол
  - a. 1 сард нэг удаа түр, сард нэг удаан хугацааны уулзалт, нэг удаа илгээмж авна.
  - b. 1 сард нэг удаа түр, 2 сард нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, 1 сард нэг удаа илгээмж авна.
  - c. Сард 2 удаа түр, улиралд нэг удаа удаан хугацааны уулзалт хийнэ.
  - d. Сард 3 удаа түр, улиралд 2 удаа удаан хугацааны уулзалт хийж, сард 2 удаа илгээмж авна.
  
4. Жирийн дэглэмтэй хорих анги нь үндсэн хашааны эргэн тойронд
  - a. 2-оос доошгүй хамгаалалтын бүстэй байна.
  - b. 3 –аас доошгүй хамгаалалтын бүстэй байна.
  - c. 1-ээс доошгүй хамгаалалтын бүстэй байна.
  - d. 4-өөс доошгүй хамгаалалтын бүстэй байна.
  
5. Чанга, онцгой дэглэмтэй хорих анги, гяндан хамгаалалтын дараах бүстэй байна
  - a. 4 бүстэй байна
  - b. 5 бүстэй байна
  - c. 6 бүстэй байна
  - d. 8 бүстэй байна

## СЭДЭВ.3.4. ХОРИХ БАЙГУУЛЛАГАД ЯЛТНЫГ ХҮЛЭЭН АВАХ, ЯЛТНЫ ХӨДӨЛМӨР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ БА ТЭДГЭЭРИЙН ЭРХИЙН БАЙДАЛ

### (Лекц 2 цаг)

Сэдвийн зорилго: Шүүхийн тогтоолд заасны дагуу ялтныг тухайн хүлээн авах үндэслэл, журам, дэглэм тус бүрт ялтны хөдөлмөр зохион байгуулалт, сургалт, эмнэлгийн үйлчилгээний онцлог, үр дагавар ямар байх талаар мэдлэгтэй болсноор тодорхой дэглэмд ялаа эдэлж байгаа ялтанд хөдөлмөр, хүмүүжил, сургалтын ажлын үр нөлөөг сурталчлах, ялтны засрал хүмүүжлийн байдалд дүгнэлт хийх чадвар эзэмшинэ.

### Сэдвийн агуулга:

- Хоригдлыг хорих байгууллага хүлээн авах, шилжүүлэх журмын тухай
- Ялтан хөдөлмөр эрхлэлт үр нөлөө, ялтныг хүмүүжүүлэх хэрхэн нөлөөлөх
- Хөдөлмөрийг зохион байгуулах зарчим, хэлбэр хоригдлын хөдөлмөрийн хөлс төлөлтийн эрх зүйн зохицуулалт, ялтны хөдөлмөрийг зохион байгуулах нийтлэг зарчим, хэлбэр
- Ялтны хөдөлмөр зохион байгуулалтын асуудал, түүний эрх зүйн зохицуулалт
- Ялтны үндсэн эрх, түүний хязгаарлагдмал байдал, ялтны үндсэн үүрэг, түүний онцлог
- Хорих ял эдэлснээс үүсэх хууль зүйн үр дагавар
- Ялтнуудын ахуй хангалтын ойлголт, төрөл, түүний эрх зүйн зохицуулалт
- Эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх болон түүний эрх зүйн зохицуулалт

### Нэр томъёоны тайлбар:

**Ялтныг ангилан хуваарилах.** Ялтныг ангилах гэдэг нь хорих ял эдлүүлэх ажиллагааг ялгамжтай нөхцөлд хэрэгжүүлж илүү үр дүнд хүргэх зорилгоор тэдний үйлдсэн гэмт хэргийн шинж, нийгмийн хор аюул, хувийн байдал, нийгэм-хүн ам зүйн бусад байдлыг харгалзан хорих байгууллагад хуваарилахыг хэлнэ.

**Ялтныг хүлээн авах.** Аливаа төрөл, дэглэмийн хорих байгууллагад ялтныг хүлээж авах эрх зүйн үндэслэл нь тухайн хоригдолд ял оногдуулсан шүүхийн хүчин төгөлдөр болсон таслан шийдвэрлэх тогтоол юм. Хорих ангид ялтныг хүлээн авах, шилжүүлэх журмыг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан “Хорих ангийн дотоод журам”, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан “Нэгдсэн тоо бүртгэл хөтлөлтийн журам”-ын холбогдох зүйл, хэсгүүдэд тодорхой заасан байдаг.



**Ялтныг шилжүүлэх.** Хорих ангид ял эдэлж байгаа ялтныг өөр хорих ангид шилжүүлэн ял эдлүүлэх талаар удирдах дээд байгууллага, албан тушаалтны шийдвэр гарсан, ялтны болон түүний гэр бүлийн гишүүдээс гаргасан өргөдөл, хүсэлт ирсэн бол Тогтоол гүйцэтгэх газрын дарга, Гүйцэтгэх ажил эрхэлсэн дэд дарга нөхцөл байдлыг харгалзан ялтныг шилжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

**Хуяглан хүргэх.** Ялтныг Дамжин өнгөрүүлэх ангид хүлээн авч, тоо бүртгэлийн ажилтан хувийн хэрэг, картыг нээсний дараа холбогдох лавлагаа бүхий нэрсийн жагсаалтыг Тогтоол гүйцэтгэх газрын тоо бүртгэл, дүн шинжилгээний тасагт ирүүлнэ. Ийнхүү ирүүлсэн лавлагаа бүхий нэрсийн жагсаалтыг тоо бүртгэл, дүн шинжилгээний тасгийн дарга нягтлан үзэж, нөхцөл байдлыг харгалзан үзсэний дараа ял эдлүүлэх хорих ангийг хуваарилдаг.

**Хөдөлмөр зохион байгуулалт.** Жирийн дэглэмтэй хорих ангийн ялтныг хорих байгууллага өөрийн болон өөрийнхөө хувь нийлүүлсэн, хамтарсан аж ахуйн нэгжид, эсхүл бусад аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан зохих хяналттайгаар хөдөлмөрлүүлж болно. Жирийн дэглэмтэй хорих ангийн ялтныг гяндан, чанга, онцгой дэглэмтэй хорих анги, баривчлах ял эдлүүлэх болон сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих байрны аж ахуйн үйлчилгээнд ажиллуулж болно. Чанга, онцгой дэглэмтэй хорих ангийн ялтныг хорих байгууллага зөвхөн өөрийн үйлдвэрлэл дээр, харуул хамгаалалттай нөхцөлд хөдөлмөрлүүлнэ.

**Цалин, урамшил.** Ялтанд хийсэн хөдөлмөрийн нь тоо, чанарт тохирсон хөлс олгоно. Гэрээний үндсэн дээр ялтан ажиллуулсан ажил олгогч ялтны хөдөлмөрийн хөлсийг хорих ангийн дансанд шилжүүлнэ. Хорих анги ялтныг өөрийн үйлдвэрлэл дээр ажиллуулсны, шилжиж ирсэн цалин хөлснөөс бүх төрлийн төлбөр суутгал хийж үлдэх хэсгийг ялтны нэрийн дансанд төвлөрүүлэн, төвлөрсөн цалин хөлсний 10 хүртэл хувийг ялтан сар тутам авч хэрэглэх эрхтэй ба үлдсэнийг суллагдах үед өөрт нь олгоно.

**Хүмүүжлийн ажлын хэлбэр.** Ялтныг эрх зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ардын уламжлалт зан үйлд сургах болон бусад чиглэлээр хүмүүжлийн ажил зохион байгуулна.

**Ерөнхий боловсролын сургалт.** Насанд хүрээгүй ялтныг ерөнхий боловсролын сургалтад бүрэн хамруулж, бусад ялтан бие дааж мэдлэгээ дээшлүүлэхэд хорих анги туслалцаа үзүүлнэ.

**Мэргэжил эзэмшүүлэх сургалт.** Хорих анги нь өөрийн эрхэлж байгаа үйлдвэрлэлийн чиглэлээр ялтанд хөдөлмөрийн дадлага олгох, мэргэжил эзэмшүүлэх сургалт зохион байгуулж болно. Хөдөлмөрийн дадлага олгох сургалтад ялтныг сайн дурын үндсэн дээр хамруулна.

**Орон байрны хангалт.** Ялтныг эрүүл ахуй, ариун цэврийн тусгайлан тогтоосон шаардлага хангасан байр, ахуйн нөхцөлөөр хангана.

**Хувцасны хангалт.** Хорих анги нь ялтныг ор, хөнжил, гудас, цагаан хэрэглэл болон хүйтэн, дулааны улирлын зориулалттай нэг загварын гадуур хувцсаар хангах ба ялтан хувиасаа дотуур хувцас, дулаан хантааз, цамц, бээлий, өвөл, зуны гутал өмсөхийг зөвшөөрнө.

**Хоол хүнсний хангалт.** Ялтны хоолны илчлэгийн хэмжээг хорих ангийн төрөл, ялтны ажлын нөхцөлийг харгалзан ялгамжтай тогтооно. Хорих байрны эрүүл ахуйн шаардлага, ялтанд олгох хоолны илчлэгийн хэмжээ, хувцасны тоо, эдлэх хугацааг холбогдох байгууллагын саналыг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно. Эмнэлгийн комиссын дүгнэлтийг харгалзан жирэмсэн болон өвчтэй ялтныг нөхцөлийг нь сайжруулсан байранд байлгаж, хоолны илчлэгийн хэмжээг нэмэгдүүлнэ.

**Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх.** Хорих байгууллагын үндсэн чиг үүрэг нийгэмд аюултай халдварт өвчтэй, согтуурах, мансуурах донтой ялтныг албадан эмчлэх, урьдчилан сэргийлэх асуудал хамаарах бөгөөд хорих байгууллагын эмнэлэгийн албад дээрх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

### **Сэдвийн тойм:**

Аливаа төрөл, дэглэмийн хорих байгууллагад ялтныг хүлээж авах эрх зүйн үндэслэл нь тухайн хоригдолд ял оногдуулсан шүүхийн хүчин төгөлдөр болсон таслан шийдвэрлэх тогтоол юм.

Цаазаар авах ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг Монгол Улсын Ерөнхийлөгч уучлалын журмаар сольсон тохиолдолд тэр шийдвэр нь хоригдлыг хорих байгууллагад хүлээн авах эрх зүйн нэг үндэслэл болдог.

Ялтныг хүлээн авахад чиглэгдсэн зохион байгуулалтын олон ажиллагаа шаардагдах бөгөөд түүнийг хийсвэрлэн ор нэр болгож хэрхэвч болохгүй. Учир нь хоригдлыг хүлээн авах ажиллагаа бол ялын зорилтыг хангах, тэднийг хүмүүжүүлэх ажлын эхний алхам болдогтой холбоотой юм.

Хорих ангиудад хоригдлыг хүлээн авах ажиллагаа нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хууль, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад актад дурдсан журмын дагуу явагдана.

Цагдан хорих байрнаас Дамжин өнгөрүүлэх ангид энэ ангиас төрөл, дэглэмийн хорих ангиудад хоригдлыг хүлээн авах, шилжүүлэх журмыг нэгд, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, хоёрт, Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан “Хорих ангийн дотоод журам”, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан “Нэгдсэн тоо бүртгэл хөтлөлтийн журам”-ын холбогдох зүйл, хэсгүүдэд тодорхой заасан байдаг.



Ялтныг хүлээн авах ажилд хорих ангийн ажилтнууд, ялангуяа, харуул хамгаалалт эрхэлсэн дэд дарга, төлөөлөгч, хүний тоо бүртгэл, сургалт-арга зүйн болон эмнэлгийн албаны хүмүүс идэвхтэй оролцвол зохихыг холбогдох хууль тогтоомжид заасан байна.

Ялтныг хүлээн авмагцаа бие, эд зүйлд нь нэгжлэг хийхийн зэрэгцээ тэдний эрх үүрэг, хорих ял эдлэх үед зөвшөөрөгдөх, хориглох болон онцлон анхаарах зүйлс, түүнчлэн хэрэг зөрчил гаргасан тохиолдолд хүлээлгэж болох эрх зүйн болон материалын хариуцлага (хуулийн 127 дугаар зүйл), өөрийн байгууллагын дэглэмийн онцлог, үйлдвэрлэлийн чиглэл, хөдөлмөр хамгаалалын анхан шатны зааварчлага зэргийг тайлбарлан таниулна.

Ялтныг хүлээн авсны дараа тэднийг бусад хоригдлоос 5-7 хоногийн хугацаагаар тусгайд нь байлгах шаардлагатай. Энэ үеэр дээр дурьдсан ажлуудаас гадна хоригдлын хувийн хэргийн үндсэн хэсгийг бүрдүүлэх, эмнэлгийн үзлэг явуулах шаардлагатай. Заримыг эмчлэх, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны арга техникийн дүрмийг нарийвчлан танилцуулах зэрэг ажлыг заавал хийсэн байвал зохино. Мөн хоригдол нэг бүртэй ганцаарчилсан уулзалт ярилцлага зохиож, тэдний мэргэжил боловсрол, хүмүүжлийн түвшин ямар хэмжээнд байгааг судлахын зэрэгцээ цаашид ямар мэргэжил, боловсрол эзэмших, ямар ажил хийх хүсэлтэйг мэдэх, энэ чиглэлээр туслалцаа үзүүлэх нь чухал юм.

НҮБ-аас батлан гаргасан “Хэрэгтэн, ялтантай харьцах наад захын жишиг дүрэм”-д (35.1); хоригдогч бүрийг хорих газарт хүлээн авахдаа тухайн төрлийн хоригдлуудтай харилцах журам, тэдэнд тавигдах сахилгын шаардлага, түүнчлэн мэдээлэл авах зөвшөөрсөн арга, гомдол гаргах журам, мөн өөрийн эдлэх эрх, хүлээх үүрэг болон тухайн хорих ангийн амьдралын нөхцөлд дасан зохицохтой холбогдсон бусад зүйлийн талаарх мэдээллийг бичгээр өгвөл зохихыг заасан байдаг тул энэ бүхнийг ёсчлон гүйцэтгэх шаардлагатай болдог байна.

Хорих ангийн захиргаа таслан шийдвэрлэх тогтоол гаргасан шүүхэд уг тогтоолыг биелүүлж эхэлснээ болон хоригдол хаана ял эдэлж байгааг нэн даруй мэдэгдэх шаардлагатай болдог. Мөн хорих байгууллага хоригдлыг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор ар гэрт нь мэдэгдэж, түүндээ өөрийн байгууллагын хаяг болон тухайн хоригдлын захидал харилцаа, эргэлт хүлээн авах, уулзалт хийх журмын тухай тайлбарлбал зохино. Ингэснээр хугацааны бус эргэлт уулзалт гарах, хориглосон зүйлийг авч ирэх зэрэг сөрөг үзэгдлийг таслан зогсоох, хоригдол түүний ар гэрийхний хооронд холбоо тогтоох зэрэгт тус нэмэр болоход эерэг нөлөө үзүүлдэг байна. Хорих байгууллагад шинээр ирсэн ялтантай холбогдсон дээрх ажлыг хийсний дараа тэднийг ажлын хэсэгт хуваарилна. Эдгээр асуудалд олон талаас нь хариуцлагатай хандсаны эцэст холбогдох шийдвэрийг хорих ангийн захиргаа гаргана.

Ялтныг хуваарилах, ялангуяа, шилжүүлэхэд онцлон анхаарвал зохих нэг зүйл бол тэдний ялын бүх хугацааг аль болохоор нэг хорих анги буюу гянданд эдлүүлэх явдал юм. Гэвч хоригдлын ял эдлэх явцад тэднийг нэг хорих ангиас нөгөөд, эсвэл хорих ангиас гянданд, гяндангаас хорих ангид шилжүүлэх шаардлага гардаг. Тухайлбал, хоригдлын гүйцэтгэж байгаа ажил үйлдвэрлэлийн чиглэл, байршил өөрчлөгдсөн, түүнчлэн уг ангид ялаа үргэлжлүүлэн эдлэхэд саад болж байгаа бусад онцгой нөхцөл байдал гарвал ялыг нь цаашид өөр ангид эдлүүлэхээр шилжүүлж болно. Харин тухайн хорих ангид цаашид ялаа эдлэхэд саад болох бодитой нөхцөл байна гэж хорих ангийн зохих албад үзвэл уг хоригдлыг өөр адил дэглэм бүхий байгууллагад шилжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

Хорих ялын талаас доошгүй хувийг эдэлсэн, засрах замдаа баттай орсоноо бүх талаар харуулж чадсан хоригдлын цаашид эдлэх ялыг хуульд заасны дагуу өөр дэглэмийн хорих ангид эдлүүлэхээр шилжүүлж болох тухай өмнө дурдсан. Энэ тохиолдолд гяндангаас онцгой, онцгойгоос чанга, чангаас жирийн дэглэмтэй хорих ангид тус тус шилжүүлнэ. Дэглэм бууруулах, чангатгах аль ч тохиолдлоор хоригдлыг нэг хорих ангиас нөгөөд, эсвэл гянданд шилжүүлэхдээ уг асуудлыг олон талаас нь нягталж бодитой хандаж чадвал тэдэнд хүмүүжлийн нөлөө үзүүлэх ажлын үр дүнг дээшлүүлэхэд нааштай алхам болдог.

Ялтныг нэг дэглэмийн хорих ангиас нөгөөд шилжүүлж болох өөр нэг тохиолдол бол насанд хүрээгүйчүүдийн хорих ангид ял эдлэгсэдтэй холбоотой. Насанд хүрээгүй хоригдлыг 18 нас хүрмэгц үлдсэн ялыг насанд хүрэгчдийн хорих ангид эдлүүлэхээр шилжүүлнэ.

Гэвч хоригдлын үйлдсэн гэмт хэргийн нийгмийн хор аюулын хэмжээ, хувийн байдал, зан төлөв, засрал хүмүүжлийн түвшин, ял эдэлсэн хугацааг харгалзан тэднийг насанд хүрээгүйчүүдийн хорих ангид хоёр жил хүртэл хугацаагаар үргэлжлүүлэн ял эдлүүлж болно. Энэ нь тухайн хоригдлын хүмүүжлийн үр дүнг бататгах, ерөнхий боловсролын болон мэргэжил эзэмшүүлэх сургалтыг дуусгах зорилгоор хийгддэг байна.

Ялтныг адил төрлийн нэг дэглэмээс нөгөөд шилжүүлж болох тохиолдол бол нарийн мэргэжлийн хүнийг ял эдлэх явцад нь шаардлагатай анги байгууллагад хуваарилан шилжүүлэх явдал юм. Энэ тохиолдолд тухайн хорих анги нь Тогтоол гүйцэтгэх газрын зохих албанд саналаа тавьж шийдвэрлүүлнэ.



### ХЯНАЛТЫН АСУУЛТ:

1. Ялтныг ангилан хүргэх, хүлээн авах, хуваарилах нь зайлшгүй зүйл үү?
2. Ялтныг шилжүүлж болох тохиолдлын талаар жишээ гаргаж тайлбарлана уу.
3. Хорих ял эдлүүлэх хяналт, харуул хамгаалалтыг зохион байгуулах нь ямар ач холбогдолтой вэ?
4. Ялтныг хөдөлмөрт хамруулах, хүмүүжүүлэх ойлголт, ач холбогдолыг тодорхойлно уу.
5. Ялтны дунд зохиох хүмүүжлийн ажлын ямар шинэлэг хэлбэрүүдийг нэвтрүүлэх нь олон улсын жишигт нийцэх вэ?
6. Ялтны ахуй хангалтын нийтлэг болон онцлог талуудыг дурьдана уу.
7. Хорих ял эдлэгсдийн эрхийн байдлыг Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний эрхийн байдалтай харьцуулан авч үзнэ үү.
8. Хорих ял эдэлснээс үүсэх эрх зүйн болон бусад үүсч болох сөрөг үр дагаврыг тодорхой жишээ гарган тайлбарлана уу.

### Бодлого

Ялтан Болд хуяглан хүргэлтээр хорих ангид ирэхэд түүний таслан шийдвэрлэх тогтоолд насыг нь буруу бичсэн үндэслэлээр тоо бүртгэлийн байцаагч хүлээн авахаас татгалзжээ. Гэвч хуяглан хүргэлтийн офицер буцаан авч явахаас татгалзсанаас маргаан үүсчээ.

Энэ тохиолдол асуудлыг хэрхэн шийдвэрлэх вэ?

### Сорил

1. Ялтныг суллах үндэслэл?
  - a. Шүүхийн шийтгэх тогтоолоор оногдуулсан ялын хугацаа дууссан
  - b. Өршөөл, уучлал үзүүлсэн
  - c. Шүүхээс хэргийг хэрэгсэхгүй болгосон
  - d. Бүгд зөв
2. Ялтантай удаан хугацааны уулзалтын үргэлжлэх хугацаа хэд цаг хүртэл байдаг вэ?
  - a. 9 цаг
  - b. 3 цаг

- c. 72 цаг
  - d. 48 цаг
3. Хорих ангийн бүтэц
- a. Орон нутгийн
  - b. Бүсчилсэн
  - c. Төвлөрсөн
  - d. Төв орон нутгийн
4. Насанд хүрээгүй ялтныг ямар нөхцөлөөр ажиллуулж болох вэ?
- a. Албадах
  - b. Сайн дураар ажиллуулах
  - c. Хөнгөлттэй нөхцөлөөр
  - d. Албадан болон сайн дураар холимог
5. Сахилгын байранд хоригдсон тусгаарлах тасалгаанд шилжсэн ялтны түр болон удаан хугацааны уулзалтыг хасч болох уу?
- a. Болно.
  - b. Түр хугацааны эргэлт бол болно.
  - c. Хорих ангийн даргын зөвшөөрлөөр зөвхөн түр хугацааны уулзалт хийж болно.
  - d. Болохгүй.



## СЭДЭВ.3.5. ХОРИХ БАЙГУУЛЛАГАД ЯЛТНЫГ АНГИЛАН ХУВААРИЛАХ, ШИЛЖҮҮЛЭХ БОЛОН ЯЛТНЫ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ТҮҮНД ТАВИХ ХЯНАЛТ, ХАРУУЛ ХАМГААЛАЛТ

### (Семинар 2 цаг)

**Сэдвийн зорилго:** Эрүүгийн ял эдлүүлэх ажиллагааны зорилгын үндсэн чиглэл нь ялтныг тодорхой дэглэм журамд хэвшүүлэх, тэдний зүгээс ард иргэдэд гэм хор учруулахаас урьдчилан сэргийлэх явдлын талаар мэдлэг эзэмшүүлэхэд оршино.

### Сэдвийн агуулга:

- Ялтныг харьяалах хорих анги руу ангилан хуваарилах ажиллагаа, эрх зүйн үндэс
- Ялтны хөдөлмөр эрхлэлтийн онцлог
- Ялтны цалин, хөлс, суутгал тооцох асуудал
- Хорих ангийн харуул хамгаалалтын төрөл, хэлбэр

### Нэр томъёоны тайлбар:

**Ялтныг ангилан хуваарилах.** Ялтныг ангилах гэдэг нь хорих ял эдлүүлэх ажиллагааг ялгамжтай нөхцөлд хэрэгжүүлж илүү үр дүнд хүргэх зорилгоор тэдний үйлдсэн гэмт хэргийн шинж, нийгмийн хор аюул, хувийн байдал, нийгэм-хүн ам зүйн бусад шинжийг харгалзан хорих байгууллагын тодорхой төрөлд хуваарилахыг хэлнэ.

**Хөдөлмөр зохион байгуулалт.** Жирийн дэглэмтэй хорих ангийн ялтныг хорих байгууллага өөрийн болон өөрийнхөө хувь нийлүүлсэн, хамтарсан аж ахуйн нэгжид, эсхүл бусад аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан зохих хяналттайгаар хөдөлмөрлүүлж болно. Жирийн дэглэмтэй хорих ангийн ялтныг гяндан, чанга, онцгой дэглэмтэй хорих анги, баривчлах ял эдлүүлэх болон сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих байрны аж ахуйн үйлчилгээнд ажиллуулж болно. Чанга, онцгой дэглэмтэй хорих ангийн ялтныг хорих байгууллага зөвхөн өөрийн үйлдвэрлэл дээр, харуул хамгаалалттай нөхцөлд хөдөлмөрлүүлнэ.

**Цалин, урамшил.** Ялтанд хийсэн хөдөлмөрийн нь тоо, чанарт тохирсон хөлс олгоно. Гэрээний үндсэн дээр ялтан ажиллуулсан ажил олгогч ялтны хөдөлмөрийн хөлсийг хорих ангийн дансанд шилжүүлнэ. Хорих анги ялтныг өөрийн үйлдвэрлэл дээр ажиллуулсны, шилжиж ирсэн цалин хөлснөөс бүх төрлийн төлбөр суутгал хийж үлдэх хэсгийг ялтны нэрийн дансанд төвлөрүүлэн, төвлөрсөн цалин хөлсний 10 хүртэл хувийг ялтан сар тутам авч хэрэглэх эрхтэй ба үлдсэнийг ялаас чөлөөлөгдөх үед өөрт нь олгоно.

**Харуул хамгаалалт, хяналт.** Ялтны дундаас нийгэмд аюултай гэмт хэрэг, зөрчил үйлдэх, аюулгүй байдлыг хангах үүднээс хамгаалалтын хүч, хэрэгсэл ашиглан зохион байгуулах арга хэмжээг хэлнэ.

### Сэдвийн тойм

Хорих анги харуул хамгаалалтын ажлыг тухайн ангийн дэглэм, ялтны тоо, байршил, цэргийн албан хаагчдын орон тоо, зохион байгуулалт, тэдний эзэмшилд байгаа холбоо дохиоллын болон инженер, техникийн хамгаалалтын хэрэгсэл, галт зэвсэг, тусгай хэрэгсэл, үйлдвэрлэлийн ба газар нутгийн онцлог, улс орны гадаад, дотоод цагийн байдал, цаг агаарын онцлог зэргийг харгалзан дотоодын хамгаалалт, гадна хамгаалалт гэсэн хоёр үндсэн хэлбэрээр зохион байгуулна. Хорих ангийн харуул хамгаалалтын алба нь ялтныг олон нийтээс тусгаарлан тэднээс дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, үйлдсэн хэргийг илрүүлэх, таслан зогсоох, холбогдох хууль, хорих ангийн дотоод журам, цагийн хуваарийг чанд мөрдүүлэх, хорих анги болон ялтны аюулгүй байдлыг хангах үндсэн үүргийг гүйцэтгэнэ.

Хорих ангид харуул хамгаалалтыг дараах байдлаар зохион байгуулна:

1. Байнгын хамгаалалт (ердийн буюу өдөр тутмын);
2. Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжих;
3. Хүч нэмэгдүүлсэн хамгаалалт;
4. Ялтны гаргасан гэмт үйлдэл (бусдыг барьцаанд авах, зохион байгуулалттайгаар хорих ангийн дотоод дэг журам зөрчих, шаардлагад захирагдахгүй байх, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болох, оргох)-ийг таслан зогсоох, эрэн сурвалжлах ажиллагаа.

Улс орны гадаад, дотоод байдал хүндэрсэн, байгалийн гамшиг тохиолдсон, нийтийг хамарсан хорио цээрийн дэглэм тогтоосон, албаны сургалт, дадлага болон бусад нэгдсэн ажиллагаанд хамруулах үед Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаалаар өндөржүүлсэн бэлэн байдалд шилжихийг зарлана. Ажлын шаардлага, албаны сургалт, дадлагын үед хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны даргын тушаалаар тухайн анги, албаны хэмжээнд хүч нэмэгдүүлсэн хамгаалалт, өндөржүүлсэн бэлэн байдал зарлаж болно. Хүч нэмэгдүүлсэн хамгаалалтын хугацаанд ялтныг хорих ангийн хамгаалалтын бүсэд төвлөрүүлэн тэдний зүгээс үйлдэж болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

Хорих ангийн хамгаалалтыг дараах хүч, хэрэгслээр зохион байгуулна:

1. Хорих ангийн албан хаагчид, бусад хүч хэрэгсэл;
2. Тогтоол гүйцэтгэх газрын харуул хамгаалалтын хэлтэс, түүний хүч хэрэгсэл;
3. Цагдаа, дотоодын цэрэг, орон нутгийн засаг захиргааны зэрэг бусад байгууллагын хүч хэрэгсэл.



“Хамгаалалтын хүч хэрэгсэл” гэдэгт хорих ангийн харуул хамгаалалтын болон бусад мэргэжлийн ажилтнууд, галт зэвсэг, тусгай хэрэгсэл, хамгаалалтын бүс, тэдгээрийн техник, тоног төхөөрөмж, албаны нохой, болзошгүй ажиллагааны үед ажиллах төлөвлөгөө болон хуулийн дагуу явуулж буй бусад ажиллагааг хамааруулан ойлгоно. Хамгаалалтын бүс гэдэгт “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хууль”-ийн 112 дугаар зүйл, энэ журамд заасан хорих ангийн амьдралын болон үйлдвэрлэлийн бүс, тэдгээрийн техник, тоног төхөөрөмж, ялтны түр ба байнгын ажиллах хэсэг, салбарын байр, үйлдвэрийн талбайг тойруулан тогтоосон тэмдэгт шон, зурвас, хашаа, түүнчлэн хуулийн дагуу тогтоосон хорих ангийн хориотой бүс, хэрэв ялтныг автомашин, галт тэрэг, онгоцоор хуяглан хүргэх, тээвэрлэх бол тухайн тээврийн хэрэгслийг тус тус хамааруулан ойлгоно. Жирийн дэглэмтэй хорих ангийн амьдралын болон үйлдвэрлэлийн бүсээс 1000-1500 метрт, чанга, онцгой дэглэмийн хорих анги, гяндангийн мөн бүсээс 1500-2000 метр зайд хориотой бүсийг байгуулах ба тэдгээрийг тухайн аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргын захирамжаар баталгаажуулна.

Чанга, онцгой дэглэмтэй хорих анги, гяндан нь хамгаалалтын дараах бүстэй байна:

1. Дотоодын хориотой бүс;
2. Телекамер;
3. Цахилгаан дохиолол бүхий сийрэгжүүлсэн хөрстэй бүс;
4. Хэрмэн буюу үндсэн хашаа.

Цагдан хорих төв нь чанга дэглэмтэй хорих ангитай адил хамгаалалтын бүстэй байна. Жирийн дэглэмтэй хорих анги, тэдгээртэй адил дэглэм бүхий байгууллага нь үндсэн хашааны эргэн тойронд хоёроос доошгүй хамгаалалтын бүстэй байна. Жирийн дэглэмтэй хорих ангийн байршил, үйлдвэрлэлийн чиглэлийг харгалзан хэрмэн буюу үндсэн хашаатай байж болно.

Хорих ангийн хоногийн жижүүрлэлт дараах бүрэлдэхүүнтэй байна:

1. Эргүүл жижүүр;
2. Ерөнхий жижүүр;
3. Ээлжийн дарга;
4. Шалган нэвтрүүлэх хянагч;
5. Даалгавар гүйцэтгэгч хянагч;
6. Холбоочин;
7. Сувилагч;
8. Гадна хамгаалалтын офицер;
9. Гадна хамгаалалтын харуул;
10. Телекамерын хяналтын ажилтан (операторчин).

Шаардлагатай тохиолдолд хоногийн жижүүрлэлтийн бүрэлдэхүүнд хүч нэмэгдүүлсэн сэргийлэх хянагч, болзошгүй ажиллагааны үед ажиллах 3-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй бүлгийг нэмж, томилж болно.

### ХЯНАЛТЫН АСУУЛТ:

1. Ялтныг хуяглан хүргэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын онцлог, тухайн ажиллагааны төрөл, хэлбэрийг дурдана уу.
2. Жир, чанга, онцгой дэглэмтэй хорих анги тус бүрт ялтны хөдөлмөр эрхлэх онцлогыг тайлбарлана уу.
3. Хорих байгууллагад хяналт, харуул хамгаалалт байхын учир холбогдлыг тодорхойлно уу.

### Бодлого

Ялтан Сүрэн харуул хамгаалалтын ажилтантай зурагт чөлөөтэй үзнэ гэж маргалджээ. Харуул хамгаалалтын ажилтан ээлжийн даргад танилцуулснаар ээлжийн дарга ялтан Сүрэнд албан хаагчийн тавьсан хууль ёсны шаардлага биелүүлээгүй гэх үндэслэлээр зөрчлийн акт бичсэн байна. Ялтан Сүрэн энэ байдлыг эсэргүүцэж, ангийн даргад гомдол гаргажээ.

Энэ тохиолдолд:

1. Сүрэнгийн гаргасан гомдол үндэслэлтэй юу?
2. Ялтны эрх, үүргүүдийг нэрлэнэ үү.

### Сорил:

1. Хорих ял эдлүүлэх дэглэмийн биелэлтийг хангах хэрэгслийг хэрхэн ангилдаг вэ?
  - a. 3
  - b. 2
  - c. 4
  - d. 6
2. Ялтны эдлэх эрхээс зөвийг сонгоно уу.
  - a. Ялтан нь хорих ангиа өөрөө сонгох
  - b. Хувийн аюулгүй байдлаа хамгаалуулах
  - c. Хорих ангиас чөлөөтэй орж гарах



3. Ялтан нь хорих ангид тогтоосон дэглэм, журам зөрчсөн нь гэмт хэргийн шинжгүй бол доорх сахилгын шийтгэлээс алийг нь оногдуулж болох вэ? Зөвийг сонго.
  - a. Ээлжийн бус ажил хийлгэх
  - b. Ялтныг тусад нь ял эдлүүлэх
  - c. Ялтны хөдөлмөрийн хөлсийг хасах
  - d. Бүгд буруу
  
4. Жирийн дэглэмтэй хорих ангийн ялтны телефон ашиглах зардлыг хаанаас гаргах вэ?
  - a. Тогтоол гүйцэтгэх газар
  - b. Тухайн хорих анги
  - c. Жил бүр улсын төсвөөс зардлыг баталж өгнө.
  - d. Ялтан өөрөө
  
5. Хоногийн жижүүрийн бүрэлдэхүүнд хориглох зүйлд хамаарахыг олно уу.
  - a. ПНЖ-н байранд үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчдын тооноос илүү ялтан оруулах
  - b. Чанга онцгой дэглэмтэй ялтныг бусад байгууллага, аж ахуй нэгжид ажиллуулах
  - c. Ялтныг ангийн дарга, ХХГАЭ дэд даргын зөвшөөрөлгүйгээр хамгаалалтын бүсээс гаргах
  - d. Бусадтай, уулзуулах

## СЭДЭВ.3.6. ХОРИХ АНГИЙН ОЙЛГОЛТ, ЯЛ ЭДЛҮҮЛЭХ НӨХЦӨЛ, ЖУРАМ

### (Лекц 2 цаг)

**Сэдвийн зорилго:** Хорих ангийн тухай нийтлэг ойлголт, үзэл баримтлалыг судалснаар хорих ангийн талаар тодорхой мэдлэгтэй болох ба жирийн, чанга, онцгой дэглэмтэй хорих ангид ял эдлүүлэх нөхцөл, журам, дэглэм тус бүрийн нөхцөл, журам, ялгаатай байдлыг зөв тодорхойлох чадвар эзэмшинэ.

### Сэдвийн агуулга:

- Хорих ангийн тухай ойлголт, чиг үүрэг,
- Жирийн дэглэмтэй хорих ангид ял эдлүүлэх нөхцөл журам, мөн чанга, гянданд болон онцгой дэглэмтэй хорих ангид ял эдлүүлэх
- Хоригдлыг боловсролын сургалтад хамруулах тухай
- Хөдөлмөрийн дадлага олгох нөхцөл журам
- Хорих анги гэдэг ойлголтын талаарх онолын үзэл баримтлалууд
- Хоригдлыг суллах үндэслэл болон хоригдлыг суллахад бэлтгэх ажиллагаа, суллах журам, тэдэнд үзүүлэх тусламж.

### Нэр томъёоны тайлбар:

**Жирийн, чанга, онцгой дэглэмтэй хорих анги.** Хорих байгууллагын үндсэн төрөл болох хорих ангийн дэглэмийн ялгаа бүхий байгууллага юм. Дэглэм тус бүр ял эдлэх нөхцөл, журмаараа ялгагдана.

**Насанд хүрээгүйчүүдийн хорих анги.** Гэмт хэрэг үйлдэн хорих ял шийтгэгдсэн насанд хүрээгүй этгээдийн хорих байгууллага.

**Эмэгтэйчүүдийн хорих анги.** Гэмт хэрэг үйлдэн хорих ял шийтгэгдсэн эмэгтэйчүүдийг хорих байгууллага.

**Ял эдлүүлэх нөхцөл, журам.** Ял эдлүүлэх чиглэлээр гарсан эрх зүйн актад тусгалаа олсон хэм хэмжээ.

**Баривчлах байр.** Баривчлах ял оногдуулсан шүүхийн тогтоолыг хэрэгжүүлэх хорих байгууллага.

**Хорих ангийн байршил.** Ялтны байршил гэж хорих ангийн дотоод цагийн хуваарьт заагдсан тодорхой цаг хугацаа, газарт ялтан байрлахыг хэлнэ. Байршлыг тогтоохдоо 60-80 ялтны эрхэлж байгаа үйлдвэрлэл, аж ахуйн чиглэлээр нь нийтийн байр, барилга, аж ахуй үйлчилгээний зэрэг хэсэгт хуваан байршуулж, тэдний ор, хувцас, хоол бэлтгэх, савлах, хооллох хэрэгслийг ялтан нэг бүрт хуваарилан дугааржуулсан байна.



**Хорих ангийн үйлдвэрлэлийн чиглэл.** Тухайн хорих ангийн эрхэлж буй үйлдвэрийн үйл ажиллагаа, тухайн орон нутгийн Засаг даргатай тохиролцон Засгийн газраас тогтооно.

**Хорих ангийн харуул хамгаалалт.** Ялтны дундаас нийгэмд аюултай гэмт хэрэг, зөрчил үйлдэх, аюулгүй байдлыг хангах үүднээс хамгаалалтын хүч, хэрэгсэл ашиглан зохион байгуулах арга хэмжээний бүтцийг хэлнэ.

**Ялтан (хоригдол).** Гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн таслан шийтгэх тогтоолоор тогтоогдсон, түүний үндсэн дээр хорих байгууллагад ял эдэлж, хоригдож байгаа этгээдийг хэлнэ.

### **Сэдвийн тойм:**

Хорих байгууллага нь шүүхийн шийтгэх тогтоолоор оногдуулсан хорих ялыг албадан эдлүүлэх төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллага бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

### **Хорих ялыг албадан эдлүүлэх**

Хэдийгээр Монгол улсын Үндсэн хуульд хэнийг ч албадан ажиллуулж болохгүй тухай заасан боловч гэмт хэрэг үйлдэж, гэм буруутайд тооцогдсон этгээдийг олон нийтээс тусгаарлаж эрх, эрх чөлөөнд нь хуульд заасан хязгаарлалт тогтоох шаардлагатай болдог. Хорих ял оноосон шүүхийн шийтгэх тогтоолыг хэрэгжүүлэх нь төрийн албадлагын онцгой ажиллагаа юм. Хорих ял шийтгүүлсэн этгээдийг тэдний гэмт хэрэг, эдлэх ялын хугацаа зэргийг харгалзан дэглэмийн харилцан адилгүй нөхцөлд байлгаж ялыг нь эдлүүлнэ. Хорих ялыг албадан эдлүүлэх үйл ажиллагаа нь хорих ангийн ял эдлүүлэхэд чиглэгдсэн албадлагын арга хэмжээ хэрэглэх, эрх, үүргийн биелэлтийг хангах, мөн хорих дотоод журмыг чанд сахиж, хорих байгууллагын ажилтнаас тавьсан ёсны шаардлагыг заавал биелүүлэх байдалтай салшгүй холбоотой байдаг .

Хорих ялыг албадан эдлүүлэх ажиллагаа нь тухайн хорих ангид хорих ял эдлэгсдийн эрхийн хязгаарлалт, хориглолтын явцад тодоор илрэн гардаг. Хорих ангиудад хорих ялыг албадан эдлүүлэх ажиллагаа хэдийгээр зайлшгүй зохих төрийн албадлага ч ялтныг хүнийх нь хувьд хүндэтгэн үзэх, эрх, эрх чөлөөг сахин хамгаалах нийтлэг зарчмыг баримтлан ажиллах шаардлага нэгэн адил тавигддаг байна.

### **Ялтны аюулгүй байдлыг хангах, тэднээс нийгэм, иргэдэд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх**

Ялтны аюулгүй байдлыг хангах, тэднээс нийгэм, иргэдэд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэх нэг чухал нөхцөл бол хорих байгууллага дахь хяналт, харуул хамгаалалт юм.

Хорих байгууллагын хяналт, харуул хамгаалалтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, хорих ангийн дотоод журамд заасны дагуу нарийн чанд зохион байгуулах нь тухайн хорих ангийн удирдлага, албан хаагчдын төрийн өмнө хүлээсэн нэг онцгой үүрэг байдаг.

Ялтны бие болон байранд тогтмол үзлэг, нэгжлэг хийж, илэрсэн зөрчлийг арилгах, ялангуяа, архи, мансууруулах бодис, зэвсгийн чанартай ашиглаж болох зүйл болон зөвшөөрснөөс илүү хэмжээний мөнгө зэргийг хураан авч шийдвэрлэж байх нь чухал юм. Энэ нь нэг талаас ялтныг өөрсдийг нь дахин гэмт хэрэг үйлдэхээс нөгөө талаар бусад иргэдийг хохироох байдлаас урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.

### Ялтныг хүмүүжүүлэх

Хорих анги энэ чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд юуны өмнө ялтныг үйлдсэн гэмт хэрэгт нь гэмшүүлж, түүний нийгмийн хор аюулыг ойлгуулах, гэмт халдлагаас иргэн, нийгмийг хамгаалах, түүнчлэн ялтныг болон бусад хүмүүсийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, эрүүгийн ялын зорилгыг хангахад чиглэгдсэн хүмүүжлийн ажлыг хуульд заасан хэлбэрүүдээр зохион байгуулна. Хорих ял эдлэгсдийг хүмүүжүүлэх ажлын үр дүн нь нэг талаас албан хаагчид тухайн ялтны хувийн байдлыг тал бүрээс нь судалж, чухам яаж ажиллахаа урьдчилан тогтоосноос, нөгөө талаар ялтан хүний засрал хүмүүжлээ олох гэсэн чин эрмэлзлэлээс ихээхэн шалтгаална. Ялтныг үйлдсэн гэмт хэрэгт нь гэмшүүлэх, түүний нийгмийн хор аюулыг нь бүрэн дүүрэн, эргэлт буцалтгүй ойлгуулах ажил тасралтгүй явагдах ёстой бөгөөд энэ зорилгыг хангахын тулд хууль суртачлах үйл ажиллагаа шийдвэрлэх үүрэгтэй. Гэхдээ олон төрлийн хууль тогтоомжийг бүгдийг нь ялтанд судлуулах боломж шаардлага байхгүй юм. Ялтны дунд зохиох хүмүүжлийн ажлыг хөдөлмөр зохион байгуулалт, харуул хамгаалалт, ахуй хангалт, эмнэлгийн үйлчилгээ зэрэгтэй харилцан уялдаатайгаар зохион байгуулсан тохиолдолд үр дүн нь нэмэгдэх магадлал өндөр байдаг.

Ялтныг албадан хөдөлмөрлүүлж, эрхэлсэн үйлдвэрлэлийн чиглэлээр хөдөлмөрийн дадлага олгох. Энэ чиг үүргийг амжилттай биелүүлэхийн тулд хорих анги өөртөө байнгын үйл ажиллагаа бүхий үйлдвэрлэлийн нэгжтэй байх нь чухал. Албадан хөдөлмөрлүүлэх, хөдөлмөрийн дадлага олгох ажиллагааг мэргэжлийн сургалттай хослуулснаар үр дүнд хүрдгийг хорих ял эдлүүлэх байгууллагын олон арван жилийн туршлага харуулсан юм. Хорих анги нь ялтныг өөрийн үйлдвэрлэл, бусад аж ахуйн нэгж байгууллагад ажиллуулах замаар чиг үүргээ хэрэгжүүлдэг. Ингэж хөдөлмөрлүүлэхдээ хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журмыг хатуу мөрдөж ажиллах үүргийг хорих ангийн захиргаа өөртөө хүлээнэ. Ялтныг ажлын байраар хангах, тэднийг аль болох эзэмшсэн мэргэжилээр нь ажиллуулах, хийсэн ажлын тоо, чанарт нь тохирсон цалин хөлс олгох зэргээс хорих ангийн хөдөлмөр зохион байгуулалттай холбогдсон чиг үүргийн биелэлт ихээхэн шалтгаална.



Насанд хүрээгүй ялтныг ерөнхий боловсролын сургалтад хамруулах, хөдөлмөрийн дадлага олгох. Насанд хүрээгүй ялтны боловсрол эзэмшсэн байдал, түвшинг нь харгалзан ерөнхий боловсролын сургалтыг зохион байгуулна. Энэ ажлыг зохион явуулах эрх зүйн нийтлэг үндэслэл нь Боловсролын тухай Монгол Улсын хууль, "Бүх нийтэд суурь боловсрол эзэмшүүлэх үндэсний хөтөлбөр" зэрэгт тусгагдсан байдаг. Ялтныг албадан хөдөлмөрлүүлэх шаардлага насанд хүрээгүй ялтанд нэгэн адил хамаарна. Гэвч энэ нь боловсрол эзэмшүүлэх ажиллагааг хөдөлмөртэй зөв холбох, ингэснээр ялтанд мэргэжил эзэмшүүлэх хөдөлмөрийн дадлага олгох боломж бүрдүүлэхэд тусалдаг байна. Насанд хүрээгүй ялтныг ерөнхий боловсролын сургалтад хамруулах, тэдэнд хөдөлмөрийн дадлага олгох ажилд гадаад, дотоодын буяны болон шашны байгууллага, тусгайлсан зарим сангаас тал бүрийн туслахаа үзүүлдэг болсныг тэмдэглэх нь зүйтэй. Энэ байдал нь хорих ангиас өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд чухал нөлөөтэй тул бий болсон эерэг байдлыг цаашид хөгжүүлэхэд чиглэсэн олон хэлбэрийн ажил зохиох шаардлага урган гарч байгаа юм.

### **Ялтны эрүүл мэндийг сахин хамгаалах**

Монгол улсын хөдөлмөрийн хууль тогтоомжид заасан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журам ялтанд жирийн иргэдийн нэгэн адил хамаарна. Энэ нь ялтны эрүүл мэндийг сахин хамгаалах нэг баталгаа болдог байна. Хорих байгууллагын нөхцөлд ялтны эрүүл мэндийг сахин хамгаалах ажил бусад иргэдийн адил явагдах боловч ял эдлүүлэх дэглэмийн шаардлагатай холбогдон онцлог байдаг. Тухайлбал, хорих байгууллагын нэгдсэн эмнэлэг дэхь нөхцөл нь чанга дэглэмтэй хорих ангитай адил байхаар хуульчлагдсан байна. Ялтныг эмчлэх ажлын зардлыг нөхөх ажиллагаа нь нийгмийн даатгалын журмыг баримтлан явагдана.

Ялтны эрүүл мэндийг сахин хамгаалах чиг үүргээ биелүүлэхийн тулд хорих анги нэгд, аливаа өвчин, ялангуяа, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хоёрт, ялтныг эмнэлгийн үзлэгт тогтмол хамруулан өвчнийг оношлох, гуравт, тэднийг цаг алдалгүй эмчлэх зэрэг ажлыг зохион байгуулна. Хорих ял эдлэгсдийн дунд түгээмэл байдаг сүрьеэ өвчнийг оношлох, эмчлэх явдал хорих ангийн онцлог чиг үүрэг байдаг.

### **Гэмт хэргийн улмаас иргэн, байгууллагад учруулсан хохирол, төлбөрийг барагдуулах**

Шүүхийн шийтгэх тогтоолд тухайн ялтны иргэн, байгууллагад учруулсан хохирлын талаар дурдсан тохиолдолд тэдний хөдөлмөрийн хөлснөөс суутган тооцох үндэслэл болдог байна. Гэмт хэрэг үйлдсэний улмаас иргэд, байгууллагад учирсан хохирлыг барагдуулах нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллаганы явцад болон хорих ял эдлүүлэх байгууллагын үйл ажиллагааны үр дүнд хэрэгжиж байдаг.

Ялтан иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлоо хэрхэн төлж барагдуулсныг тэдний хүмүүжлийн түвшинг үнэлэх нэг гол үзүүлэлт хэмээн хугацаанаас өмнө тэнсэн суллах, ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих асуудлыг шийдвэрлэдэг байна.

### Хуульд заасан бусад үүрэг

#### **Хорих ангийн энэ үүргийг тоймлон авч үзвэл:**

Хорих ангийн удирдлага, албан хаагчдад Төрийн албаны тухай Монгол улсын хуулийн нийтлэг үүрэг болон мөн хуулийн төрийн тусгай албаны хэсэгт хамаарагдах үүрэг хамаарагдана. Хорих анги нь Монгол улсын Засгийн газар, Хууль зүйн яам, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын удирдлагын гаргасан эрх зүйн баримт бичиг, албан даалгавраар өгөгдсөн үүргийг биелүүлэх, эргэж мэдээллэх үүрэг хүлээдэг. Хорих, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэгжүүлэх ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаж байгаа эсэхэд Улсын ерөнхий прокурор, түүний харьяа прокурорууд хяналт тавьдаг. Энэ ажлын явцад илэрсэн дутагдлыг арилгах талаар прокурорын шаардлага, мэдэгдлийн мөрөөр тодорхой арга хэмжээ авах, хариу мэдэгдэх үүргийг хорих ангийн удирдлага хүлээдэг.

Дээрх чиг үүрийг хэрэгжүүлэхдээ хорих ангийн удирдлага, албан хаагчид хууль тогтоомжоор баталгаажсан тодорхой эрхүүдийг эдэлдэг байна. Орчин үед нийгэм-эдийн засаг, техник технологийн харилцаа гүнзгий өөрчлөгдөн, шинэ шинэ төрлийн гэмт хэрэг гарах болж, гэмт хэргийн чиг хандлага улам бүр мэргэжлийн, зохион байгуулалттай шинжтэй болон гэмт бүлэг, этгээдээс хэрэглэж буй арга техник нарийн боловсронгуй болж байгаа нь хорих байгууллагын харуул хамгаалалтад шууд нөлөө үзүүлж байна.

#### **ХЯНАЛТЫН АСУУЛТ:**

1. Хорих байгууллага, түүний төрөл тус бүрийн ялгаатай болон нийтлэг талууд нь юу вэ?
2. Хорих анги нь түүнтэй адил дэглэм бүхий байгууллагуудаас ялгагдах үндсэн шинжүүдийг нэрлэнэ үү.
3. Жирийн, чанга, онцгой дэглэмтэй хорих ангид ял эдлүүлэх нөхцөл, журмыг тодорхойлно уу.
4. Гянданд ял эдлүүлэх нөхцөл, журам нь бусад дэглэмээс ялгагдах онцлогуудыг дурьдана уу.



## **Бодлого**

Ялтан Насан хорих ангид хүргэгдэн ирэхэд түүнд ял оноосон таслан шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болоогүй, мөн түүнчлэн ялтан насанд хүрээгүй байна гэсэн үндэслэлээр тоо бүртгэлийн байцаагч ялтанг хүлээн авахаас татгалзжээ.

Энэ тохиолдолд:

1. Хорих ангийн тоо бүртгэгчийн үйлдэлд дүгнэлт өгнө үү.
2. Хорих анги ялтан хүлээж авахад ямар шаардлага тавигдах вэ?

## **Сорил**

1. Насанд хүрээгүй ялтныг ямар нөхцөлөөр ажиллуулж болох вэ?
  - a. Албадах
  - b. Сайн дураар ажиллуулах
  - c. Хөнгөлттэй нөхцөлөөр ажиллуулах
  - d. Албадан болон сайн дураар ажиллуулах холимог нөхцөлөөр
2. Нэгдсэн эмнэлэг, дамжин өнгөрүүлэх ангийн дэглэм, харуул хамгаалалт ямар дэглэмийн хорих ангитай адил байх вэ?
  - a. Жирийн дэглэмтэй
  - b. Чанга дэглэмтэй
  - c. Онцгой дэглэмтэй
  - d. Завсарын холимог дэглэмтэй
3. Ялаас чөлөөлөх өвчний жагсаалтыг хаанаас батлан гаргах вэ?
  - a. Тогтоол гүйцэтгэх газрын нэгдсэн эмнэлэг
  - b. Эрүүл мэндийн яам, Хууль зүйн яам
  - c. Тухайн хорих ангийн эмнэлэг, клиникийн 1 дүгээр эмнэлэг
  - d. Эрүүл мэндийн яам
4. Хоригдлын хөдөлмөрийг дараах хуульд заасан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журамд нийцүүлэн зохион байгуулна.
  - a. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
  - b. Хөдөлмөрийн хууль
  - c. Иргэний хууль
  - d. Хөдөлмөрийн болон Иргэний хууль
5. Ялтны сайн дурын байгууллага, ажиллаж болох уу?
  - a. Болно
  - b. Болохгүй
  - c. Тогтоол гүйцэтгэх газар зөвшөөрвөл болно
  - d. Прокурорын байгууллага зөвшөөрвөл болно

## СЭДЭВ.3.7. СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИЙГ ЦАГДАН ХОРИХ ТУХАЙ ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА

### (Лекц 2 цаг)

**Сэдвийн зорилго:** Эрүүгийн хуульд зааснаар гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа сэжигтэн, яллагдагчийн тухай ойлголт болон тэдгээрийг шүүхийн шийдвэрийн дагуу цагдан хорих ажиллагааг хэрхэн гүйцэтгэх талаар онолын цогц мэдлэгтэй болж, сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх буюу цагдан хорих ажиллагааг хуулийн дагуу гүйцэтгэж, хэрэгжүүлэх чадвартай болно.

### Сэдвийн агуулга:

- Сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих ажиллагаа, түүний эрх зүйн зохицуулалт
- Цагдан хорих байрны хяналт, харуул хамгаалалт
- Сэжигтэн, яллагдагчийг хорих нөхцөл, журам
- Насанд хүрээгүй этгээдэд оногдуулсан хорих ял эдлүүлэхийг хойшлуулсан ял эдлүүлэхийг хойшлуулсан болон суллагдсан этгээдэд хяналт тавих журам.

### Нэр томъёоны тайлбар:

**Цагдан хорих шийдвэрийг биелүүлэх зарчим.** Цагдан хорих шийдвэрийг биелүүлэхэд баримталвал зохих үзэл баримтлал ба хууль дээдлэх, хүнлэг ёс, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх зарчмыг баримтална.

**Цагдан хоригдсон этгээдийн эрх зүйн байдал.** Цагдан хорих үйл ажиллагаатай холбоотой хуулиар хязгаарласнаас бусад иргэний эрхийг хязгаарлахыг хориглох тухай цогц ойлголт юм.

**Цагдан хорих байрны тогтолцоо.** Нийслэлд цагдан хорих төв, баривчлах байр, аймгуудад цагдан хорих, баривчлах байр бүхий ШШГЕГ-ын харьяа бүтцийн нэгжийг ойлгоно.

**Цагдан хоригдсон этгээдэд тавих прокурорын хяналт.** Хорих байрны үйл ажиллагаа, нөхцөл, журам цагдан хорих үйл ажиллагаа холбогдох хуулийн хүрээнд нийцэж байгаа эсэх талаар Улсын ерөнхий прокурор болон түүний харьяа прокуроруудаас явуулж байгаа хяналтын үйл ажиллагаа.

**Насанд хүрээгүй этгээдийг хянан харгалзах.** Шүүх насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан бол тогтоолын хувийг ялтны оршин суугаа газрын цагдаагийн байгууллагад нэн даруй хүргүүлж, сум, дүүргийн Засаг дарга, ялтныг хараа хяналтандаа байлгаж хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн иргэн, хуулийн этгээдэд энэ тухай бичгээр мэдэгдэн, хяналт тавих үйл ажиллагаа.



**Ял хойшлуулсан хугацаанд хяналт тавих.** Албадан ажил хийлгэх, баривчлах, хорих ял нь шүүхийн шийтгэх тогтоолоор хойшлогдсон ялтанд цагдаагийн байгууллагаас тавих хяналтыг ойлгоно.

**Хорих ял тэнсэгдсэн этгээдэд хяналт тавих.** Хорих ял эдлэх хугацаанаас өмнө тэнсэн суллагдсан болон Эрүүгийн хуульд зааснаар тэнсэгдсэн ялтанд цагдаагийн байгууллагаас тавих хяналт юм.

### **Сэдвийн тойм:**

Манай улсад 1999 оны 7 дугаар сард сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих талаар бие даасан “Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай” Монгол Улсын хууль батлагдан гарсан билээ.

Харин өнөөдрийн байдлаар 2002 онд батлагдсан одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн байцаан шийтгэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиудыг удирдлага болгон сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг явуулж байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд сэжигтэн гэдэг нь уг этгээдийг гэмт хэрэг үйлдэж байх үед буюу үйлдсэн дор нь барьсан, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хохирогч буюу харсан хүн шууд заасан, уг этгээдийн бие, хувцас, эд зүйл, орон байранд гэмт хэргийн ул мөр тодорхой илэрч олдсон, уг этгээд хэргээ илчлэн ирсэн, гэмт хэрэгт сэрдэгдэх үндэслэл бүхий баримт байгаа бол уг этгээдийг хэлэх, харин яллагдагч гэдэгт нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол үйлдэж, ял сонгосон этгээдийг ойлгох талаар тус тус заажээ.

Энэ сэдвийн хүрээнд дээр нэрлэн дурьдсан сэжигтэн, ялтныг цагдан хорих ажиллагааны талаар авч үзэх юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих ажиллагаа нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газрын Тогтоол гүйцэтгэх газрын чиг үүрэгт хамаарна. Сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих ажиллагаа нь хууль дээдлэх, хүнлэг ёс, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх гэсэн зарчимд тулгуурлах бөгөөд цагдан хоригдсон этгээдэд эрүү шүүлт тулгах, эсхүл бусад арга хэрэглэн түүний бие махбодийг тарчлаан зовоох, сэтгэл санааны дарамт учруулахыг хатуу хориглоно.

## Сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих тухай ойлголт, журам:

### Сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих

#### хүндэвтэр гэмт хэргийн сэжигтэн, яллагдагчийг

өмнө нь авсан  
таслан сэргийлэх  
арга хэмжээг  
зөрчсөн

хэрэг хянан  
шийдвэрлэх  
ажиллагааны  
явцад дахин гэмт  
хэрэг үйлдсэн

хэрэг бүртгэлт,  
мөрдөн байцаалт,  
шүүхээс оргон  
зайлж болзошгүй,  
эсхүл оргон  
зайлсан

Хүнд, онц хүнд  
хэргийн сэжигтэн,  
яллагдагч, удаа дараа  
ял шийтгэгдэж байсан  
этгээд, онц аюултай  
гэмт хэрэгтэн дахин  
гэмт хэрэгт сэрдэгдсэн  
бол цагдан хорих

### Сэжигтэн, яллагдагчийг хорьж мөрдөх хугацаа

#### Сэжигтэн:

Сэжигтнийг цагдан хорьж мөрдөх хугацаа  
14 хүртэл хоног байна

#### Яллагдагч:

Яллагдагчийг хорьж мөрдөх хугацаа 2 сар  
хүртэл байна

Сэжигтэн, яллагдагчийг хорьж мөрдөх хугацааг зайлшгүй шалтгааны улмаас сунгахаар  
бол сунгах эсэх асуудлыг шүүх шийдвэрлэнэ.

хугацааг  
тухай бүр 30  
хүртэл хоногоор  
сунгана

Цаашид хорьж  
мөрдөх зайлшгүй  
шаардлагатай  
бол шүүх хорьж  
мөрдөх хугацааг  
сунгана

онц хүнд гэмт  
хэрэгт 24 сараас  
хэтрэхгүй

хүндэвтэр гэмт  
хэрэгт 4 сараас  
хэтрэхгүй

хүнд гэмт  
хэрэгт 12  
сараас  
хэтрэхгүй

### Яллагдагчийг хорьж мөрдөх хугацааг дахин сунгах

#### Тохиолдол 1.

Төр, нийгмийн зүтгэлтний амь биед халдах

#### Тохиолдол 2.

Хорлон сүйтгэх

#### Тохиолдол 3.

Хүнийг хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар  
санаатай алах

#### Тохиолдол 4.

Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хулгайлах


#### Тохиолдол 5.

Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар зандалчлах


#### Тохиолдол 6.

Төрлөөр устгах

Эдгээр 6-н гэмт хэргийн яллагдагчийг дээр дурдсан хорьж мөрдөх хугацааг сунгаснаас  
илүү хугацаагаар хорьж мөрдөх шаардлагатай бол шүүх 6 сар хүртэл хугацаагаар нэмж  
сунгаж болно



**Цагдан хорих тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа:**



<b>Цагдан хорих байрны тогтолцоо</b>	
<b>Бүтэц:</b> Нийслэлд - Цагдан хорих төв Аймагт - Цагдан хорих, баривчлах байр	<b>Харьяалал:</b> Цагдан хорих төв - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Цагдан хорих, баривчлах байр - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны
Нийслэл дэх цагдан хорих төв нь хуулийн этгээдийн эрх эдэлнэ.	

Хорих байранд зөвшөөрөгдөх эд зүйлс										
Тухайн улирлын 1 удаагийн солих, 3 ээлжийн дотуур хувцас	Шүдний оо, саван, сойз, алчуур бусад зайлшгүй шаардлагатай ариун цэврийн хэрэгсэл	Хөнжил, дэр, гудас, цагаан хэрэгсэл	Зөвшөөрөгдсөн аяга, халбага	Эрүүл ахуйн шаардлага хангасан дөрвөн кг хүртэлх гурилан бүтээгдэхүүн	Эмчийн бичгээр зөвшөөрсөн мансууруулах, гайвшруулах бусад эм	Зөвшөөрөгдсөн ном, сонин, сэтгүүл	Бичгийн цаас, дугтуй, үзэг	Зайгаар ажилладаг зурагт, радио хүлээн авагч	Шашны ном	

# ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙ

ГАРЫН АВЛАГА

<b>Хоригдох этгээдийг хүлээн авах ажиллагаа</b>	
<p><b>Хүлээн авах үүрэг бүхий этгээд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Ерөнхий жижүүр, Жижүүрийн туслах, Эмч</li> <li>- Шалган нэвтрүүлэх байрны харуул</li> </ul>	<p><b>Хүлээн авах цаг:</b></p> <p>08.00 – 22.00 цагийн хооронд</p>
<p>Хүлээн авсан тухай тэмдэглэл: Ерөнхий жижүүрийн туслах хоригдох этгээдийн талаарх мэдээлэл бүхий лавлагааг хөтөлж, ерөнхий жижүүр хүлээн авсан баримт бичгийг тоо бүртгэлийн ажилтанд хүлээлгэн өгнө</p>	<p>Баримт бичгийг шалгах: Хоригдох этгээдийг хүргэж ирсэн албан тушаалтныг байлцуулан цагдан хорих шийдвэрт заагдсан этгээд мөн эсэх, тогтоолын бүрдлийг ерөнхий жижүүр шалгана</p>
<p>Хоригдох этгээдийн биед үзлэг хийх: Шалган нэвтрүүлэх байрны харуул, ээлжийн дарга нар цагдан хорьж буй албан тушаалтныг байлцуулан үзлэг хийж, хориотой эд зүйлсийг хураан авч, тэмдэглэл хөтлөн холбогдох этгээдээр гарын үсэг зуруулна</p>	<p>Хоригдож буй этгээдэд тайлбар хийх: Хорих байрны дотоод журам, цагийн хуваарь, сахилгын шийтгэл ногдуулах журам, эрх, үүргийг нь танилцуулж, тэмдэглэл үйлдэн гарын үсгийг нь зуруулна. Дээрх мэдээллийг бичгээр гаргаж өгнө.</p>
<p>Эмчийн үзлэг хийх: Хоригдох этгээдийн биеийн ерөнхий байдал, ил шарх, өвчин зовиур байгаа эсэхийг үзэж өвчтөний карт нээж, шаардлагатай тохиолдолд хорих байрны эмнэлэгт хэвтүүлж болно</p>	<p>Эмчийн үүрэг: Аймаг, орон нутагт хоригдсон этгээдийг эмнэлэгт хэвтүүлэх зайлшгүй шаардлагатай тохиолдолд эмнэлэгийн тусламж үзүүлэх журмыг баримтална</p>
<p>Хоригдож буй этгээд нь гадаад улсын харьяат буюу харьяалалгүй бол харьяалах улсын хэл дээр эсхүл англи хэл дээр орчуулан танилцуулна.</p>	





<b>Хоригдсон этгээдэд үзүүлэх эмнэлэгийн үйлчилгээ</b>		
<b>Анхны үзлэг:</b>	<b>Хоригдож буй үеийн үзлэг:</b>	<b>Өлсгөлөн зарласан үеийн үзлэг:</b>
<ul style="list-style-type: none"> <li>- Эрүүл мэндийн карт нээж, рентгэн зураг авна</li> <li>- Биеийн ерөнхий байдлын талаар нарийн үзлэг хийнэ</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- 14 хоногт 1 удаа урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулна</li> <li>- Картанд тэмдэглэл хийнэ</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Биеийн байдал, жинг үзэж, өгсөн хоол, цай идэж, уухыг татгалзсан тухай тэмдэглэл үйлдэнэ</li> </ul>
<p>Хоригдож буй этгээдэд эмнэлэгийн аливаа тусламжийг үзүүлэхдээ “Цагдан хоригдогчдод эмнэлэгийн тусламж үзүүлэх, түүнийг эмнэлгийн байгууллагад эмчлэх, цагдан хорих байранд эмнэлэгийн ажилтан орж үйлчлэх журам”-ыг дагаж мөрдөнө.</p>		

### **Хоригдсон этгээдийг суллах үндэслэл**




<b>Хорих байрнаас суллагдсан этгээдийн лавлагаанд дараах зүйлийг тусгана</b>	
<b>Тусгах зүйл. 1 – 5</b>	<b>Тусгай зүйл. 6 – 10</b>
<ul style="list-style-type: none"> <li>- Анх цагдан хоригдсон үед аль өрөөнд, цагдан хоригдох үед аль өрөөнд хоригдож байсан</li> <li>- Цагдан хоригдох, суллагдах үеийн биеийн байдал</li> <li>- Хорих өрөө сольж байсан эсэх</li> <li>- Өмссөн хувцас, үнэт эдлэл хүлээлгэн өгсөн байдал</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцуулсан талаарх тэмдэглэл, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн эсэх</li> <li>- Эмнэлгийн тусалцаа, эргэлт, уулзалт авсан, өмгөөлөгчөөр хангагдсан эсэх</li> <li>- Хорих байрны талаарх гомдол, санал байгаа эсэх</li> </ul>
<p>Дээр дурдсан зүйл бүрийн заавал тусгаж тэмдэглэл хөтлөн суллагдсан этгээд болон өмгөөлөгчөөр гарын үсэг зуруулна.</p>	

## ХЯНАЛТЫН АСУУЛТ:

1. Сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа баривчлах ял эдлүүлэх ажиллагааны нөхцөл, журмаас ямар шинжээрээ ялгаатай болохыг тайлбарлана уу.
2. Хорих ял хойшилсон этгээдэд тавих хяналт, хорих ял тэнсэгдсэн этгээдэд тавих хяналтаас ялгаатай эсэхийг тайлбарлана уу.
3. Хорих ялаас суллагдсан этгээдэд тавих хяналт ямар онцлогтой байх вэ?

## Дасгал



## Асуулт:

### Босоогоор:

1. Гэмт хэрэгт сэрдэгдэх буй этгээдийг .... гэнэ.
3. Хоригдож буй этгээдийн биед ..... хийнэ.
4. 7 хоногт 4 удаа салхилах эрхтэй хоригдогч.



6. Хэд хоногт 1 удаа усанд оруулдаг вэ?
- 9.7 хоногт 1 удаа гаднаас юу авч болдог вэ?
11. Цагдан хорих байрны дотоод “.....”
12. Хорих өрөөг онгойлгоход хамгийн багадаа хэдэн харуул байлцах вэ?
13. Яасан этгээдэд хорих байрны харуул, жижүүр эмч өдөр бүр хяналт тавьдаг вэ?
15. Ямар тохиолдолд өөр өрөөний хоригдсон этгээдтэй харьцахыг хориглодог вэ?
17. Хоригдсон этгээдүүдэд төлбөрт үйлчилгээ үзүүлэх асуудлыг хаанаас шийдвэрлэх вэ?
18. Хоригдож буй этгээд цагийн хуваарийн дагуу ашиглаж болох зүйлийн нэг
20. Хоригдож буй этгээд цагийн хуваарийн дагуу ашиглаж болох зүйлийн нэг

### **Хөндлөнгөөр:**

2. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол үйлдэж, ял сонгосон этгээдийг ..... гэнэ.
5. Хоригдох этгээдийг хүлээн авахад байлцах субъектын нэг
7. Хорих өрөөг онгойлгоход хоригдож буй этгээд хаалганаас хэдэн метрийн зайнд зогсох вэ?
8. Хоригдож буй этгээдийн байрлаж буй орон зайг юу гэж нэрлэдэг вэ?
10. Хорих байр нь заавал харуул, .....-тай байна.
14. Өлсгөлөн зарласан хоригдож буй этгээдэд эмнэлэгийн албадлага хэрэглэхдээ хоригдсон этгээд өөрөө ..... эсэхийг үл хамаарна.
16. Хоригдож буй этгээдийг бие болон хорих өрөөнд үзлэг, нэгжлэг хийхэд хориотой зүйл гарч ирвэл хэрхэн шийдвэрлэх вэ?
19. Хоригдож буй этгээд цагийн хуваарийн дагуу ашиглаж болох зүйлийн нэг

## Сорил:

1. Хорих байранд хоригдох этгээдийг хүлээж авах цагт аль нь хамаарах вэ?
  - a. 06.00 – 20.00
  - b. 07.00 – 21.00
  - c. 08.00 – 22.00
  - d. 09.00 – 23.00
2. Хоригдсон этгээдийн биед хийх үзлэгийг ямар субъект гүйцэтгэх вэ?
  - a. Ижил хүйсийн ажилтан
  - b. Эм
  - c. Ерөнхий жижүүр
  - d. Эмчийн туслах
3. Сэжигтнийг цагдан хорих анхны хугацаа ямар байх?
  - a. 7 хоног хүртэл
  - b. 14 хоног хүртэл
  - c. 30 хоног хүртэл
  - d. 45 хоног хүртэл
4. Хоригдож буй этгээдийг ямар хугацаанд халуун усанд оруулах вэ?
  - a. 7 хоногт 1 удаа
  - b. 7 хоногт 2 удаа
  - c. 14 хоногт 1 удаа
  - d. 15 хоногт 3 удаа
5. Цагдан хоригдож буй этгээдэд ногдох хоолны илчлэгийн хэмжээ ямар байх вэ?
  - a. 3400 кк
  - b. 3600 кк
  - c. 3900 кк
  - d. 4100 кк



## СЭДЭВ.3.8. ШҮҮХИЙН ТОГТООЛ ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ БУСАД БАЙГУУЛЛАГЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

### (Семинар 2 цаг)

Сэдвийн зорилго: Шүүхийн тогтоолыг гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэхэд бусад байгууллагуудтай хамтран ажиллах ажиллагааны зарчим, чиглэлийн талаар мэдлэг олж авах ба практикт хамтын ажиллагааны чиг үүргийг хэрэгжүүлэх чавдартай болно.

### Сэдвийн агуулга:

- Цагдаа, прокурорын байгууллагын хамтын ажиллагаа
- Шүүх, аймаг, орон нутгийн эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагаа
- Өмгөөллийн болон бусад байгууллагуудын хамтын ажиллагаа

### Нэр томъёоны тайлбар:

**Прокурорын хяналт.** Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар прокурор нь ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих ба ял эдлүүлэх ажиллагаа хууль, журамд заасны дагуу явагдаж байгаа эсэх, ялтны эрхийг хангаж байгаа эсэхэд хяналт тавина.

**Үйлдвэрлэлийн чиглэл.** Тухайн хорих ангийн эрхэлж буй үйлдвэрийн үйл ажиллагаа юм. Үүнийг тухайн орон нутгийн Засаг даргатай тохиролцон Засгийн газраас тогтооно.

**Ялтны эрхийг хангах ажиллагаа.** Ялтны эрхийг хуулиар тогтоосон хүрээнд байгаа эсэхэд тавьж буй хяналт, удирдлага, зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалтын арга хэмжээний нийлбэр.

### Сэдвийн тойм:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн тогтоолыг гүйцэтгэхдээ төрийн болон төрийн бус, олон нийтийн байгууллагатай хамтран ажилладаг.

Цагдаагийн байгууллага нь оргосон ялтныг эрэн сурвалжлах, шүүхийн шийтгэх тогтоолоор хорих ял шийтгэгдсэн этгээдийг хорих ял эдлүүлэх байгууллагад хуяглан хүргэх, эрүүгийн ял шийтгэгдэгчдийн тоо бүртгэл хөтлөх зэргээр хамтран ажиллана. Харин прокурорын байгууллага нь бүхий л төрлийн эрүүгийн ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих, зарим төрлийн ялыг өөр төрлийн ялаар солих эсэх дүгнэлтийг шүүхэд гаргах, сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих үйл ажиллагаанд хяналт тавих зэрэг үүргээр хамтран ажилладаг.

Ялтан нь өмгөөлөгчтэй байх эрхтэй бөгөөд энэ тохиолдолд өмгөөлөгч нь хоригдолтой тэдгээрийн байгаа газарт чөлөөтэй нэвтрэн орж, ганцаарчлан уулзах эрхтэй байдаг. Бусад байгууллагуудын нэгэн адилаар шат шатны шүүхийн байгууллагууд нь эрүүгийн ял эдлүүлэх ажиллагаанд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай хамтран ажилладаг.

Шүүх нь цаазаар авах ял оногдуулсан шүүхийн шийдвэртэй хэргийг гомдол, эсэргүүцэл гарсан эсэхээс үл хамааран хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэх, зарим төрлийн ялыг өөр төрлийн ялаар солих эсэх асуудлыг шийдвэрлэх зэргээр хамтран ажиллана. Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлэх бөгөөд төрийн хүсэл зоригыг илэрхийлдэг засаглалын бүрэн эрхтэй төрийн тусгай байгууллага юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын бүх төрлийн ял эдлүүлэх ажил нь гагцхүү шүүхийн хүчин төгөлдөр болсон таслан шийдвэрлэх тогтоолыг хэрэгжүүлэхээс эхэлдэг. Монгол Улсын Шүүхийн тухай хуульд зааснаар (10) шүүхийн шийдвэрээ Монгол Улсын нэрийн өмнөөс гаргаж төрийн сүлд бүхий хэвлэмэл хуудсан дээр үйлдэж, шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зурж, тамга дарна.

Хорих ял оногдуулсан шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолд тухайн хүнийг ямар төрөл, дэглэмийн хорих ангид хэдэн жилийн хугацаагаар ял эдлэвэл зохихыг заасан байдаг тул энэ нь ялтныг ангилан хуваарилах, ялыг нь эдлүүлэх эрх зүйн үндэс болдог. Шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хамтын ажиллагааны нэг томоохон илрэл нь хорих ангид ял эдэлж байгаа хоригдлын ялын дэглэмийг зөөлрүүлэх чангатгах байдлаар өөрчлөх тэднийг хорих ялаас хугацаанаас өмнө тэнсэн суллах буюу хорих ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих, өвчний учир суллахтай холбогдсон албан ёсны санал, тодорхойлолт гаргах шийдвэрлэх явдал юм. Энэ тухай санал тодорхойлолтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага гаргаж, хуульд заасан үндэслэл журмын дагуу Шүүхийн байгууллага шийдвэрлэнэ.

Улсын дээд шүүх аймаг, нийслэл, дүүрэг, сумын болон сум дундын шүүхээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай харьцаж ажиллахдаа дараах зарчмыг баримтлах талаар заажээ.

Үүнд:

- Шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол шийдвэр хүчин төгөлдөр болмогц гүйцэтгэх бичиг баримтыг хуульд заасны дагуу бүрдүүлж ёсчлон шийдвэр биелүүлэх байгууллагад шуурхай хүргүүлж байх
- Шүүхийн шийдвэрт хохирогч нэхэмжлэгч хариуцагчийн ажлын болон оршин суугаа хаяг, өр, төлбөрт гаргуулах эд зүйл, мөнгөний тоо хэмжээг үнийн дүнгээр төгрөгөөр тодорхой үнэн зөв зааж байх
- Хорих ял шийтгүүсэн этгээд хуульд заасан болзол журмыг хангасан гэж үзэж ялаас хугацааны өмнө тэнсэж буюу өөр хөнгөн ялаар сольж суллах өвчний учир



ялаас чөлөөлүүлэх буюу хойшлуулах талаар хорих ял эдлүүлэх байгууллагаас тавьж байгаа асуудалд шуурхай хандаж зөв шийдвэрлэх

- Хариуцагч нас барсан, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр торгох ял торгуулийн арга хэмжээг биелүүлэхгүй байх хуульд заасан үндэслэлээр шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох түдгэлзүүлэх торгох ялыг хорих ялаар солих зэрэгт шуурхай шийдвэрлэж хариу мэдэгдэх зэрэг болно.

Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн. Энэ 2 байгууллагуудын өдөр тутмын болон байнгын уламжлалт хамтын ажиллагааны хэлбэрүүдэд гэмт хэргээс урьдчлан сэргийлэх түүнтэй тэнцэх, нуугдмал гэмт хэргийг илрүүлэх, оргосон ялтныг эрэн сурвалжлах, Улсын онцгой объектыг хамгаалах, ШШГБ-н цагдан хорих байрын дотоод журмыг хэрэгжүүлэхтэй холбогдсон ажиллагаа ШШГБ-н боловсон хүчнийг бэлдэх, давтан сургах хорих ял эдэлж суллагдсан хүмүүст хяналт тавих зэрэг юм.

Сэжигтэн, яллагдагч, ялтан оргох, үймээн гаргах бусдыг барьцаанд авах аливаа хорлон сүйтгэх ажиллагаа явуулах зэргээс урьдчилан сэргийлэх тэдгээрийг илрүүлэх таслан зогсоох ажлын шаардлагатай тохиолдолд Цагдаагийн байгууллагын туслалцааг авч ажилладаг. Төлбөр төлөгчийг эрэн сурвалжлах, олж тогтооход өөрт байгаа мэдээлэл өгөх, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулахад саад учруулж байгаа, эсхүл шийдвэр гүйцэтгэгчийн амь бие, эрүүл мэндэд заналхийлсэн бол цагдаагийн байгууллага туслалцаа үзүүлж болно гэж хуульд заасан байна.

Цагдаагийн байгууллагын нэг өвөрмөц үүрэг бол Улсын онцгой чухал объектыг хамгаалах явдал юм. Тэгвэл ШШГБ-н тогтолцоонд багтдаг гяндан хугацаагүй хорих тусгай салбар чанга онцгой дэглэмтэй хорих ангиуд Улсын онцгой объектод хамаардаг. Мөн Шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсноос хойш 10 хоногийн дотор хоригдлыг уг тогтоолд заасан төрөл, дэглэмийн хорих ангид хүргэж өгөх ажлыг Цагдаагийн байгууллага хариуцан гүйцэтгэж байхаар хуульчлагдсан байна.

Цагдаа, ШШГБ-н хамтын ажиллагааны бас нэг илрэл бол хорих ял эдэлж суллагдсан зарим хүмүүст хяналт тавих юм. Мөн шүүхээр ял шийтгүүлсэн этгээдийн тоо бүртгэлийн мэдээллийн талаар мэдээлэл солилцон бүртгэл хөтлөх явдал юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцох төрийн байгууллагуудад Аймаг нийслэлийн Засаг даргын тамгын газар багтана. Монгол улсын Засгийн оногдуулсан шүүхийн шийдвэр биелүүлэхийг хойшлуулсныг хүчингүй болгосон, ялаас чөлөөлөгдсөн тохиолдолд хэрхэн ажиллах, аймаг нийслэлийн Засаг дарга хорих ангийн үйлдвэрлэлийн чиглэл, байршлыг тогтоох өөрчлөх саналаа ШШГБГ-аар дамжуулан Засгийн газарт тавьж шийдвэрлүүлэх зэргийг заажээ.

Цагдаагийн газар, хэлтэсүүд, аймаг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын харьяанд ажилладаг. Тэдгээр газар хэлтэсүүд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцоод зогсохгүй Аймаг нийслэлийн Засаг даргын холбогдох албадтай зарим төрлийн ял эдлүүлэх эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажилладаг байна. Энэ байдал нь нөгөө утгаараа Аймаг, нийслэлийн Засаг даргын албад ШШГБ-тай хамтран ажиллаж байгаагийн нэг илрэл болдог.

### ХЯНАЛТЫН АСУУЛТ:

1. Шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хамтын ажиллагааны хэлбэр, эрх зүйн зохицуулалт ямар байх талаар ярилцана уу.
2. Цагдаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хамтын ажиллагааны хэлбэр, эрх зүйн зохицуулалтыг дурьдана уу.
3. Байгууллагын хамтын ажиллагааны хэлбэр, эрх зүйн зохицуулалтын онцлогийг ярина уу.
4. Төрийн бус байгууллага, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хамтын ажиллагааны хэлбэр, эрх зүйн зохицуулалтыг дурьдана уу.

### Дасгал:

Төлбөр төлөгч “М” нь төлбөр авагч “А”-д 5 сая, “Д”-д 4 сая, “Г”-д 3 сая төгрөгийн тус тус төлбөртэй. Шүүхийн шийдвэр, гүйцэтгэх хуудсаа төлбөр авагч “А” нь 2009 оны 1 дүгээр сарын 2-ны өдөр, “Д” нь 2009 оны 2 дугаар сарын 28-ны өдөр, “Г” нь 2012 оны 12 дугаар сарын 4-ны өдөр тус тус шийдвэр гүйцэтгэх албанд хүлээлгэн өгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эхлүүлжээ. Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн эд хөрөнгийг худалдан борлуулаад албан дансанд 7 сая төгрөг цугларчээ. Ингээд төлбөрийн шаардлагыг хангах болоход төлбөр авагч “А” нь хамгийн түрүүнд шүүхийн шийдвэрээ гаргуулсан байсан учир 5 сая, үлдсэн 2 саяыг “Д”-д өгсөн байна. Шийдвэр гүйцэтгэгчийн хийсэн ажиллагаа нь эрх зүйн үндэслэлтэй юу?

### Сорил:

1. Оргосон ялтныг эрэн сурвалжлах ажиллагаанд хамтран ажиллах үүрэгтэй байгууллага аль нь вэ?
  - a. Прокурорын байгууллага
  - b. Хууль зүй, дотоод хэргийн яам
  - c. Орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал болон Сум, дүүргийн Засаг дарга
  - d. Цагдаагийн байгууллага



2. Жирийн дэглэмтэй хорих ангийн ялтны телефон ашиглах зардлыг хаанаас гаргах вэ?
  - a. Ялтан өөрөө
  - b. Тогтоол гүйцэтгэх газар
  - c. Тухайн хорих анги
  - d. Халамжийн байгууллага
3. Гадаад улсын харьяат ялтан өөрийн орны дипломат төлөөлөгчдийн газрын ажилтантай уулзах эрхтэй юу?
  - a. Эрхгүй
  - b. Уулзах эрхтэй
  - c. Тогтоол гүйцэтгэх газрын зөвшөөрлөөр
  - d. Прокурорын зөвшөөрлөөр
4. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс ялтанд уучлал үзүүлсэн эсэх тухай хариуг аль байгууллагаар дамжуулан өгөх вэ?
  - a. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
  - b. Тогтоол гүйцэтгэх газар
  - c. Хууль зүйн яам
  - d. Улсын дээд шүүх
5. Хорих ял эдлэгсдийн шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих зардлыг хэн хариуцах вэ?
  - a. Хорих анги
  - b. Ялтан өөрөө
  - c. Тогтоол гүйцэтгэх газар
  - d. Буяны болон халамжийн байгууллага

## БҮЛГИЙН НОМ ЗҮЙ

### *Эрх зүйн баримт бичгүүд*

1. Монгол улсын Үндсэн хууль (1924, 1940, 1960, 1992 он)
2. Монгол ард улсын дотор аливаа хэрэгтэн ялтанг засан сайжруулах тухай хууль 1931 он
3. БНМАУ-ын засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль 1966 он
4. БНМАУ-ын засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль 1981 он
5. Хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай хууль 1993 он

6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны тухай хууль 1994 он
7. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэгжүүлэх тухай хууль 1995 он
8. Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль 1996 он
9. Монгол улсын эрүүгийн хууль 2002 он
10. Монгол улсын эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль 2002 он
11. Монгол улсын иргэний хууль 2002 он
12. Монгол иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй 2002 он
13. Монгол улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2002 он
14. Монгол улсын хөдөлмөрийн хууль 1991 он
15. Монгол улсын захиргааны хариуцлагын тухай хууль 1992 он
16. Монгол улсын төрийн албаны тухай хууль 1994 он
17. Монгол улсын гүйцэтгэх ажлын тухай хууль 1997 он
18. Монгол улсын шүүхийн тухай хууль 2002 он
19. Монгол улсын прокурорын байгууллагын тухай хууль 2002 он
20. Монгол улсын өмгөөллийн тухай хууль 2002 он

### **Эрх зүйн акт:**

1. ХЗДХ-ийн сайдын 2009 оны 195 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт “Дамжин өнгөрүүлэх ангид мөрдөх дэглэм, харуул хамгаалалтын журам”
2. ХЗДХ-ийн сайдын 2009 оны 195 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт “Тогтоол гүйцэтгэх газрын харьяа нэгдсэн эмнэлэгт мөрдөх дэглэм, харуул хамгаалалтын журам”
3. ХЗДХ-ийн сайдын 2009 оны 198 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт “Ялтныг нийгэмшүүлэх хөтөлбөр”
4. ХЗДХ-ийн сайдын 2002 оны 276 дугаар тушаалын хавсралт “Албадан ажил хийлгэх ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэхэд хяналт тавих журам”
5. ХЗДХ-ийн сайдын 2002 оны 275 дугаар тушаалын хавсралт “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх журам”
6. ХЗДХ-ийн сайдын 2002 оны 270 дугаар тушаалын хавсралт “Сахилгын байр, тусгаарлах тасалгааны нөхцөл журам”
7. ХЗДХ-ийн сайдын 2002 оны 252 дугаар тушаалын хавсралт “Тодорхой албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрх хасах ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих журам”



8. ШШГЕГ-ын даргын 2008 оны 11 сарын 20-ны өдрийн А/115 дугаар тушаалын хавсралт “Ялтныг мэргэжлийн түр сургалтад хамруулах, шалгалт авах, мэргэжлийн чадамжийн гэрчилгээ олгох журам”
9. ШШГЕГ-ын даргын 2010 оны А/73 дугаар тушаалын хавсралт “Ялтанд шагналын хоног олгох, тэнсэн суллах, ялын дэглэмийг өөрчлөхөд мөрдөх журам”
10. ШШГЕГ-ын даргын 2009 оны 5 сарын 27-ны өдрийн А/54 тоот тушаалын нэгдүгээр хавсралт “Тэргүүний хүмүүжигчийн урамшуулал тогтоох журам”
11. ШШГЕГ-ын даргын 2009 оны 5 сарын 20-ны өдрийн А/48 тоот тушаалын нэгдүгээр хавсралт “Баривчлах ял эдлүүлэх байрны дотоод журам”
12. ШШГЕГ-ын даргын 2009 оны 7 сарын 29-ны өдрийн А/78 тоот тушаалын хавсралт “Өвчний болон бусад шалтгааны улмаас нас барсан ялтныг оршуулах ажлыг зохион байгуулах журам”
13. ШШГЕГ-ын даргын 2009 оны А/11 тоот тушаалын хавсралт “Чанга ,онцгой дэглэмтэй хорих анги, гяндангийн болон цагдан хорих төвийн гадна хамгаалалтыг зохион байгуулах журам”
14. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2008 оны 50 дугаар тушаалын хавсралт “Хорих ангийн дотоод журам”
15. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2008 оны 51 дугаар тушаалын хавсралт “Хорих ангийн харуул хамгаалалтын болон ялтанд хяналт тавих журам”
16. ШШГЕГ-ын даргын 2007 оны А/15 дугаар тушаалын хавсралт “Ялтынг хуяглан хүргэх заавар”
17. Монгол Улсын хууль зүй, дотоод хэргийн яам, Эрүүл мэндийн яамны сайдын 2002.12.31-ний 313/316 тоот тушаал “Ялаас чөлөөлөх өвчний жагсаалт, хүнд өвчтэй ялтанд эмнэлгийн бусад байгууллагын туслалцаа үзүүлэх журам”

***Ном, сурах бичиг, нэг сэдэвт бүтээл:***

1. А. Лхагва “Монгол улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй” 2004 он
2. А. Лхагва “Засан хүмүүжүүлэх байгууллагын товч түүх” 1996 он
3. А. Лхагва, С.Жанцан “Монгол улсын эрүүгийн ял эдлүүлэх эрх зүй” 1996 он
4. А. Лхагва “Монгол улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүхэн замнал” УБ 2008 он
5. А. Лхагва, С.Жанцан, О.Энхбат “БНМАУ-ын засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн эрх зүй” /ерөнхий анги, альбом, схем/ 1996 он
6. Б.Дашзэвэг “Монгол улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй” /ерөнхий анги, тусгай анги /2003 , 2004 он
7. Б.Дашзэвэг “Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн сурган хүмүүжүүлэх эрх зүй” 1976 он

8. Б.Дашзэвэг “БНМАУ-ын засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн эрх зүйгээр ялтныг засаж, дахин хүмүүжүүлэх үйл явцыг зохицуулах зарим асуудал” 1983 он
9. Б.Дашзэвэг “Ялтныг засаж, хүмүүжүүлэх ба дахин хүмүүжүүлэх үндсэн арга хэрэгсэл” 1983 он
10. О.Алтангэрэл, О.Алтангэрэл “Шийдвэр гүйцэтгэгчийн ном” УБ 2004 он
11. В.Шаллер “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн сургалтын материал” УБ 2007
12. В.Шаллер “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа” УБ 2004 он
13. Д.Бадам, Б.Цэрэнчимэд “МУ-ын эрүүгийн ял эдлүүлэх эрх зүй” УБ 2003 он
14. Л.Чүлтэмсүрэн “Засан хүмүүжүүлэх байгууллагын товч түүх” 1979 он
15. С.Нарангэрэл “БНМАУ-ын засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн эрх зүйн үндсэн асуудал” 1985 он
16. Н.Галрагчаа, Г.Чимэддорж “Ялтныг дэглэмийн онцлогоор засаж, дахин хүмүүжүүлэх арга зүйн зарим асуудал” 1989 он
17. Д.Батжаргал, Г.Чимэддорж “Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн сэтгэл судлал” (зохиомжлон орчуулсан) 1989 он
18. Б.Ундрах, Ё.Туяа “Эд хөрөнгийн холбогдолтой иргэний хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх үйл ажиллагааг зохицуулах хууль, эрх зүйн баримт бичгийн эмхтгэл” 2001 он
19. С.Жанцан “Хорих ял эдлүүлэх газраас суллагдсан хүмүүсийг рецидив гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал” 1989 он
20. А.Алтанзул “Албадан ажил хийлгэх ялын хэрэгжилтийн өнөөгийн байдал, түүний эрх зүйн орчинг боловсронгуй болгох зарим асуудал” УБ 2007 он
21. О.Энхбат “Хорих ял эдлүүлэх дэглэм түүнийг хангах хэрэгсэлүүд” 1989 он
22. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай монгол улсын хууль түүнд холбогдох эрх зүйн баримт бичгийн эмхтгэл” / Эмхтгэсэн Н.Оюунчимэг, хянан тохиолдуулсан Х.Уламбаяр / 2003 он
23. ШШПГЕГ-аас гаргадаг “Эрх зүй, албаны мэдээлэл сэтгүүл” /улирал бүр /
24. “ОУ-ын гэрээ конпенци баримт бичгийн эмхтгэл” 2006 он
25. Ц.Мөнбат “Монгол улс дахь эрүүгийн зарим ялын эрх зүйн зохицуулалт” /Монголын төр эрх зүй сэтгүүл 2006 он №4 /
26. Н.А.Стручков “Курс исправительно- трудового права” М., 1984г
27. В.П. Артамонов /доктор, профессор/ “Наука советского исправительно- трудового права” М., 1974г
28. А.Д.Глоточкин, В.Ф. Пирожков “Исправительно- трудовая психология” М., 1974г



### **СЭДЭВ.3.9. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГАА, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ БА НҮБ БОЛОН ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГААС ЯЛ ЭДЛҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ГАРГАСАН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА**

#### **(Семинар 2 цаг)**

Сэдвийн зорилго: Шүүхээс гарсан тогтоолыг гүйцэтгэх ажиллагааны жишиг стандарт, гадаадын зарим улс орны ял эдлүүлэх үйл ажиллагааны онцлог, НҮБ-ээс хорих болон хорихоос бусад төрлийн ял эдлүүлэх чиглэлээр гаргасан эрх зүйн баримт бичгийн агуулгын талаар мэдлэгтэй болсноор улс орнуудын ял эдлүүлэх эрх зүйн зохицуулалтыг харьцуулах чадвартай болж, улмаар Монгол улсын ял эдлүүлэх байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай байгаа эрх зүйн зохицуулалтыг хэрэгжүүлэх хандлага төлөвшихөд оршино.

#### **Сэдвийн агуулга:**

- Хэрэгтэн, ялтангай харьцах наад захын жишиг дүрэм, түүний агуулга
- Хоригдолтой харьцах үндсэн зарчим
- Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүсийг хамгаалах дүрмийн агуулга
- Хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрэм
- Хэрэгтэн, ялтанг хандах чиглэлээр үйлчилж байгаа Олон улсын баримт бичгийн төрөл, хорихоос өөр төрлийн ял эдлэгсэд хамаарах Олон улсын эрх зүйн баримт бичиг, тэдгээрийн агуулга.

#### **Нэр томъёоны тайлбар:**

**Хэрэгтэн ялтангай харьцах.** Хорих ял эдэлж байгаа ялтан бүртэй хүн гэдэг нэрээр нь хүндэтгэн хүлээн авч харьцахыг ойлгоно.

**Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх.** Хорихоос өөр ялын төрөлд баривчлах, торгууль, албадан ажил хийлгэх, эд хөрөнгө хураах, тодорхой албан тушаал эрхлэх, тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах зэрэг хамаарна. Эдгээр ялыг ШШГЕГ-ын харьяа аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх алба Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан журмын дагуу эдлүүлнэ.

**Хорих ял эдлүүлэх.** Монгол Улсын Эрүүгийн хуулийн 52 дугаар зүйл 52.1-ээс 52.11 заасны дагуу ял эдлүүлэхийг хэлнэ.

**Насанд хүрээгүй хоригдол.** Монгол Улсын Эрүүгийн хуулийн 21 дугаар зүйлийн 21.1 21.2 21.3 зүйлд заасан субъектүүдийг ойлгоно.

**Хүний эрх, эрх чөлөө.** Хүний төртэй харьцах, түүний эдийн засгийн нийгэмшлийн, улс төрийн, соёлын хүрээн дэх боломж ба шаардлагын эрх зүйн байдлыг тодорхойлсон ухагдахуун юм.

**Шорон.** Хорих ялыг албадан эдлүүлдэг төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллага. Шорон нь шороон гэсэн үгнээс үүсэж энэ нь аажимдаа шорон гэдэг үг болон хувирсан хэмээн үздэг.

**Хамгаалалтын хүч хэрэгсэл.** Хорих газрын харуул хамгаалалтын болон бусад мэргэжлийн ажилтнууд, галт зэвсэг, тусгай хэрэгсэл, хамгаалалтын бүс тэдгээрийн техник тоног төхөөрөмж, албаны нохой, болзошгүй ажиллагаанд ажиллах төлөвлөгөө болон хуулийн дагуу явуулж буй бусад ажиллагаа.

**Дэглэм.** Дэглам гэсэн төвд үг. Лам гэдэг нь монгол хэлний эр үгийн эгшигт хувираад – лэм болсон. Дэг гэдэг үг төвд хэлэндээ сайхан үг. Дэгтэй хүн, дэгтэй хүүхэд, ер нь зурчихсан хэм хэмжээ гэж ойлгоно.

**Сэжигтэн.** Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч эрүүгийн байцаан шийтгэх хуулиар тогтоосон үндэслэл журмын дагуу эрүүгийн хэрэг үүсгэн шалгагдаж байгаа хүнийг хэлнэ.

**Яллагдагч.** Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол үйлдэж ял сонгосон этгээдийг хэлнэ.

**Ялтан.** Гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон, өөрөөр хэлбэл, шүүх гэм буруутайг нь тогтоож хорих ял болон хорихоос өөр төрлийн ял оногдуулсан этгээдийг хэлнэ.

### Сэдвийн тойм

Энэ сэдвийн хүрээнд гадаадын зарим улс орны ял эдлүүлэх ажиллагаа, эрх зүйн зохицуулалт болон монгол улсын ял эдлүүлэх ажиллагаа түүний эрх зохицуулалтын онцлогийг судлан үзэж, өөрийн орны ял эдлүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй асуудлыг судлах юм.

Америк, Канад, Австрали, Умард Ирланд, Шинэ Зеланд зэрэг олон улс орны эрх зүйн суурь нь Англо-Саксоны эрх зүйн бүл бөгөөд дэлхийн улс орнуудын бараг гуравны нэг хувьд энэхүү эрх зүйн бүл үйлчилж байна. Англо-Саксоны эрх зүй нь Их Британи буюу Англид анх бий болсон ба нийтийн эрх зүйн төрөл ч ч гэж нэрлэдэг талаар өмнөх хичээлүүдэд судалсан билээ.

Англи-Саксоны эрх зүйн бүлийн гол шинж нь шүүхийн хэвшүүлж хэрэглэх хэм хэмжээг эрх зүйн эх сурвалжаа болгодог. Эх газрын эрх зүйн нэгэн адил эрх зүйн салбаруудыг тодорхойлон хувааж ангилсан зүйл байдаггүй, материаллаг эрх зүйгээс процессын эрх зүйг илүүтэйгээр авч үздэг онцлогтой. Шүүхийн прецедент нь тухайн орны шүүгчдийн хэрэглэж, хэвшүүлэн зохицуулсан хэм хэмжээ юм. Англо-Саксоны эрх зүйн системтэй улс орнуудыг төлөөлөн Англи, АНУ зэрэг улсуудад эрүүгийн ял эдлүүлэх эрх зүйн зохицуулалт ямар байдаг талаар авч үзье.



## **Англи улс**

Английн энэрэнгүй үзэлтэн Джон Говард анх 1977 онд Уельс шоронгийн байдлын тухай номоо хэвлүүлснээр улс даяараа гэмт хэрэгтэн хүнд ял шийтгэлийг ямар журмаар эдлүүлэх тухай ойлголт бий болсон гэж үздэг байна. Д.Говард шорон бол ямар газар байх ёстойд дараах тайлбар өгсөн байна. Шорон бол залхаан цээрлүүлэх газар биш, харин гэмт хэрэгтнийг хүмүүжүүлэх, хөдөлмөр хийлгэх, уг хөдөлмөр нь хүнийг зовоосон шинжгүй байх, хэрэгтнийг нас хүйсээр нь ангилж, төрөлжүүлэн дэглэмээр ял эдлүүлэх тухай дурьдсан нь дэлхийн улс орнуудад жишиг болж, өнөөг хүртэл хорих ял эдлүүлэх ажиллагааны зарчим болсон гэж үзэх бүрэн үндэстэй.

## **АНУ**

АНУ-ын ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт холбооны улсуудын хэмжээнд ямар байгааг авч үзэхэд АНУ-ын шүүхээс ихэнхдээ барьцаалах, торгууль хүлээлгэх, хорих ял эдлүүлэх гэсэн ялын төрлийг хэрэглэдэг байна.

Барьцаалах ял гэдэг нь ялыг тэнсэж, шүүхийн шийдвэр биелүүлэхийг тодорхой хугацаагаар хойшлуулах ойлголт бөгөөд хорихоос бусад төрлийн ялд хамаарна. Барьцаалах ялын дундаж хугацаа нь 1-5 жил байхаар заажээ. Барьцаалах ялын үндсэн нөхцөл нь энэ төрлийн ял эдлэх хугацаандаа шинээр гэмт хэрэг үйлдэхгүй байхыг шаардана. Барьцаалах ялын нөхцөлийг хэрэгтэн ялтан зөрчвөл ял эдлүүлэх байгууллагын санаачилгаар шүүх өөр төрлийн ялаар солих шийдвэр гаргадаг байна.

Торгуулийн ял АНУ-д хамгийн өргөн дэлгэр хэрэглэгддэг ялын төрөл бол торгууль юм. Үйлдсэн гэмт хэргээс хамаарч 1000 - 500,000 хүртэл ам долларын торгуулийн ял оногдуулдаг байна.

Хорих ялыг ямар журмаар эдлүүлдэг талаар товчхон дурьдвал, 2 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгүүлсэн бол төрөлх хотынх нь хорих газар, 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгүүлсэн этгээдийг шаардлагатай гэж үзсэн нөхцөлд штатын, бусад тохиолдолд 5-аас дээш жилийн хорих ялтай хоригдлуудыг штатын хорих ангид ял нь эдлүүлэхээр хувиарладаг байна. АНУ-д хорих байгууллагын төрөл, дэглэмийг дараах байдлаар тогтоодог байна.

## **Нээлттэй**

- Хамгийн бага аюулгүй байдалтай дэглэм
- Дунд зэргийн аюулгүй байдалтай дэглэм

Нээлттэй дэглэмд эдэлж буй ялтнууд илүү эрх чөлөөтэй шоронгоосоо ажил хөдөлмөр эрхлэх боломжтой ба тэнд хөнгөн гэмт хэрэг үйлдсэн этгээд ял эдэлдэг. Харуул хамгаалалт нь энгийн, нүсэр хамгаалалт шаарддаггүй байна.

### Хаалттай

- Дээд зэргийн аюулгүй байдалтай дэглэм
- Онц аюултай байдалтай дэглэм гэж ангилдаг

Хаалттай дэглэмийн хувьд нээлттэй дэглэмийг бодвол хязгаарлалт илүү байдаг байна. Өндөр хашаа, хүч нэмэгдүүлсэн хамгаалалттай байх ба энд онц аюултай гэмт хэрэг үйлдсэн ялтнууд ялаа эдэлдэг. Англо-Саксоны эрх зүйн системтэй улс орнуудын хувьд эрх чөлөөг хасах дэглэм нь зөвхөн нээлттэй, хаалттай гэсэн 2 хэсэгт ангилагдана. Дэглэм дотроо 3-4 зэрэглэлтэй. Энд ялтнуудын засрал хүмүүжлийг оноогоор дүгнэж ялгавартайгаар ял эдлүүлдэг онцлогтой.

Ром Германы эрх зүйн тогтолцоотой ОХУ, ХБНГУ-ын ял эдлүүлэх эрх зүйн зохицуулалтыг талаар авч үзье. Ром Германы эрх зүйн тогтолцоотой орнуудын эрх зүйн онцлог шинжийг ОХУ-ын эрдэмтэн, судлаач Ю.А. Тихомиров дараах байдлаар нэрлэн заажээ.

- Эрх зүйт төрийн номлолыг хүлээн зөвшөөрдөг.,
- Үндсэн хуулийн хяналтын тогтолцоотой байхыг эрхэмлэдэг.,
- Захиргааны шүүхийн зохицуулалттай байх.,
- Олон шашны тогтолцоог зөвшөөрдөг гэх мэт.

Ром Германы эрх зүйн бүл нь эртний Ромын эрх зүйтэй салшгүй холбоотой бөгөөд онцлог шинж нь бичмэл эрх зүйд тулгуурласан, заншлын болон прецедент хэрэглэхээс татгалзан, хуулийг эрүүгийн эрх зүйн хэм хэмжээний цорын ганц эх сурвалж хэмээн үздэгт оршино.

ОХУ-ын эрдэмтэн, судлаачид ял эдлүүлэх дэглэм, ял эдлүүлэх эрх зүйн зохицуулалт ямар байх талаар өөрсдийн үзэл баримтлалыг дэвшүүлсэн байдаг. Тухайлбал, доктор А.С. Михлин шүүхийн шийдвэр гүйцэтгэх хууль болон үүнтэй холбогдож гарсан эрхийн хэм хэмжээний актын хурээнд баривчлах ба тодорхой хугацаагаар эрхийг хязгаарлах, бүх насаар хорих ялыг эдлүүлэх, нийгмээс тусгаарлахтай холбогдсон асуудлыг өөртөө багтаасан ойлголт хэмээн тайлбарласныг ихэнх судлаачид дэмжиж бичсэн нь байдаг.

ОХУ-д хорих ял эдлүүлэх байгууллага засан хүмүүжүүлэх колони, гяндан, хөдөлмөр хүмүүжлийн колониуд гэж ангилагдсан тогтолцоотой ба эдгээр нь жирийн, чанга. онцгой гэсэн дэглэмүүдтэй байна. Монгол улсын хувьд 1990 оноос өмнөх хууль эрх зүйн бодлого, шинэчлэл бүхэлдээ ЗСБНХУ-ын жишээ, туршлагад тулгуурлаж ирсэнийг хуульчид хүлээн зөвшөөрдөг. Тийм ч учраас ОХУ, манай улсын өнөөгийн хорих байгууллагын тогтолцоо, дэглэм адил мэт боловч бас өөр өөрийн онцлогтой. Тухайлбал, ОХУ-д суурин колони гэж нээлттэй дэглэм байдаг. Суурин колонид ял эдэлж байгаа хоригдол нийтийн байранд хоригдож, өглөө ажил сургуульдаа яваад орой хорих байрандаа ирдэг байна.



Тэнд харуул хамгаалалтын өвөрмөц алба ажиллаж, бүртгэл болон хяналтын нарийн системийг нэвтрүүлсэн байдаг байна. Хэрэв ялтан хугацаандаа байрандаа эргэж ирэхгүй байх, эсхүл ямар нэгэн байдлаар дүрэм зөрчвөл бусад дэглэмийн засан хүмүүжүүлэх колони руу шилжүүлдэг. Анх удаа гэмт хэрэг үйлдэж 1-3 жил, санамсаргүй гэмт хэрэг үйлдэж 1-5 жилийн ялтай этгээдүүд энд ялаа эдэлдэг байна. Хорихоос өөр төрлийн ялын төрөл болох эрх хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаа хамгаалалтын бүсгүй, харуул хамгаалалттай талбайгүй байдаг. Эрх хязгаарлах ял эдлэгчид засан хүмүүжүүлэх байгууллагын захиргаанаас хэт алслагдмал байх ёсгүй. Хил хязгаар нь 5 км-ээс хэтрэхгүй байдаг. Суурин колоний хил хязгаар мөн адил. Ялгаа нь суурин колони орон нутагт хөдөө аж ахуйн чиглэлийн эрхлэн гүйцэтгэдэг байна.

Холбооны Бүгд Найрамдах Герман улсад ХХ зууны эцэс хүртэл Герман улсын эрүүгийн ял эдлүүлэх үйл ажиллагаа, эрх зүйн системд “Хүмүүжил аюулгүй байдлын арга хэмжээ” гэсэн төрөл байсаар иржээ. Герман улсад хамгийн өргөн хэрэглэгддэг ялын төрөл нь торгох ял юм. Энэ нь хорихоос өөр төрлийн ял бөгөөд торгох ялыг шүүх ялтны цалингийн хэмжээг харгалзан тогтоодог байна. Хорих ялын хэмжээ нэг сараас 15 жил, эсвэл бүх насаар нь хорих хугацаатай. Хоригдол 15-аас доошгүй жил хорих ял эдэлсэний дараа түүний үлдсэн ялыг зохих нөхцөлтэйгээр хойшлуулж болдог.

ХБНГУ-ын хорих байгууллагын тогтолцоо нь:

1. Нээлтэй хорих анги: Тэнд хор хохирол багатай гэмт хэрэг үйлдсэн этгээдийг 6 сар хүртэл хугацаагаар хорино. Ийм төрлийн хорих анги олон биш байдаг.
2. Хаалттай хорих анги: 6 сараас дээш хугацаагаар хоригдох болсон гэмт этгээдүүд ял эдэлдэг. Энд ирсэн ялтан эхний ээлжинд ганцаар хоригдох ба үүнийг гэм буруугаа ухамсарлах боломж олгож байна гэж үздэг. Хоригдлын хөдөлмөр ажлын 5 өдөрт өдөр тутам 8 цаг ажиллахаар зохион байгуулагдсан байдаг. Ихэнхдээ гар ажиллагаа зонхилсон үйлдвэрлэл эрхэлдэг. Зарим тохиолдолд хувийн фирмд гэрээгээр ажиллах боломжтой. Хоригдлын хөдөлмөр нь тухайн хоригдлыг жирийн нийгмийн гишүүдийн адил ажиллаж, амьдрахад нь туслах зорилготой юм.

Франц улсын ял эдлүүлэх байгууллага нь насанд хүрэгчдийн төвлөрсөн хорих, орон нутгийн хорих байгууллага, насанд хүрээгүйчүүдийн тусгайлсан сургалт, хүмүүжлийн байгууллагаас бүрдэнэ. Хорих ялыг төвлөрсөн хорих ангид эдлүүлдэг. 1 жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн хоригдол ялаа төвлөрсөн хорих ангид эдэлдэг байна. Шинээр ирсэн хоригдлыг шоронгийн байдалд дасгахын тулд 45 хүртлэх хоног ганцаарчилсан тасалгаанд байлгадаг. Тэднийг засарч хүмүүжих зан төлөвөө олсон, олоогүй, эргэлзээтэй байгаа гэж ангилдаг. Засрах төлөвөө олсон хоригдлууд өдөр нь хамтарч ажиллаад, шөнө нь ганцаарчилсан тасалгаанд байрлана. Засрал хүмүүжлийн түвшингээрээ сайн гэж үнэлэгдсэн хоригдлын ахуй нөхцөлийг

сайжруулах, хагас хөнгөн дэглэмд шилжүүлэх, шоронгоос гадна ажиллах, төрөл төрөгсөдтэйгээ уулзах, хугацаанаас өмнө тэнсэн суллах гэх мэт урамшил үзүүлдэг байна.

Орон нутгийн хорих байгууллагад шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болохыг хүлээж байгаа яллагдагч, хор хохирлын хэмжээ багатай гэмт хэрэг үйлдсэн ялтан, 1 жил хүртэл хугацаагаар хорих ял шийгүүлсэн этгээдийг байрлуулдаг. Насанд хүрээгүй хоригдлыг тусгай байгуулсан хүмүүжлийн байгууллага болон сургуульд байлгаж ялыг нь эдлүүлдэг. Франц улсын ял эдлүүлэх ажиллагааны нэгэн онцлог бол насанд хүрээгүй хоригдлыг шашин, буяны болон хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулдаг олон нийтийн байгууллагад ялаа эдлэхийг зөвшөөрдөг. Нөгөөтэйгүүр Франц улсын шүүх хоригдлын эдлэх ялын хугацааг хасч багасгах, хугацаанаас нь өмнө тэнсэн суллах эрхтэй.

Сингапур улсад хорих ял эдлүүлэх ажиллагаа ялтнаа хүмүүжүүлэх, нийгэмд зөв хүн болгон төлөвшүүлэхэд чиглэдэг байна. Тухайлбал, гэмт хэрэг үйлдсэн этгээд сэтгэл санааны хувьд ихээхэн хямралтай хүмүүс байдаг тул хамгийн түрүүнд тэдний сэтгэл зүйг эмчлэх, сэргээх, ингэснээр сэтгэл зүйчид, нийгмийн ажилтнууд тэдэнтэй нэг бүрчлэн ажиллаж, үйлдсэн гэмт хэргийн бурууг ухамсарлуулан ойлгуулахад ял эдлүүлэх ажиллагаа чиглэгдэх учиртай хэмээн үздэг. Тийм ч учраас нэг хорих ангид дунджаар 1152 ялтан ял эдлэхэд 10 ялтан тутам 1 албан хаагч, нийгмийн ажилтан оногддог гэсэн тооцоо байдаг. Тэдний дунд зохиох сургалт хүмүүжлийн ажилд хорих анги анхаарлаа нилээд хандуулдаг. Олон чиглэлээр сургалтыг зохион байгуулна. Үүнд:

- Ерөнхий боловсролын сургалт.,
- Мэргэжлийн сургалт.,
- Зан байдлыг өөрчлөх зэргээр сургалтыг төрөлжүүлэн явуулахад бүс нутгийн боловсролын байгууллага идэвхтэй дэмжлэг туслалцаа үзүүлдэг байна.

Сингапурын шоронгийн ажилтнууд хоригдлыг нийгэмшүүлэх ажлын туршлагаараа бүс нутагтаа тэргүүлдэг тухай Канадад болсон ял эдлүүлэх ажиллагааны талаарх бага хурлын илтгэлд тэмдэглэсэн байдаг.

Хоригдлыг нийгэмшүүлэх талаар Их Британи болон ХБНГУ-аас улсын дэвшүүлж байгаа саналыг Израйль, Нидерланд, Латин Америкын орнууд, Сингапур, Австрали, Канад зэрэг олон орнууд талархалтайгаар хүлээн авч, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлж иржээ. Энэ ажилд хорих байгууллагууд бизнесийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах нь үр дүнгээ өгдөг талаар ч улс орнуудын туршлага байна.

Австрали улс ялтнуудаа нилээд нарийн ангилсны үндсэн дээр ял эдлүүлдэг байна. Тухайлбал, насаар нь залуучууд, настайчууд, насанд хүрээгүйчүүд, хүйсээр нь эрэгтэй, эмэгтэй, мөн түүнчлэн хар тамхинд донтогсод, онц хүнд гэмт хэрэгтнүүд,



гэх мэтээр ангилан ял эдлүүлдэг. Хэрэв эмэгтэй ялтан хүүхэдтэй бол тусдаа ял эдлэх боломжоор хангадаг байна. Австралийн засан хүмүүжүүлэх байгууллагууд хоригдож байгаа хүмүүсийг сургах, хүмүүжүүлэх талаар сайн анхаарихын зэрэгцээ мэргэжлийн сургалтыг өндөр түвшинд явуулдаг. Тухайлбал, шаазан эдлэл, цахилгаан тоног төхөөрөмжийг засах болон зохион бүтээх сургалтууд явагдаж ялтнуудаа өргөн оролцуулдаг байна. Тус улсын аль ч хорих ангид мэргэжлийн сэтгэл зүйчид, нийгмийн ажилтнууд ажиллаж ялтны сургалт хүмүүжлийн ажлыг зохион явуулж улмаар тэдний цаашдын засрал хүмүүжилд ихээхэн анхаарч ажилладаг байна.


Австралийн Сидней хотод чанга дэглэмтэй эрэгтэйчүүдийн хорих анги байрлах бөгөөд энэхүү хорих ангид ял эдлүүлэхдээ ялтныг ганцаарчлан байрлуулах бөгөөд өглөө 8 цагаас оройн 8 цаг хүртэл сургалт, хүмүүжлийн ажилд оролцон хөдөлмөрлөх зэргээр бусад ялтнуудтай хамт чөлөөт цагаа өнгөрүүлэх ба бусад үед ялтан ганцаар байрладаг журамтай.

### **Олон улсын хүний эрхийн байгууллагаас ял эдлүүлэх ажиллагааны талаар гарсан баримт бичгийн агуулга**

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цагдан хорих, ял эдлүүлэх ажиллагаанд шинэ шаардлага тавигдаж түүнийг зөв шийдвэрлэх явдал зөвхөн тухайлсан нэг орны асуудал биш юм. Олон улсын хэмжээнд шоронгийн шинэчлэлийн үйл явц хэрэгжиж, улс орон бүр түүнийг хүлээн зөвшөөрч байгаа өнөө манай улсын хорих байгууллагын албан хаагчид хүний эрх, эрх чөлөөг хуулиар хязгаарлахад оролцогчийн хувьд хүний эрхийн суурь зарчмыг зайлшгүй мэдэж байх шаардлагатай. Иймд олон улсын хүний эрхийн пактууд ял эдлүүлэхэд хүний эрхийг хангах хамгаалах зарчмыг Энэ сэдвийн хүрээнд судлах юм.

1999 онд Лондон хотноо дэлхийн 50 гаруй орны шүүх, шүүүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын төлөөлөгчид хуран чуулж гаргасан баримт бичигт тодорхой тусгагджээ. Маш олон улс орны шоронд хоригдогчдын, ялангуяа урьдчилан мөрдөн байцаалтын явцад тэдний дийлэнх олонх нь эрх зүйн хэвийн туслалцаа авах боломжгүй буюу тун бага боломжоор хангагддаг Шорон нийгэмд тун бага ашиг өгч хоригдогчдын гэр бүлийг бусниулж, хохирогчдын ашиг сонирхлыг хангаж чаддаггүй болсон гэж тус тус үздэг. Хэдийгээр хуульд заасан үндэслэлээр эрүүгийн хэрэгт холбогдуулан баривчлаж байгаа ч гэсэн баривчлах ажиллагааны хэм хэмжээг хэтрүүлбэл дур мэдэн баривчлахтай адилтган үздэг байхыг тэмдэглэжээ. Энд дөрвөн чиглэлийн сонгож авъя.

## Сэжигтэн яллагдагч Хоригдлын эрхийг хамгаалах




ИУТЭОУПактаар Хоригдсон буюу саатуулагдеан хүмүүст хүч хэтрүүлэн хэрэглэхийг хориглосон байдал бүх нөхцөлд хориглох боломжгүй юм. Учир нь хууль сахиулагч албан тушаалтнууд гарцаагүй тохиолдолд үүргээ биелүүлэхэд шаардлагатай хэмжээгээр хүч хэрэглэж болно.


Олон Улсын Хүний эрхийн хэм хэмжээ нь хүнийг хууль бусаар дур мэдэн баривчилж эрх чөлөөг нь хязгаарлахгүй байх болон албадан суутуулагдсан үед гарч болох бусад хэлбэрийн зөрчил гарахаас давхар хамгаалсан байдаг. Олон улсын баримт бичигт хорих цагдан хорих газар бол заавал хянах ёстой газар гэж үздэг. Яагаад хянах ёстой вэ? гэвэл: Шүүхийн өмнөх шатанд гэмт хэрэгт сэжигтэн яллагдагчаар татагдахад хувь хүн эрх чөлөөгөө гэлтгүй бусад эрхээ алдах эрсдэлтэй байдаг. Иймд сэжигтэн ялдагчдийн эрхийг зайлшгүй хамгаалах шаардлагатай болдог. Шүүхийн өмнөх шатанд байгаа гэдэг утгаараа сэжигтэн яллагдагчийн эрхийг хамгаалах, тэдэнтэй харьцах талаар илүү болгоомжтой байх учиртай.

ИУТЭОП  
9 ДҮГЭЭР  
ЗҮЙЛ 9.1

“дур мэдэн” хэмээх нэр томъёог зөвхөн хууль бус хорьж саатуулахыг хэлээд зогсохгүй хүч хэтрүүлсэн, шударга бус болон хойшлуулшгүй эсхүл таамаглах аргагүй гэсэн нөхцөлүүдийг агуулсан илүү өргөн агуулгатай гэж тайлбарласан байна



Монгол улс 2000 онд “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгийн хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенци-д нэгдэн орсон.



Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийн эрхийг хамгаалах зарчмууд

Баривчлагдсан хүн бүрт түүнийг баривчлах болсон шалтгааныг баривчлах үед мэдээлж, аливаа сонгосон ялыг түүнд нэн даруй мэдэгдэх ёстой.

Эрүүгийн хэргээр яллагдаж байгаа бүх хүн өөрийнхөө өмгөөлөгчтэй найдвартай уулзах цаг, байрны нөхцөлөөр бүрэн хангах ёстой.

НҮБ-ын ерөнхий Ассамблей 1958-12-09

### Тэнсэн болон тэнсэн суллагдсан эрх зүйн зөрчил үйлдэгчдэд тавих хяналт

Тэнсэн болон тэнсэн суллагдсан эрх зүйн зөрчил үйлдэгчдэд тавих хяналтыг шилжүүлэх тухай үлгэрчилсэн гэрээ

Ерөнхий Ассамблейн 1990 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 45/118 тоот тогтоолоор батлав.

### ХЯНАЛТЫН АСУУЛТ:

1. НҮБ-ын дүрэм тус бүрийн хэрэгжилтийг өөрийн орны ял эдлүүлэх ажиллагааны жишээн дээр харьцуулан авч үзнэ үү.
2. Хорих ял эдлүүлэхтэй холбоотой олон улсын эрх зүйн баримт бичгүүд нь үндэсний хууль тогтоомжид хэрхэн нөлөөлөх вэ?
3. НҮБ-ын жишиг дүрмүүдийн заалтын хэрэгжилтийг гадаадын зарим орон, тухайлвал: АНУ, Англи, Герман, Франц, Япон, ОХУ-ын жишээн дээр тулгуурлан тайлбарлана уу.



## Сорил

1. Англи-Саксоны эрх зүйн бүлийн гол шинж нь юу вэ?
  - a. Эрх зүйн салбаруудыг тодорхой хувааж ангилдаг.
  - b. Шүүхийн хэвшүүлж хэрэглэх хэм хэмжээг эрх зүйн эх сурвалжаа болгодог.
  - c. Нийтийн эрх зүйн төрөлд багтдаггүй.
  
2. Олон улсын хэм хэмжээнд шоронг ямар газар гэж үздэг талаар
  - a. Гэмт хэрэгтнийг хүмүүжүүлэх
  - b. Хэрэгтэн ялтныг цээрлүүлэх
  - c. Дэглэмээр ангилж ял эдлүүлэх
  
3. ОХУ-ын эрх зүйн тогтолцооны онцлогийг нэрлэнэ үү.
  - a. Бичмэл эрх зүйд тулгуурладаг
  - b. Заншлын болон прецедент хэрэглэж болно гэж үздэг.
  - c. Эрүүгийн эрх зүйн эх сурвалжийг хууль гэж үздэг.
  
4. АНУ-ын хорих байгууллагын төрөл дэглэмийг яаж тогтоодог болохын нэрлэнэ үү.
  - a. Хагас нээлттэй
  - b. Нээлттэй, хаалттай
  - c. Жирийн ба чанга
  
5. Япон улсын эрүүгийн ялын төрлүүдийг нэрлэнэ үү.
  - a. Албадан болон албадан хөдөлмөрлүүлэхгүйгээр хорих
  - b. Албадан ажил хийлгэх
  - c. Эрх хасах
  
6. Хоригдолтой харьцах наад захын жишиг дүрмийг баталсан конвенц?
  - a. НУТОУ-ын Пактаар
  - b. НҮБ-аас
  - c. Ерөнхий асамблейн
  
7. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцид монгол улс хэдэн онд нэгдэн орсон бэ?
  - a. 2010
  - b. 2000
  - c. 2005

## СЭДЭВ.3.10. МОНГОЛ УЛСЫН ШШГБ ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА, ЭХ СУРВАЛЖ

### (Семинар 2 цаг)

Сэдвийн зорилго: Монгол улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн байгууллага олон улсын байгууллагуудын хамтын ажиллагааны талаар тодорхой мэдлэг эзэмшин, холбогдох эх сурвалжийг ашиглах чадвартай болно.

### Сэдвийн агуулга:

- Монгол улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага ба ОХУ-тай хамтын ажиллагаа
- Монгол улс, ОХУ-ын хооронд иргэний ба эрүүгийн хэргийн талаарх эрх зүйн туслалцааны тухай гэрээний агуулга
- Монгол улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага ба Ази номхон далайн хорих байгууллагуудын хамтын ажиллагаа

### Сэдвийн тойм

ШШГБ түүхэн хөгжлийнхөө олон арван жилд Зөвлөлт холбоот улс болон одоогын Оросын Холбооны улстай хамтын ажиллагаатай найрсаг харилцаатай явж ирсэн. 1960 оноос БНМАУ-ын Нийгмийг аюулаас хамгаалах яамны харьяа засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагуудыг удирдах газраас ОХУ-ын нийслэл Москва хотын ДЯЯамны дээд сургуульд мэргэжилтэй боловсон хүчин хуульчид бэлтгэхээр эхний ээлжинд 5-6 ажилтныг тус сургуульд явуулж байсан түүхэн баримт бий. Эдгээр ажилтнууд 1965 онд сургуулиа төгсөж ирсэн. Энэ цаг үетэй давхцан 1931 онд батлагдсан “Аливаа ялтан хэрэгтнийг засан сайжруулах ажлын тухай” хуулийг шинэчлэх ажил өрнөж байлаа.

Юуны өмнө Москвагийн ДЯЯ-ны дээд сургууль төгссөн хуульчид ЗХУ-ын засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хуулийг орос хэлнээс Монгол хэлэнд хөрвүүлсэн байдаг. Ингэснээр 1966 онд БНМАУ-ын засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн шинэ хууль батлагдсан юм. Энэхүү хууль нь тухайн үеийн ЗХУ-ын засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хуулийн нилээд хэсгийг хуулбарлан авч хэрэгжүүлсэн гэж эрдэмтэн судлаачид үздэг. Энэ бүхнийг дурьдах болсон нь Монгол улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага 1960 он түүнээс ч өмнө ОХУ-тай хамтын ажиллагаатай байсныг харуулж байгаа юм. 1999 оны 4-р сарын 20-ний өдөр Монгол улс, ОХУ-ын хооронд иргэний ба эрүүгийн хэргийн талаарх эрх зүйн туслалцааны тухай гэрээ байгуулсан.

Гэрээнд дараах зүйлүүд тусгагдсан байна.

- Эрх зүйн туслалцаа үзүүлэх даалгавар хүлээж авсан байгууллага нь түүнийг биелүүлэхдээ өөрийн улсын хууль тогтоомжыг мөрдөхөөр заасан байна.



- Даалгавар хүлээж авсан байгууллага түүнийг биелүүлэх газар хугацааг тодорхой тэмдэглэнэ. Хэрэв биелүүлээгүй бол шалтгааныг нь тодорхой бичнэ.
- Эрх зүйн туслалцаа үзүүлэх зардалыг хэлэлцэн тохирогч тал өөрийн нутаг дэвсгэр дээр гарсан зардлыг хариуцна.
- Хэлэлцэн тохирогч талууд харилцан бие биедээ мэдээлэл өгч байна.
- Хэлэлцэн тохирогч талууд холбогдох байгууллагаар баталгаажуулсан орчуулга баримт бичгийн хуулбар нэгэн адил хамаарна.
- Иргэнийг сураггүй алга болсон буюу нас барсанд тооцох асуудлыг иргэний хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж хүсэгч талд мэдээлэнэ.

Монгол улс ОХУ-ын хооронд 1999 онд байгуулсан Гэрээ 80-н зүйлээс бүрдэж байгаа тул үүнтэй холбогдсон баримт материалыг гүнзгийрүүлэн судлах шаардлагатай.

Монгол улс ОХУ болон бусад орны хооронд эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээний ба эрүүгийн хэргийн талаарх эрх зүйн туслалцааны гэрээ байгуулан ажиллаж ирсэн одоо ч энэ харилцаа улам гүнзгийрэн хөгжиж байгаа юм. Үүнд

- Сэжигтэн этгээд шилжүүлэх
- Гэмт этгээдийг шилжүүлэх
- Тэдгээрийг шилжүүлэн өгөх тухай шаардан түр шилжүүлэн өгөх
- Хорих ял шийтгэгдсэн этгээдийг түр шилжүүлэх
- Тэдгээрийн эд зүйлийг шилжүүлэх
- Хорих ял шийтгэгдсэн этгээдийг ял эдлүүлэхээр шилжүүлсэн зэрэг чиглэлээр Монгол улсын Гадаад яам, хууль зүйн яамнаас ОХУ болон бусад улсын хоорондын гэрээгээр зохицуулна.

### **Сэжигтэн этгээдийг шилжүүлэх журмаас:**

ЭБШ ажиллагаа явуулах тухай хүсэлтийг илгээх үед сэжигтэн этгээд цагдан хоригдож байгаа бол түүнийг шилжүүлэх арга хэмжээг хангасан байна. Хэлэлцэн тохирогч талд буцаах арга хэмжээг хангасан байна.

### **Гэмт этгээдийг шилжүүлэх журмаас:**

Хэлэлцэн тохиогч талууд нэг жилээс дээш хугацаагаар хорих буюу өөр хүнд ял оногдуулах хэрэгт ЭБША явуулахаар шилжүүлэх, шилжүүлэн өгөх шаардлага



- Шаардлага өгсөн байгууллагын нэр
- Үйлдсэн гэмт хэргийн тодорхойлолт, хэргийн ангилал
- Учирсан хохирол
- Хэрэв ялтан этгээд ял эдэлсэн бол ял эдэлсэн хугацааг зааж өгнө.

### **Ази номхон далайн хорих байгууллагуудтай хамтын ажиллагааны талаар**

Австрали улсын Сидней хотод төвтэй Ази номхон далайн орнуудын хорин байгууллагын удирдах ажилтны бага хурлыг зохион байгуулах төвтэй 1998 оноос эхлэн хамтын ажиллагаа хэрэгжүүлж Монголын хорих байгууллагын удирдах

ажилтнууд Ази номхон далайн орнуудын хорих байгуулагуудын удирдах ажилтны 18-р бага хурлаас эхлэн төлөөлөгчөөр оролцож өөрийн орны хорих байгуулагын тухай болон тулгамдаж байгаа асуудал цаашид хэрхэн ажиллах талаар илтгэлээ хэлэлцүүлдэг болсон 2013 онд 32 дугаар бага хуралд оролцох байна.

2010 оноос Өмнөд Солонгос улстай ялтан солилцох гэрээ байгуулах талаар 2 улсын гадаад харилцааны яамны хооронд санамж бичигт гарын үсэг зурсан юм. БНХАУ Монгол улсын хооронд ялтан солилцох гэрээний тухай хэлэлцүүлэгийн хэмжээнд явагдаж байна.





## ХЯНАЛТЫН АСУУЛТ:

1. Монгол улс ОХУ-ын хооронд байгуулсан гэрээнд сэжигтэн болон гэмт этгээдийг шилжүүлэх журам ялтан шилжүүлэх журмаас ялгагдах онцлогуудын талаар харьцуулан авч үзнэ үү.

### Бодлого

МУ-ын иргэн “Б” 2012 оны 08 сарын 02-ны өдөр ОХУ-ын “Р” хотод гэмт хэрэг үйлдсэний улмаас 2012 оны 09 сарын 20-ны өдөр ОХУ-ын “Р” хотын шүүхээр 3 жилийн хорих ялаар шийтгүүлсэн байна. Б нь тус хотын 21 дүгээр Засан хүмүүжүүлэх ангид ялаа эдэлж байгаа бөгөөд “Б”-ын ар гэрийн хүсэлтийг үндэслэж, эх оронд нь буюу Монгол Улсын ял эдлүүлэх байгууллагад шилжүүлэх асуудал гарчээ.

Энэ тохиолдолд:

1. Ялтан Б-г Монгол Улсын ял эдлүүлэх байгууллагад шилжүүлэх эсэх асуудалд эрх зүйн талаас нь дүгнэлт хийнэ үү?

### Сорил

1. Монгол улс ялтан солилцох гэрээг ямар улс оронтой байгуулсан бэ?  
а. БНСАУ(өмнөд)                      б. ОХУ                      в. Тува
2. Монгол улс, ОХУ-ын хооронд эрх зүйн туслалцаа үзүүлэх, иргэний ба эрүүгийн хэргийн талаар эрх зүйн харилцааны гэрээ хэдэн онд батлагдсан бэ?  
а. 1999 онд                              б. 2005 онд                              в. 1966 онд
3. Гэмт этгээдийг ямар тохиолдолд шилжүүлэх вэ?  
а. 1 жилээс дээш хорих ялтай  
б. 6 сарын хорих ялтай  
в. Баривчлах ялтай

## ГУРАВ. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙ ХИЧЭЭЛИЙН ЗААХ АРГА, АРГАЧЛАЛ

### **Ерөнхий шаардалга:**

Лекцийн хичээл: Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр, цаг сэдвийн хүрээнд шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн мэдлэг олгох зорилго бүхий конспект, үзүүлэн тараах материал, техник хэрэгсэл ашиглан “Лектор багш” лекцийг удирдан явуулна.

Семинарын хичээл: Онолын мэдлэгийг гүнзгийрүүлэн судалж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн хичээлийг оюутны бие даасан бүтээлч үйл ажиллагаанд тулгуурлан эзэмшүүлэх зорилгоор харилцан ярилцах, илтгэл бэлдүүлэх, бичлэг зохиомж хийлгэх, судалгаа зохиомж гаргуулах, бие даалтыг шалгах, эх зохиолын тэмдэглэл хийлгэх, заавал унших ном зохиолыг судлуулах, товчлол тэмдэглэл шалгах, бичгийн ажил хийж үнэлгээ өгөх хэлбэрийг өргөн ашиглаж, олныг хамруулж оюутан бүртэй тулж ажиллах, оюутныг өдөөж, шинийг эрэн хайх хүсэл тэмүүллийг нь бадраах замаар дэвшилтэт шинэ хэлбэрийг сонгон хэрэглэж, семинарыг сонирхолтой үр дүнтэй аргаар явуулна.

### **Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн хичээлийн арга зүйд тавигдах шаардлага**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн хичээлийг судлах үндэслэл, хичээлийн зорилго, зорилттой уялдан уг хичээлийг заах арга зүйд дараах шаардлага тавигдана. Үүнд:

- Хичээлийн зорилгыг хангахуйц арга, хэлбэрийг сонгох, тэр нь хичээлийн агуулгад тохирсон байх.
- Шүүхийн шийдвэрийг практикт хэрхэн гүйцэтгэх, түүнд дүн шинжилгээ хийх чадвар суулгах нөхцөл боломжийг хангах.
- Оюутнууд хичээлд жигд, идэвхтэй оролцох боломж, нөхцөлийг бүрдүүлэх.
- Хичээлийн арга зүй нь амьдрал, практикт нийцсэн, шүүхийн практикийг харгалзсан, тунхагласан хэлбэрээс аль болохоор зайлсхийх.

## **1. Хичээлийн оролцооны аргууд**

### **Оюуны довтолгоо**

Оюуны довтолгоо гэдэг нь суралцагчид үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх явдлыг урамшуулах арга юм. Энэ нь оюутан шүүмжлэлээс айхгүйгээр бүтээлч санаа бодож олох, илэрхийлэхийг урамшуулдгаараа ач холбогдолтой. Энэ үед багш оюутнуудыг тухайн асуудлаар аль болох олон төрлийн санааг чадах хэмжээгээрээ гаргахыг хүсч,



бүх санааг самбар юм уу тусгайлан бэлтгэсэн хүснэгт дээр тэдгээрийн буруу зөвийг харгалзахгүйгээр бичнэ.

Хэрэв хариултын явцад жинхэнэ оновчтой хариулт гарч ирэхгүй байвал, түүнийг тодруулан засч болно. Бүх санааг бичиж дуусах хүртэл ямар нэг шүүмжлэлийг багш хийхгүй байх ёстой. Эцэст нь уг санаануудыг шүүмжлэн ярилцаж, төрөлжүүлэн ангилж болно.

### **Ангилах**

Ач холбогдлоор нь ангилах арга нь ойролцоо хувилбаруудын дунд сонголт хийнэ гэсэн үг. Багш оюутнуудад оюуны довтолгоо хийж гаргасан эсвэл урьдчилан бэлдсэн тодорхой тооны жагсаалтыг тараана. Тэдгээрээс хамгийн чухал нэг, эхний тав, бүгдийг нэгээс дуустал нь г.м.–ээр ангилахыг даалгана.

Үүний дараа ангилсан дарааллаа хамгаалах хэсэг, үл зөвшөөрч байгаа хэсэг, бусад оролцогчдын ангилалтын үндсэн дээр дахин ангилах хэсгийг томилж ажиллуулна.

Энэ аргын ач холбогдол нь оюутнууд үзэл бодлоо илэрхийлэх, бусдыг сонсож түүнээс үнэт зүйлийг нь харж чаддаг болно.

### **Жижиг бүлгээр хэлэлцэх**

Хэлэлцэх сэдэв, мөрдөх журам, цаг хугацааг нарийн гаргаж, урьдчилан төлөвлөсөн байна. Бүх хүмүүст үг хэлэх боломж олгох үүднээс бүлгүүдийг тав хүртэл гишүүнтэй зохион байгуулна.

Бүлгүүд дугаар, эсвэл нэртэй байх ба ямар хугацаагаар уг сэдвийг хэлэлцэх, хэн ямар үүрэгтэй оролцох, мөн дарааллын талаар багш тодорхой чиглэл өгнө.

Багшийн зүгээс энэ үед хэн нэгэн оюутан давамгайлах байдлаар биш аль болох нийтийг хамруулах нөхцөл байдал бүрдүүлэх тал дээр анхаарна.

### **Кейс судлах**

Оюутнуудыг шүүгч, өмгөөлөгч, яллагч нарыг төлөөлсөн байдлаар хуваана. Мөн тодорхой шийдэл, үндэслэлийн дагуу жижиг бүлгүүд ч болгож болно.

Кейс нь ихэвчлэн амьдрал дээр болж өнгөрсөн хэрэг байх ба оюутнуудын гаргасан санал дүгнэлтийг сонссоны дараа багш шүүхээс ямар шийдвэрийг юун дээр үндэслэж гаргасныг тайлбарлаж өгнө.

### **Дүрд тоглох**

Оюутнууд өөрсдийн үзсэн харсан, сонссон дуулсан, сэтгэн бодох чадварт тулгуурлан тодорхой нөхцлийг тоглож үзүүлэх ба багшийн туслалцааг авч болно. Ажиглагч оюутнуудад юуг анхаарах ёстойг сануулна. Тоглолтын дараа ажиглагч оюутнуудаар ямар хэрэг маргаан гарсан, түүнийг хэрхэн шийдвэрлэвэл зохихыг яриулах бөгөөд эцэст нь багш дүгнэж тайлбарлана.

### **Асуулт, хариулт**

Багш асуултыг бэлтгэхдээ тухайн хичээлийн агуулгыг илэрхийлж чадахуйц хэмжээнд хийнэ. Энэ аргыг үр дүнтэй хэрэглэхийн тулд хичээлийн төгсгөлд бүх л шаардлагатай гэсэн асуулт хариултыг тэмдэглэсэн жагсаалт гаргана.

Гол нь багшийн зүгээс аль нэг оюутан бүх л хичээлийн туршид давамгайлсан оролцохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах нь зүйтэй.

### **Дуурайх**

Оюутнууд өгөгдсөн нөхцөлийг уншаад түүнийг амьдруулан тоглоно. Гэхдээ энэ нь хичээлийн сэдэвт нарийн тохирсон байдаг учир дүрд тоглохыг бодвол харьцангуй их цаг шаарддаг.

Багшийн зүгээс дуурайх дасгалыг хийхийн өмнө тодорхой зааварчилгаа, мэдээлэл өгнө.

### **Нээлтэй төгсгөлгүй асуулт**

Оюутнуудад сэдэвтэй холбоотой урьдчилан бэлдсэн дутуу бичилттэй өгүүлбэрүүдийг тараан өгч гүйцээлгэнэ.

Мөн ямар нэг хэрэг учралын газраас авсан зураг г.м.-ийг үзүүлж яриа өрнүүлэн үнэлэлт дүгнэлт өгүүлж болно.

### **Санал асуулга**

Оюутнуудад судалж буй тухайн сэдвийн талаар өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэх боломж олгох зорилготой бөгөөд багшийн зүгээс дараах нөхцлийг бүрдүүлэхэд анхаарна. Үүнд: хэлэлцэх үндсийг бүрдүүлэх, оюутнуудын үнэлэмж, хандлага, итгэл үнэмшлийг өрнүүлэх, эцэст нь үнэлэлт дүгнэлт хийх.

Санал асуулгыг явуулахдаа багш оюутнуудаас тухайн асуудлаар хувийн үзэл бодлоо өөрөө өөрөөсөө асуухыг хүснэ. Жишээ нь: тус бүртээ саналаа бичих. Дараа нь хүн бүрийн саналыг асууж тэдгээрийг харьцуулан харах боломжтой байдлаар самбарт бичнэ. Эцэст нь оюутнуудаас өөрсдийн саналаа хамгаалах, мөн эсрэг санал байж болох эсэх талаар харилцан ярилцана.

### **Илтгэл хэлэлцүүлэх**

Оюутнуудад урьдчилсан байдлаар сэдэв өгч илтгэл бэлдүүлнэ. Мөн шүүмжлэгчийг томилж илтгэл хэлэлцүүлсний дараа саналыг нь сонсох ба бусад оюутнуудаас асуулт тавьж, илтгэгчээс хариулт авах хэлбэрийг ашиглана.

Эцэст нь багшийн зүгээс тодорхой санал дүгнэлт хийнэ.



## **Зогсох**

Энэ нь оюутнуудыг ямар нэгэн маргаантай сэдвийн хүрээнд өөрийн үзэл бодлыг босч зогсон хэлүүлнэ гэсэн үг. Ингэхдээ дэмжинэ, эсрэг, түдгэлзсэн гэсэн бичигний хажууд зогсоно. Энэ үед оюутнуудын үзэл бодол, үндэслэлийг сонсоод зогсохгүй үнэт зүйлийг нь тодруулахыг шаардаж болно.

## **Практик ажилтантай уулзах**

Энэ арга нь амьдрал дээр хууль, эрх зүйг хэрхэн ашиглаж, хэрэглэдэг талаар оюутнуудад маш чухал мэдээлэл өгдөг. Гэхдээ практик ажилтанг зөв сонгох, оюутнуудыг бэлдэх, уулзалтыг дүгнэх зэрэгт анхаарлаа хандуулахгүй бол хичээлийн чанар, үр дүнд сөрөг нөлөө үзүүлдэг гэдгийг мартаж болохгүй.

## **Үнэлэмжит зүйлийг тодруулах**

Энэ арга нь оюутнуудад өөрийнхөө болон бусдын санаа бодол, үзэл баримтлалыг тодруулах, мэдэх боломжийг олгодог. Мөн харилцааны чадварыг сайжруулж, бусдыг сонсох, тэдний санаа бодлыг ойлгох, шийдвэр гаргах дадал олгох, итгэл үнэмшилдээ тууштай байх хандлагыг төлөвшүүлнэ.

# **ДӨРӨВ. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙ ХИЧЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ**

## **1. Үнэлгээний зорилго**

Монгол улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны мөн чанар, зорилт, чиг үүрэг, үе шат, субъектийн онцлогийн талаар болон шийдвэр гүйцэтгэх эрх зүйн үндсэн агуулга, түүнийг хэрэгжүүлэх арга зам, иргэний хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, ял эдлүүлэх ажиллагааны талаар олж авсан онолын мэдлэгээ амьдралд хэрэгжүүлэх чадвартай эсэх, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бичиг баримтуудын эх зохиох, шинэ мэдлэг бүтээж, түүнийгээ амьдралд хэрэгжүүлэх чадвар эзэмшсэн эсэхийг үнэлэхэд чиглэгдэнэ.

Багш үнэлгээг дараах зорилгоор явуулна. Үүнд:

- Сургалтын үр дүнд оюутны мэдлэг, чадвар ямар түвшинд байгааг тодорхойлох;
- Хичээлийн хөтөлбөрийн зарим нэгэн тодорхой сэдвийн сургалтыг давтан судлах шаардлагатай эсэхийг тогтоох;
- Багш өөрөө болон хичээл зорилгодоо хүрсэн эсэхийг үнэлэх.

## **2. Үнэлгээний журам**

Оюутныг үнэлж, дүгнэхдээ доорх үсгэн дүнг хэрэглэнэ.

1. “А” үнэлгээ: Сурлагын дээд амжилтыг илтгэх дүн. Хичээлийн ухагдахуун,

агуулгыг бүрэн дүүрэн ойлгосон, хөтөлбөрт тусгагдсан мэдлэгийг онц сайн эзэмшсэн, бие дааж ном сурах бичиг, эх зохиол унших, нэр томъёог оновчтой зөв хэрэглэх, бодлого, тохиолдлыг зөв шийдвэрлэх, үнэлэлт, дүгнэлт өгөх чадвартай, хичээлд жигд идэвх, санаачлагатай оролцдог, явцын шалгалтад амжилттай дүн үзүүлсэн болон тодорхой сэдвээр илтгэл тавьсан байна.

2. “В” үнэлгээ: Амжилттай суралцсаныг илтгэх дүн. Хичээлийн ухагдахуун, агуулгыг сайн ойлгосон, тэдгээрийн мөн чанарыг зөв тайлбарлах, бодлого, тохиолдол бодох, чадвар эзэмшсэн, семинарын хичээлд байнга идэвхитэй оролцдог, явцын шалгалтанд амжилттай дүн үзүүлсэн.
3. “С” үнэлгээ: Хичээлийн агуулгыг дундаж түвшинд эзэмшсэн байгааг илтгэх дүн. Хичээлийн үндсэн ойлголт, ухагдахууны ихэнхи хэсгийг хангалттай ойлгосон, хялбар бодлого, тохиолдлуудыг шийдвэрлэх чадвартай, семинарын хичээлд идэвхитэй оролцож явцын шалгалтанд хангалттай дүгнэгдсэн.
4. “D” үнэлгээ: Дундаж түвшинээс доогуур амжилтыг илтгэх дүн. Хичээлийн үндсэн ойлголт, ухагдахууныг жигд ойлгоогүй, асуултад бүрэн бус хариулсан, семинарын хичээлд жигд бус оролцож явцын шалгалтанд хамрагдсан, хялбар бодлогыг бодох чадвар эзэмшсэн боловч хариулт нь оновчтой бус байна.
5. “F” үнэлгээ: Мэдлэг чадвар хангалтгүйг илтгэх дүн. Тухайн хичээлийн агуулгыг эзэмшиж чадаагүй, хялбархан асуултанд хариулах, бодлого, тохиолдол шийдвэрлэх чадваргүйг илтгэнэ.

Үсэг, процентоор илэрхийлэгдсэн тоон дүнг дараах жишгээр нэгээс нөгөөд шилжүүлнэ.

Үсгэн дүн	Тоон дүн	Процентон дүн
A	4.0	90-100
B	3.0	80-89
C	2.0	70-79
D	1.0	60-69
F	0	0-59

### Жишиг үнэлгээ:

- Хичээлийн ирц, идэвхи - 20 оноо
- Оюутны бие даалтын ажил -10 оноо
- Улирал дундын шалгалт - 30 оноо
- Улирлын шалгалт - 40 оноо нийт 100 хүртэл оноог цуглуулах боломжтой.



### 3. Үнэлгээний шалгуур

Үнэлэх зүйл Үнэлэх жишиг, шалгуур	
Мэдлэг	<ul style="list-style-type: none"><li>• Асуудлын мөн чанарыг хэрхэн ойлгож, тусгаж байгаа байдал</li><li>• Асуудалд онолын үндэстэй хариулж чадаж байгаа эсэх</li><li>• Мэдлэгээ бусдад түгээх, дамжуулах, тайлбарлах аргаар хүргэж чадаж байгаа эсэх</li><li>• Тухайн судлагдахууны талаар тодорхойлолт гаргах, харьцуулалт хийх, харилцан хамаарал зүй тогтолыг тогтоох арга зүйг эзэмшсэн эсэх</li><li>• Хариулт болон үзэл бодлынхоо үндэслэл, нотолгоог гаргаж байгаа байдал</li></ul>
Чадвар	<ul style="list-style-type: none"><li>• Онолын мэдлэгээ ашиглан асуудлыг тайлбарлан шийдвэр гаргаж чадаж байгаа эсэх</li><li>• Бодлого бодох, аливаа тогтоол шийдвэрүүдийг гүйцэтгэх ажилагаанд үнэлэлт дүгнэлт өгөхдөө онолын мэдлэгээ ашиглаж чадаж байгаа эсэх</li><li>• Бичиг баримт боловсруулах чадварт суралцсан байдал</li><li>• Олж авсан онолын мэдлэгээ практикт хэрэгжүүлэх арга замыг тодорхойлож байгаа байдал, онол практикийн харилцан уялдаа, холбоо, практикт учирч буй бэрхшээлийг шийдвэрлэх арга замыг тодорхойлож байгаа байдал</li><li>• Дүрд тоглох чадвар, арга барилыг эзэмшисэн байх</li><li>• Амаар болон бичгээр өөрийн үзэл бодлыг илэрхийлж буй байдал</li></ul>
Хандлага	<ul style="list-style-type: none"><li>• Өөрийн үзэл бодол, байр суурь, үнэлэлт дүгнэлтээ илэрхийлэхдээ бусдын үзэл бодол, үнэлэлт дүгнэлтэнд хүндэтгэлтэй хандаж түүнээс үнэ цэнэтэй зүйлийг нь мэдлэг хэлбэрээр авч чадаж байгаа эсэх</li><li>• Багаар ажиллах чадвар, өөрөөр хэлбэл багийн гишүүн байх, баг удирдах, бусдыгаа аливаа зүйлд төлөөлөх чадвар</li></ul>

## V ХЭСЭГ. ХАВСРАЛТ

### Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн чиглэлээр бичих курсын ажлын үлгэрчилсэн сэдэв

1. ШШГЭЗ-н шинжлэх ухааны хөгжил
2. Хорих байгууллагын зохион байгуулалт, чиг үүрэг
3. ШШГБ-ын тогтолцоо
4. ШШГБ-ын ажилтны эрх зүйн баталга
5. ШШГЭЗ-н хэм хэмжээ
6. Хорих ялын ойлголт, онцлог
7. Баривчлах ялын ойлголт, онцлог
8. Торгох ялын ойлголт, онцлог
9. Цаазаар авах ялын ойлголт, онцлог
10. Албадан ажил хийлгэх ялын ойлголт, онцлог
11. Эд хөрөнгө хураах ялын ойлголт, онцлог
12. Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял
13. Иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааны онцлог, зарчим
14. Гүйцэтгэх баримт бичиг, гүүний агуулга, бүрдэл
15. Шүүхээс баталгаажуулсан шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагааны онцлог
16. Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хугацаа
17. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал
18. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх үндэслэл, журам, үр дагавар
19. Эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийн гүйцэтгэх ажиллагааны онцлог
20. Албадан дуудлага худалдаа явуулах журам, онцлог
21. Хорих ангийн ойлголт ба ял эдлүүлэх нөхцөл, журам
22. Байгууллага, иргэдээс төлбөр гаргуулах ойлголт, журам
23. Эмнэлэгийн болон хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа



24. Гадаадын зарим улс орнуудын ял эдлүүлэх ажиллагааны онцлог
25. Сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа
26. Хорих ангид ял эдэлж буй ялтнуудын хөдөлмөр эрхлэлт
27. Хорих ангиудад хоригдлыг ангилан хуваарилах, шилжүүлэх ажиллагаа
28. ШШГА-ны талаар гарсан олон улсын баримт бичгийн агуулга, онцлог
29. ШШГЭЗ-н тогтолцоо
30. ШШГЭЗ-н харилцаа
31. ШШГ Ерөнхий Газрын чиг үүрэг
32. Аймгийн шийдвэр гүйцэтгэх албаны эрх хэмжээ, чиг үүрэг
33. Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны эрх хэмжээ, чиг үүрэг
34. ШШГБ-ын хамтын ажиллагаа
35. ШШГА-ны шинэтгэлийн асуудал

### **Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн чиглэлээр бакалаврын диплом бичих үлгэрчилсэн сэдэв:**

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаандаа баримтлах чиглэл, зарчим, тэдгээрийн хэрэгжилтийн байдал
2. Хоригдлын дунд явуулах ерөнхий боловсролын болон мэргэжил эзэмшүүлэх сургалтын ойлголт, эрх зүйн зохицуулалтын уламжилал, шинэчлэлийн асуудал
3. Хоригдлын хөдөлмөр зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалтын уламжлал, шинэчлэл
4. Хоригдолыг шүүхийн магадлалаар хугацаанаас өмнө суллах ойлголт, хууль зүйн үр дагавар
5. Төрийн ялын бодлогын оногдуулалт, хэрэгжилтийн уялдаа (1980-2008)
6. Иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт
7. Шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хамтын ажиллагаа, эрх зүйн зохицуулалт
8. Хоригдолд тавих хяналт, харуул хамгаалалтын зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалт боловсронгуй болгох асуудал
9. Хоригдолд үзүүлэх эмнэлгийн үйлчилгээ, эрх зүйн зохицуулалтын өнөөгийн түвшин, цаашид анхаарах чиглэл

10. Хүний эрхийн үүднээс хоригдлын эрхийг хамгаалахад холбогдсон зарим асуудал
11. Гадаадын зарим орны ял эдлүүлэх эрх зүйн зохицуулалтын онцлог
12. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны эрх зүйн баталгаа, үнэлэмж түүнийг тодорхойлох нь
13. Эрүүгийн ял эдлүүлэх ажиллагаанд тавих прокурорын хяналтын орчин, түүний онцлог
14. Төлбөр төлөгч хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааны эрх зүйн зохицуулалт анхаарах асуудал
15. Хорих ангиас суллагдсан этгээдэд тавих хяналт эрх зүйн зохицуулалт